

Нийтийн эрх ашгийг төлөөлж нэхэмжлэл гаргах эрх: харьцуулсан судалгаа

УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ДЭРГЭДЭХ ШҮҮХИЙН СУРГАЛТ, СУДАЛГАА, МЭДЭЭЛЛИЙН АКАДЕМИ*

- I. Удиртгал
- II. Эх газрын эрх зүйн бүлийн улсууд
 1. Бүгд Найрамдах Франц Улс
 2. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
 3. Бүгд Найрамдах Португал Улс
 4. Испанийн Хаант Улс
 5. Япон Улс
- III. Англо-Саксоны эрх зүйн бүлийн улсууд
 1. Америкийн Нэгдсэн Улс
 2. Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс
 3. Бүгд Найрамдах Энэтхэг Улс
- IV. Социалист эрх зүйн бүлийн улс
 1. Бүгд Найрамдах Хятад Ард Улс
- V. Дүгнэлт

* Энэхүү судалгааг Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн Шүүхийн судалгааны төвийн дарга, хууль зүйн доктор Б.Дөлгөөн (Ph.D) удирдаж, Захиргааны эрх зүйн секторын эрхлэгч Н.Хулан (LL.M), секторын судлаач М.Ананд, П.Чинунар, Л.Энхсайхан, Л.Жавхлант, Иргэний эрх зүйн секторын судлаач С.Юмжирдулам, Г.Амаржаргал, Эрүүгийн эрх зүйн секторын эрхлэгч Э.Баасанбямба, секторын судлаач Б.Оюунзаяа нар 2025 оны 11 дүгээр сард хийж гүйцэтгэлээ.



Хураангуй: Энэхүү судалгаагаар зарим гадаад улсуудын нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах тогтолцоо, эрх зүйн зохицуулалт, түүний онцлог болон ялгаатай байдал, хэрэгжилтийн хэлбэрийг авч үзсэн болно. Судалгаанд уг эрхийн зохицуулалтыг эрх зүйн уламжлал, шүүхийн хяналтын хэлбэрийн ялгаанд тулгуурлан эх газрын эрх зүйн бүлд хамаарах Бүгд Найрамдах Франц Улс (цаашид "Франц Улс" гэх), Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (цаашид "ХБНГУ" гэх), Бүгд Найрамдах Португал Улс (цаашид "Португал Улс" гэх), Испанийн Хаант Улс, Япон Улс, англо-саксоны эрх зүйн бүлд хамаарах Америкийн Нэгдсэн Улс (цаашид "АНУ" гэх), Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс (цаашид "ИБУИНХУ" гэх), Бүгд Найрамдах Энэтхэг Улс (цаашид "БНЭУ" гэх), социалист эрх зүйн бүлд хамаарах Бүгд Найрамдах Хятад Ард Улс (цаашид "БНХАУ" гэх)-ын нийт 9 улсын туршлагыг харьцуулан судаллаа.

Судалгаанаас үзэхэд эх газрын эрх зүйн тогтолцоотой улс орнуудад нэхэмжлэл гаргах эрх нь анх хувь хүний субъектив эрхийн хамгаалалтад төвлөрч байсан боловч нийгмийн харилцаа төвөгтэй болж, байгаль орчин, хэрэглэгчийн эрх, нийтийн эрүүл мэнд, соёлын өв зэрэг нийтлэг үнэт зүйлсийг хамгаалах шаардлага нэмэгдэхийн хэрээр нийтийн ашиг сонирхлыг хамгаалах тусгай механизм аажмаар хөгжжээ. Франц Улс болон Португал Улсад иргэн, холбоо, зарим тохиолдолд прокурорт нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрх олгосон илүү өргөн хүрээний тогтолцоо бүрдсэн бол ХБНГУ, Испани Улс болон Япон Улсад энэ эрхийг тодорхой салбарын хууль, тусгай нөхцөлөөр хязгаарлан зохицуулж байна.

Англо-саксоны эрх зүйн бүлд багтах АНУ, ИБУИНХУ, БНЭУ-ын хувьд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах тогтолцоо нь шүүхийн практик, шүүхийн идэвхтэй оролцоонд тулгуурлан хөгжсөн байна. АНУ-д уг тогтолцоо хууль тогтоомжийн түвшинд системтэй зохицуулагдсан бол ИБУИНХУ-д шүүхийн жишиг шийдвэрийн тайлбар давамгайлж, БНЭУ-д Үндсэн хуулийн зарчим болон шүүхийн идэвхтэй тайлбарын үндсэн дээр хөгжсөн онцлогтой байна.

Харин социалист эрх зүйн тогтолцоонд нийтийн ашиг сонирхлыг хамгаалах институт нь иргэний нийгэмд тулгуурлах бус, төр төвтэй зохион байгуулалтад суурилсан шинжтэй байдаг. Судалгаанд хамруулсан БНХАУ-ын хувьд нийтийн ашиг сонирхлыг хамгаалах ажиллагаа нь прокурорын байгууллага болон хуулиар эрх олгогдсон байгууллагын оролцоогоор хэрэгждэг бөгөөд энэ нь төрийн бодлого, нийгмийн тогтвортой байдлыг хангах зорилготой институтийн хэлбэрээр хөгжсөн байна.

Ийнхүү харьцуулсан шинжилгээнээс үзэхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах тогтолцоо нь улс орнуудын эрх зүйн уламжлал, шүүхийн хяналтын хэлбэрээс хамааран өөр өөр хэлбэрээр хөгжсөн боловч нийтлэг зорилго нь нийтийн эрх ашиг, шударга ёсыг хамгаалах шүүхийн хяналтын механизмыг өргөжүүлэхэд чиглэж байна.

Түлхүүр үг

Нийтийн ашиг сонирхол, бүлгийн ашиг сонирхол, төлөөллийн нэхэмжлэл, нэхэмжлэл гаргах эрх, ашиг сонирхлын шалгуур, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх, байгаль орчны маргаан, хэрэглэгчийн эрх.



I. УДИРТГАЛ

Энэхүү судалгаанд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлах зорилгоор эрх зүйн онцлог, шүүхийн хяналтын тогтолцоо, институтийн хөгжлийн түвшинг харгалзан АНУ, Франц улс, БНХАУ, ИБУИНХУ, ХБНГУ, Япон Улс, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрх зүйн орчны хувьд харьцангуй жишиг болон хөгжиж буй БНЭУ, Португал Улс, Испани Улсыг сонгон авч үзлээ.

БНЭУ, Португал Улс, Испани Улсын хувьд нийтийн ашиг сонирхлын нэхэмжлэл нь шүүхийн идэвхтэй оролцоогоор хөгжиж, иргэд болон байгууллагууд нийгмийн эмзэг бүлгийн эрх ашгийг хамгаалах, байгаль орчныг хамгаалах, нийгмийн шударга ёсыг хангах зорилгоор нэхэмжлэл гаргах боломжийг бүрдүүлсэн байна. Тухайлбал Португал Улсад ардчилсан Үндсэн хуулийн хүрээнд хүний эрх, нийтийн эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалахад иргэний нийгмийн оролцоог дэмжсэн хүчирхэг эрх зүйн тогтолцоотой. Харин БНЭУ-д нийтийн ашиг сонирхлын нэхэмжлэл нь шүүхийн идэвхтэй оролцоогоор хөгжиж, иргэд болон байгууллагууд нийгмийн эмзэг бүлгийн эрх ашгийг хамгаалах, байгаль орчныг хамгаалах, нийгмийн шударга ёсыг хангах зорилгоор нэхэмжлэл гаргах боломжийг шүүх жишиг шийдвэрээр бүрдүүлсэн байна.

Дээрх үндэслэлүүдээр судалгааны багийн зүгээс дээрх 9 улсыг Эх газрын эрх зүйн бүл (англ. civil law, continental law), Социалист эрх зүйн бүл (англ. socialist law), Англо-Саксоны эрх зүйн бүл (англ. common law)-ээр бүлэг болгон авч үзэн, харьцуулан судаллаа.

II. ЭХ ГАЗРЫН ЭРХ ЗҮЙН БҮЛИЙН УЛСУУД

1. БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛС

1.1. Онолын үндэслэл, эрх зүйн тогтолцоо

Франц Улсын Үндсэн хуульд нийтийн ашиг сонирхол (фр. *l'intérêt général*) гэх ойлголтыг үгчлэн тусгаагүй ч Үндсэн хуулийн Зөвлөл (фр. *Le Conseil constitutionnel*) энэ ойлголтыг хуулийн хүчин төгөлдөр байдлыг шалгах нэг үзүүлэлт (фр. *condition de constitutionnalité*) болгон ашигладаг. Өөрөөр хэлбэл, хууль нь нийтийн ашиг сонирхолд нийцсэн бол Үндсэн хуулийг зөрчөөгүй харин хувь хүний ашиг сонирхолд үйлчилбэл Үндсэн хууль зөрчсөн гэж үздэг байна. Иймд Үндсэн хуулийн түвшинд нийтийн ашиг сонирхол нь хууль тогтоогчийн эрх мэдлийг хэрэгжүүлэхэд баримтлах үзэл суртлын болон эрх зүйн суурь бөгөөд хүний эрхийг хязгаарлах хууль ёсны үндэслэл болдог¹.

Францын эрх зүйн онолд нийтийн ашиг сонирхлыг хууль зүйн хувьд нарийн тодорхойлох боломжгүй, харин нийгмийн хөгжлийг дагаад хувьсан өөрчлөгддөг

¹ Merland, Guillaume. «*L'intérêt général, instrument efficace de protection des droits fondamentaux?*» Cahiers du Conseil constitutionnel 16 (2004), <https://www.conseil-constitutionnel.fr/nouveaux-cahiers-du-conseil-constitutionnel/l-interet-general-instrument-efficace-de-protection-des-droits-fondamentaux#:~:text=L%27int%C3%A9r%C3%AAt%20g%C3%A9n%C3%A9ral%2C%20instrument%20efficace%20de,principe%20dont%20la%20constitutionnalit%C3%A9>, (Сүүлд үзсэн: 2025.10.22).



уян хатан ойлголт гэж үздэг байна. Судлаачид үүнийг нарийвчлан тодорхойлох оролдлогоос илүүтэй түүний агуулга, зорилго, үүрэг, хэрэгжилтийн хэлбэрийг тайлбарладаг. Тухайлбал, Жоан Риверо (*Jean Rivero*) болон Жоан Валин (*Jean Valine*) нар нийтийн ашиг сонирхлыг захиргааны үйл ажиллагааны зорилго гэж үздэг бөгөөд энэ нь хувийн ашгаас ялгаатай ч нийгмээс тусгаар орших зүйл биш, харин "хүний нийтлэг хэрэгцээний цогц" (фр. *un ensemble de nécessités humaines*) гэж тодорхойлжээ. Уламжлалт байр сууринаас үзвэл эмх журам, аюулгүй байдал зэрэг ашиг сонирхол нь төрийн онцгой чиг үүрэгт хамаардаг бол төрийн үйл ажиллагаанаас гадна нийтийн зорилготой хувийн үйл ажиллагаагаар боловсрол, эрүүл ахуй, нийгмийн хамгаалал зэрэг ашиг сонирхлыг хэрэгжүүлэх боломжтой гэж тайлбарладаг.²

Харин захиргааны эрх зүйн хүрээнд энэ ойлголт нь захиргааны байгууллагын үйл ажиллагааны зорилго бөгөөд хууль ёсны байдлын гол шалгуур болдог.³ Өөрөөр хэлбэл, захиргааны байгууллага нийтийн сайн сайхны төлөө үйл ажиллагаа явуулах үүрэгтэй бөгөөд хэрэв гаргасан шийдвэр нь энэ зорилгод харш байвал түүнийг эрх мэдлээ урвуулсан, хууль бус үйлдэл (фр. *illégalité pour détournement de pouvoir*) гэж үздэг байна. Тухайн улсын эрх зүйн онолд ашиг сонирхол (фр. *l'intérêt*) гэх ойлголт нь хууль зүйн үндсэн хөдөлгүүр бөгөөд төр ба иргэн, нийтийн ба хувийн хүрээний заагийг илэрхийлдэг гол ойлголт гэж үздэг. Энэ хүрээнд ашиг сонирхлыг гурван түвшинд авч үздэг байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1. Франц Улс дахь ашиг сонирхлын ангилал⁴

Хувийн ашиг сонирхол (фр. <i>l'intérêt privé</i>)	зөвхөн тухайн этгээд өөрөө хамгаалдаг
Нийтийн ашиг сонирхол (фр. <i>l'intérêt général</i>)	төрөөс хамгаалагддаг
Бүлгийн ашиг сонирхол (фр. <i>l'intérêt collectif</i>)	дээрх хоёр ангиллын завсарт орших, тодорхой бүлэг, мэргэжил, нийгмийн хэсгийн ашиг сонирхлыг илэрхийлдэг хосолмол шинжтэй ойлголт

Бүлгийн ашиг сонирхол нь тодорхой бүлгийн гишүүдийн нийтлэг ашиг, нийгмийн тодорхой давхарга буюу мэргэжлийн салбарын ашиг сонирхол (жишээлбэл, үйлдвэрчний эвлэл), зарим тохиолдолд нийгмийн нийтлэг үнэт зүйлсийн илрэл, тухайлбал байгаль орчны хамгаалал, хүний эрх, жендерийн тэгш байдал зэрэг хэлбэрээр илэрдэг байна.⁵

² 박균성, "프랑스 행정법상 공익개념", 서울대학교 법학47(3), (2006), 27, <https://www.kci.go.kr/kciportal/ci/sereArticleSearch/ciSereArtiView.kci?sereArticleSearchBean.artid=ART001258568>, (Сүүлд үзсэн: 2025.10.22).

Park Kyun-sung, "France haengjeongbeobsang gong-iggaenyem", Seouldaehaggyo beobhag 47(3), (2006), 27.

³ Merland, Guillaume, *supra* note 2.

⁴ Intérêt à Agir. «L'intérêt à agir des associations par le contentieux.» <https://www.interetaagir.org/linteret-a-agir-des-associations-par-le-contentieux/#:~:text=French%20law%20has%20been%20built,action%2C%20three%20meanings%20are%20relevant>, (Сүүлд үзсэн: 2025.10.22).

⁵ *Ibid.*



XIX зуунд Франц Улсад иргэний болон эрүүгийн хэрэгт зөвхөн өөрийн эрх ашиг нь шууд хөндөгдсөн этгээд л шүүхэд хандах эрхтэй гэж үздэг байв. Харин нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үүргийг төр дангаараа хэрэгжүүлж, "actio popularis" буюу "нийтийн нэрийн өмнөөс хэн ч хамаагүй нэхэмжлэл гаргах" хэлбэрийг хориглодог байжээ. XX зууны эхэн үеэс хувийн ба нийтийн ашиг сонирхлын дунд орших бүлгийн ашиг сонирхлын ойлголт эрх зүйн онол ба шүүхийн практикт хүчтэй хөгжиж эхэлсэн байна.

Эхэн үедээ ийм төрлийн нэхэмжлэл гаргах эрх нь зөвхөн хуульд тусгайлан зөвшөөрөгдсөн этгээдүүдэд⁶ (захиргааны байгууллага, үйлдвэрчний эвлэл, холбоо) хамаарч байсан бол, Захиргааны дээд шүүх (фр. *Le Conseil d'État*)-ийн шийдвэрүүдийн нөлөөгөөр энэ хүрээ аажмаар тэлжээ. Ингэснээр холбоо, эвслүүд өөрийн зорилго, үйл ажиллагааны хүрээнд бүлгийн ашиг сонирхлыг хамгаалан шүүхэд хандах эрхтэй гэж үзэх болсон нь эрх зүйн хувьд томоохон дэвшил болсон байна. Үүний нөлөөгөөр Франц Улсын шүүхийн тогтолцоонд хувь хүний эрх ашгаас гадна бүлгийн болон нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах зохицуулалт тодорхой хэмжээнд хөгжсөн боловч, энэ хандлага цөөнгүй маргаан, шүүмжлэлийг дагуулдаг ажээ.

Энэ нь нэг талаас шүүхэд "ашиг сонирхлын шалгуур" (фр. *l'intérêt à agir*)-ыг уян хатан тайлбарласнаар байгаль орчныг хамгаалах байгууллага, олон нийтийн холбоодын нэхэмжлэлийг өргөнөөр хүлээн зөвшөөрөх нь захиргааны шүүхийн ачааллыг нэмэгдүүлэх, мөн нийтийн төслүүд, дэд бүтцийн хөтөлбөрүүдийг хэт удаашруулах эрсдэлтэй гэж үздэг.⁷ Нөгөө талаас ашиг сонирхлын хэт нарийн шалгуур тавих нь нийтийн ашиг сонирхлыг хамгаалах боломжийг хумих сөрөг үр дагавартай гэж үздэг байна. Ялангуяа байгаль орчны маргаанд хувь хүн өөрийн "хууль ёсны эрх" зөрчигдсэнийг нотлоход хүндрэлтэй тул нийгмийн нийтлэг ашиг сонирхол хөндөгдөж байгаа боловч шүүхэд маргаан үүсгэх этгээд тодорхойгүй үлдэх тохиолдол элбэг байдаг. Үүнтэй холбоотойгоор Европын холбоо нь Аархусын конвенц (англ. *Aarhus Convention*)⁸-д нийцүүлэн байгаль орчны асуудлаар шүүхэд хандах эрхийг өргөтгөхийг шаарддаг.⁹

Франц Улсын захиргааны хэргийн шүүхийн тогтолцоо нийтийн ашиг сонирхлыг хамгаалахын тулд нэхэмжлэгчийн ашиг сонирхлыг уян хатан авч үзэхийг зорьдог

⁶ Hauriou, Maurice. «Droits des habitants d'un quartier vis-à-vis un service public concédé et recevabilité d'un recours pour excès de pouvoir formé par un syndicat de quartier.» *Revue Générale du Droit* (2013) <https://www.revuegeneraledudroit.eu/blog/2013/11/20/droits-des-habitants-dun-quartier-vis-a-vis-un-service-public-concede-et-recevabilite-dun-recours-pour-exces-de-pouvoir-forme-par-un-syndicat-de-quartier/>. (Сүүлд үзсэн: 2025.10.22).

⁷ Chevalier Émilie, "Standing before French Administrative Courts and Environmental Protection: Not Specific Enough for an Effective Access to Justice?" *Persona e Amministrazione* 1 (2020), 328, <https://journals.uniurb.it/index.php/persona/article/view/2290>, (Сүүлд үзсэн: 2025.10.22).

⁸ United Nations Economic Commission for Europe (UNECE). *Text of the Convention: Convention on Access to Information, Public Participation in Decision-making and Access to Justice in Environmental Matters (Aarhus Convention)*, <https://unece.org/environment-policy/public-participation/aarhus-convention/text>. (Сүүлд үзсэн: 2025.10.22). Европын Эдийн Засгийн Комисс 1998 оны 06 дугаар сарын 25-ны өдөр "Байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох, зөрчигдсөн эрхийг сэргээх тухай конвенцийг Дани Улсын Аархус хотод баталсан бөгөөд энэхүү конвенцийг "Аархусын конвенц" гэж нэрлэдэг. 2025 оны байдлаар тус конвенцид 48 улс нэгдэн орсон байна.

⁹ *Ibid.*

ч, захиргааны шийдвэр бүрд "шүүхэд хандах"-аас сэргийлэхийн тулд тодорхой хязгаарыг хадгалж иржээ. Шүүхийн тогтсон практикаар нэхэмжлэгчийн эрх ашиг нь шууд (фр. *direct*), тодорхой (фр. *certain*), бөгөөд хууль ёсны (фр. *légitime*) байх ёстой гэж үздэг.¹⁰ Иймд нийтийн ашиг сонирхлын төлөөх бүлгийн ашиг сонирхлын нэхэмжлэл (фр. *action d'intérêt collectif*)-ийн хувьд энэ шалгуур илүү уян хатан хэрэгждэг. Өөрөөр хэлбэл, байгаль орчин, хэрэглэгчийн эрх, нийгмийн эмзэг бүлгийн хамгаалал зэрэг тодорхой салбарт үйл ажиллагаа явуулдаг холбоод, төрийн бус байгууллагууд нэхэмжлэл гаргахдаа шууд хохирол амсаагүй байсан ч тэдгээрийн нийтийн ашигт чиглэсэн зорилго, статусаар нь үндэслэн "нэхэмжлэл гаргах эрхтэй" гэж үзэх болжээ.

1.2. Хууль тогтоомжид тусгагдсан байдал

Өмнөх хэсэгт дурдсанчлан Франц Улсад нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах ойлголт нь манай улсын Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан ойлголтоос өөрөөр буюу бүлгийн ашиг сонирхлын нэхэмжлэлийн хүрээнд хэрэгждэг гэж үзэж болно.

Франц Улс 2014 онд бүлгийн ашиг сонирхлын нэхэмжлэлийг нэвтрүүлэхдээ АНУ-ын загварыг (Судалгааны 2 дахь бүлгийн 1 дэх хэсгээс дэлгэрэнгүй унших боломжтой) шууд хуулбарлахгүй франц хэв шинж (фр. *à la française*)-тэй хэлбэрийг хуульчилсан. Энэ нь Европын Холбооны (цаашид "ЕХ" гэх) Гүйцэтгэх хорооны 2013 оны зөвлөмжийн нөлөөгөөр боловсруулагдсан юм. Тус зөвлөмжөөр гишүүн орнуудад хэрэглэгчийн байгууллагын гаргах нэхэмжлэлийг зөвхөн хориг тавих (англ. *injunction*) шаардлагаар хязгаарлахгүй, хохирлыг гаргуулах (англ. *opt-in*) хэлбэрийг ч хүлээн зөвшөөрөхийг зөвлөсөн байдаг. Үүний үндсэн дээр Франц Улс 2014 оны 3-р сард хоёр шатлалт бүтэц бүхий "бүлгийн ашиг сонирхлын нэхэмжлэл"-ийн тогтолцоог хуульчилжээ.¹¹

2016 онд уг тогтолцоог өргөжүүлж, эхлээд эрүүл мэндийн салбарт¹², улмаар ажлын байрны ялгаварлан гадуурхалтыг хориглох, байгаль орчны болон хувийн нууцын хамгаалалттай холбоотой маргаанд бүлгийн ашиг сонирхлын нэхэмжлэл гаргаж болохоор хуульчилсан байна. Эдгээр зохицуулалт нь "XXI зууны шүүхийн тогтолцоог шинэчлэх тухай хууль" (*Loi n° 2016-1547 du 18 novembre 2016 de modernisation de la justice au XXIe siècle*)¹³-д тусгагдсан байдаг. Бүлгийн ашиг сонирхлын нэхэмжлэл гаргах салбар бүр тус тусын зохицуулалттай байснаас гадна нэхэмжлэл гаргах эрх бүхий байгууллага, хохирлын төрөл, хариуцагчид

¹⁰ Couvreur, Sébastien. « Réflexions sur la notion d'intérêt à agir devant les juridictions administratives. » Krieger & Associés (2017). <https://www.krieger-avocats.lu/blog/blog-detail.html?blogidarticle=366&blogstartmonth=8&blogmonthback=-1>. (Сүүлд үзсэн: 2025.10.22).

¹¹ 2014.03.17-ны өдрийн "Хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль" (*Loi n° 2014-344 du 17 mars 2014 relative à la consommation*) болон 2014.09.24-ний өдрийн "хэрэглэгчийн ашиг сонирхлын нэхэмжлэл"-тэй холбоотой (*Décret n° 2014-1081 du 24 septembre 2014 relatif à l'action de groupe en matière de consommation*) журам хэрэгжиж эхэлжээ.

¹² 2016.01.26-ны өдрийн "Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хууль" (*Loi n° 2016-41 du 26 janvier 2016 de modernisation de notre système de santé*) болон 2016.09.26-ны өдрийн "эрүүл мэндийн салбар дахь бүлгийн ашиг сонирхлын нэхэмжлэл"-д хамаарах асуудлын талаарх журам (*Décret n° 2016-1249 du 26 septembre 2016 relatif à l'action de groupe en matière de santé*)-д тус зохицуулалтыг хуульчилжээ.

¹³ Loi n° 2016-1547 du 18 novembre 2016 de modernisation de la justice au XXIe siècle (2016), <https://www.legifrance.gouv.fr/loda/id/JORFTEXT000033418805>, (Сүүлд үзсэн: 2025.10.20).



ногдуулах шинж чанараараа ялгаатай байв. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль хэрэгжсэнээс хойш арван жилийн хугацаанд нийт 40 орчим бүлгийн ашиг сонирхлын нэхэмжлэл гаргасан бөгөөд ердөө хоёр тохиолдолд анхан шатны шүүхээс хариуцагчид хариуцлага оногдуулах шийдвэр гаргасан байна.¹⁴ Үүний шалтгааныг нэхэмжлэл гаргах урьдчилсан зөвшөөрлийн хэт хатуу шаардлага болон нарийн процедурын хязгаарлалттай холбон үзжээ.

Эдгээр бэрхшээлийг арилгах зорилгоор Франц Улсын Засгийн газар 2024 оны 10 сард хэд хэдэн Европын холбооны удирдамжийг, тэр дундаа (EX) 2020/1828 дугаар "Төлөөллийн нэхэмжлэлийн тухай" удирдамжийг хэрэгжүүлэх талаар хуулийн төслийг парламентад өргөн барьсан. Үүний үр дүнд Франц Улсын парламент 2025 оны 4 дүгээр сарын 30-нд "Эдийн засаг, санхүү, байгаль орчин, эрчим хүч, тээвэр, эрүүл мэнд болон хүн амын хөдөлгөөний асуудлыг Европын Холбооны хуульд нийцүүлэх тухай" 2025-391 дугаар хууль¹⁵ (фр. *Loi n° 2025-391 du 30 avril 2025 portant diverses dispositions d'adaptation au droit de l'Union européenne en matière économique, financière, environnementale, énergétique, de transport, de santé et de circulation des personnes*) (цаашид "2025 оны хууль" гэх)-ийг баталж, тус хуулиар салбар хуулиудын зохицуулалтуудыг нэгтгэн шинэчилжээ. Тухайлбал, Захиргааны шүүхийн хууль (фр. *Code de justice administrative, CJA*), Байгаль орчны хууль¹⁶ (фр. *Code de l'environnement*) зэрэг салбар хуулиудад байсан тусдаа заалтуудыг хүчингүй болгож, бүлгийн ашиг сонирхлын нэхэмжлэлийн нэгдсэн зохицуулалтыг мөрдөж эхэлсэн байна.

¹⁴ A&O Shearman. «Réforme des actions de groupe : ce que change la loi du 30 avril 2025», (2025), <https://www.aoshearman.com/fr-fr/insights/class-action-reform-key-changes-introduced-by-the-law-of-april-30-2025>, (Сүүлд үзсэн: 2025.10.20).

¹⁵ Loi n° 2025-391 du 30 avril 2025 portant diverses dispositions d'adaptation au droit de l'Union européenne en matière économique, financière, environnementale, énergétique, de transport, de santé et de circulation des personnes (J.O. 2 mai 2025), <https://www.legifrance.gouv.fr/loda/id/JORFARTI000051539065#JORFARTI000051539065>, (Сүүлд үзсэн: 2025.10.20).

¹⁶ Code de l'environnement, art. L.142-3-1, https://www.legifrance.gouv.fr/codes/section_lc/LEGITEXT000006074220/LEGISCTA000006143735/#LEGISCTA000019280521, (Сүүлд үзсэн: 2025.10.23).



Хүснэгт 2. Франц Улсын 2025 оны хуульд орсон бүлгийн ашиг сонирхлын нэхэмжлэлд холбогдох хуулийн зохицуулалт

Хуулийн нэр	Хуулийн зохицуулалт
<p>Эдийн засаг, санхүү, байгаль орчин, эрчим хүч, тээвэр, эрүүл мэнд болон хүн амын хөдөлгөөний асуудлыг Европын Холбооны хуульд нийцүүлэх тухай” 2025-391 дугаар хууль</p>	<p style="text-align: center;">III дугаар бүлэг-16 дугаар зүйл¹⁷</p> <p>I.-А.- Бүлгийн ашиг сонирхлын нэхэмжлэлийг энэ хэсгийн С-д заасан нэхэмжлэгчийн зүгээс, ижил төстэй нөхцөл байдалд байгаа хэд хэдэн хувь хүн эсхүл хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, өөрийн мэргэжлийн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх явцад эсхүл түүний хүрээнд үйлдсэн хууль ёсны буюу гэрээний үүргээ зөрчсөн мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг этгээд, эсхүл нийтийн эрх зүйн хуулийн этгээд, эсхүл нийтийн үйлчилгээний удирдлагыг хариуцсан хувийн байгууллагаас үйлдэгдсэн ижил зөрчил эсхүл нэг төрлийн зөрчилтэй холбоотойгоор шүүхэд мэдүүлнэ. Бүлгийн ашиг сонирхлын нэхэмжлэл ийг А-ын эхний хэсэгт заасан зөрчлийг зогсоолгох, эсхүл тухайн зөрчлөөс үүдэн гарсан хохирлыг нөхөн төлүүлэх, эсхүл дээрх хоёр шаардлагын аль алиныг нь хангуулах зорилгоор гаргана.</p> <p>С.-1.- Бүлгийн ашиг сонирхлын нэхэмжлэлийг энэ зорилгоор зөвшөөрөл авсан холбоо гаргана, уг зөвшөөрлийг олгох эрх бүхий захиргааны байгууллага хууль ёсны журмаар байгуулагдсан, ашгийн бус зорилготой, дараах нөхцөлүүдийг хангаж буй аливаа холбоонд олгож болно:</p> <p>1° Зөвшөөрөл хүссэн өдрийн байдлаар, хамгаалагдаж буй ашиг сонирхолд халдсан асуудлаар дараалан арван хоёр сарын хугацаанд бодитоор, ил тод үйл ажиллагаа эрхэлж байсан бөгөөд уг үйл ажиллагаагаа нотолж байх;</p> <p>2° Түүний дүрмийн зорилго нь халдсан ашиг сонирхлыг хамгаалахад чиглэсэн байх;</p> <p>3° Зөвшөөрөл хүссэн өдрийн байдлаар, худалдааны тухай хуулийн VI дэвтэрт заасан (дампуурал, төлбөрийн чадваргүйдлийн) ажиллагаанд ороогүй байх;</p> <p>4° Холбоо нь бие даасан байх бөгөөд өөрийн хамгаалж буй этгээдүүдээс бусад, эдийн засгийн ашиг сонирхол бүхий этгээдүүдийн нөлөөлөлд өртөөгүй байх, энэ төрлийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зохицуулах талаар бичгээр баталсан журамтай байх;</p> <p>5° Холбоо нь өөрийн дүрмийн зорилго, үйл ажиллагаа, гол санхүүжилтийн эх үүсвэр, мөн зохион байгуулалтын бүтцийн талаар олон нийтэд зохих аливаа аргаар мэдээлэл хүргэдэг байх.</p> <p>Зөвшөөрлийг олгох эрх бүхий захиргааны байгууллага, энэ заалтын 1-д дурдсан нөхцөлийн аль нэгийг нь хууль ёсоор хангахаа больсон гэж үзвэл зөвшөөрлийг буцаан хүчингүй болгож болно.</p> <p>Зөвшөөрөл авсан холбоодын жагсаалтыг олон нийтэд тогтоолоор тогтоосон журмын дагуу ил тод байршуулна.</p> <p>Зөвхөн зөрчлийг таслан зогсоох зорилготой бүлгийн ашиг сонирхлын нэхэмжлэлийг хамгийн багадаа хоёр жил дараалан бодитоор, ил тод үйл ажиллагаа эрхэлсэн, ашгийн бус зорилготой, хууль ёсны журмаар бүртгэгдсэн бөгөөд дүрмийн зорилго нь халдсан ашиг сонирхлыг хамгаалахад чиглэсэн холбоо мөн гаргаж болно.</p> <p>Бүлгийн ашиг сонирхлын нэхэмжлэлийг дараах төлөөллийн үйлдвэрчний эвлэлүүд (Хөдөлмөрийн хуулийн L.2122-1, L.2122-5, L.2122-9 дүгээр зүйлүүд, эсхүл Төрийн албаны ерөнхий хуулийн L.221-1 дүгээр зүйлд заасан утгаар), мөн шүүхийн байгууллагын шүүгчдийн төлөөллийн үйлдвэрчний эвлэлүүд дараах тохиолдолд гаргаж болно:</p> <p>а) Ялгаварлан гадуурхалтын эсрэг тэмцэх асуудлаар;</p> <p>б) Хувийн мэдээллийг хамгаалах асуудлаар;</p> <p>с) Ажил олгогчийн зөрчилтэй холбоотойгоор, түүний эрх мэдэл дор ажиллаж буй хэд хэдэн хүний эрхэд зөрчил учирсан тохиолдолд тухайн зөрчлийг зогсоолгох, эсхүл уг зөрчлөөс үүдэн бий болсон хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор.</p> <p>V. Бүлгийн ашиг сонирхлын нэхэмжлэлийг тухайн маргааныг шийдвэрлэх эрх бүхий шүүхийн журмын дагуу хянан шийдвэрлүүлнэ.</p> <p>VI. Шүүхийн тухай хуулийн L.211-15 дугаар зүйлийг дараах агуулгаар шинээр сэргээв:</p> <p>«L.211-15 дугаар зүйл. – Тусгайлан байгуулагдсан анхан шатны шүүхүүд нь Эдийн засаг, санхүү, байгаль орчин, эрчим хүч, тээвэр, эрүүл мэнд болон хүн амын хөдөлгөөний асуудлыг Европын Холбооны хуульд нийцүүлэх 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 2025-391 дүгээр хуулийн 16 дугаар зүйлд тулгуурлан гаргасан бүлгийн ашиг сонирхлын нэхэмжлэлийн хэргүүдийг хянан шийдвэрлэнэ.»</p>

¹⁷ Supra note 14.



Дээрх хуулиас гадна Байгаль орчны хуулийн 142-1 дүгээр зүйлд байгаль орчныг хамгаалах зорилготой холбоо нь энэ зорилгоо биелүүлэхийн тулд захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах боломжтой гэж хуульчилжээ.

Хүснэгт 3. Франц Улсын байгаль орчны холбогдох хуулийн зохицуулалт

Хуулийн нэр	Хуулийн зохицуулалт
Франц Улсын байгаль орчны хууль	<p>L142-1-р зүйл¹⁸</p> <p>Байгаль, хүрээлэн буй орчныг хамгаалахаар зорилгоо тодорхойлсон аливаа холбоо нь энэ зорилготой холбогдох аливаа зөрчил, гомдлын талаар захиргааны шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.</p> <p>Байгаль орчны хуулийн L141-1 зүйлийн дагуу зөвшөөрөл авсан байгаль орчныг хамгаалах холбоо, мужуудын холбоод, усны экосистемийг хамгаалах, мэргэжлийн загасчдын холбоод нь өөрийн зорилго болон дүрмийн хүрээнд хамаарах, байгаль орчинд хохирол учруулж болзошгүй аливаа захиргааны шийдвэрийн эсрэг нэхэмжлэл гаргах хууль ёсны ашиг сонирхолтой гэж тооцогдоно. Энэхүү эрх нь зөвшөөрөл авсан огнооноос хойш гарсан захиргааны шийдвэрүүдэд хамаарна.</p>

2025 оны хуулийг баталснаар бүлгийн ашиг сонирхлын нэхэмжлэлийн тогтолцоог нэгтгэн шинэчилж, ЕХ-ны хандлагатай нийцүүлэн нийтийн ашиг сонирхлыг хамгаалах илүү уян хатан механизмыг бий болгосон гэж үзэж болохоор байна.

Нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээд

Франц Улсын захиргааны эрх зүйд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд хандах эрх бүхий субъектүүдийг дараах байдлаар ангилж болно. Энэ талаар дээр авч үзсэн 2025 оны хуулийн 16-р зүйлд хуульчилсан байна. Ерөнхийд нь авч үзвэл:

1. Прокурор (фр. ministère public): 2014 оны хэрэглэгчийн эрхийг хамгаалах хуулиар прокурор бүлгийн ашиг сонирхлын нэхэмжлэлд туслах журмаар оролцох (оролцогч тал болж санал гаргах) эрхтэй байсан бол 2025 оны хуулиар бие даан бүлгийн ашиг сонирхлын нэхэмжлэгч болох эрхийг нэмж өгсөн.
2. Төрийн төлөөлөгч (фр. Préfet): Төрийн төлөөлөгч нь орон нутгийн өөрөө удирдах байгууллагад хууль ёсны хяналт (фр. déferé préfectoral) хэрэгжүүлдэг бөгөөд Франц Улсын Орон нутгийн өөрөө удирдах байгууллагын ерөнхий хууль (фр. Code général des collectivités territoriales, CGCT)-ийн дагуу тухайн муж (фр. département)-ийн төлөөлөгч нь орон нутгийн байгууллагын шийдвэрийг хууль зөрчсөн гэж үзвэл хоёр сарын дотор захиргааны шүүхэд нэхэмжлэл гарган хүчингүй болгуулах эрхтэй. Энэхүү хууль ёсны хяналт нь 1982 оны нутгийн засаг захиргааны шинэчлэлээр бий болсон төрийн хяналтын механизм бөгөөд жил бүр 800–1500 орчим удаа хэрэгждэг. Жишээлбэл

¹⁸ Code de l'environnement, art. L142-1, https://www.legifrance.gouv.fr/codes/texte_lc/LEGITEXT000006074220/2025-10-23, (Сүүлд үзсэн: 2025.10.23).



2024 онд төлөөлөгчдөөс нийт 838 актын эсрэг нэхэмжлэл гаргаснаас 268 тохиолдолд түр түдгэлзүүлэх арга хэмжээ (фр. *référé-suspension*) хүссэн бөгөөд эдгээрийн 195 нь орон нутгийн байгууллага өөрөө маргаан бүхий актыг хүчингүй болгосноор хэрэг хэрэгсэхгүй болж, үлдсэн маргааны 77%-ийг төлөөлөгчийн талд шийдвэрлэжээ.¹⁹

3. Төрийн бус байгууллага, холбоо, эвсэл: Дээр дурдсанчлан, хэрэглэгчийн эрх, байгаль орчин, мэдээлэл хамгаалал, ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх зэрэг тодорхой чиглэл бүхий холбоод бүлгийн ашиг сонирхлын нэхэмжлэл гаргах эрхтэй. Ихэнх тохиолдолд эдгээр холбоо нь төрийн захиргааны байгууллагад бүртгэгдэн, "зорилго нь нийтийн ашиг сонирхол" гэж хүлээн зөвшөөрөгдсөн байх шаардлагыг хангасан байх шаардлагатай. Шинэ хуулиар (2025) энэ байдлыг өөрчилж, тодорхой шалгуурыг хангасан илүү олон холбоодод зөвшөөрөл олгохоор болжээ. Тухайлбал, "ашиг олох зорилгогүйгээр эвлэлдэн нэгдсэн, бие даасан, 24 сараас дээш хугацаанд үйл ажиллагаа явуулсан, дүрмийн зорилго нь хамгаалж буй ашиг сонирхолтой нь нийцэх" холбоо байвал Хууль зүйн яаманд хүсэлт гарган албан ёсны зөвшөөрөл авч, бүлгийн ашиг сонирхлын нэхэмжлэл гаргах субъект болж болно. Эдгээр шалгуур нь ЕХ-ны Гүйцэтгэх хорооны зөвлөмжид тусгасан "эрх бүхий байгууллагад тавих шаардлагуудтай" адилхан гэдгийг хууль тогтоогч онцолсон байна.
4. Бүртгэлтэй боловч зөвшөөрөлгүй холбоо: 2025 оны хуулиар шинээр оруулсан заалтаар, албан ёсны зөвшөөрөлгүй боловч хоёр жилээс дээш хугацаанд бодит үйл ажиллагаа явуулсан, дүрмийн зорилго нь холбогдох ашиг сонирхлыг хамгаалахад чиглэсэн холбоо нь **зөрчил таслан зогсоох зорилгоор** бүлгийн ашиг сонирхлын нэхэмжлэл гаргахыг зөвшөөрчээ. Гэвч эдгээр **холбоод нөхөн төлбөр шаардах эрхгүй**, зөвхөн зөрчил таслан зогсоох хүрээнд нэхэмжлэл гаргах боломжтой. Энэ нь "хагас эрхтэй" холбоодын оролцоог нэмэгдүүлж байгаа ч зарим шинжээчдийн үзэж буйгаар шүүхийн практикт тэдний нөлөөг хязгаарлаж болзошгүй гэж үзэх хандлага байна.²⁰
5. Гадаадын байгууллага: 2025 оны хуулиар Европын Холбооны бусад гишүүн орны эрх бүхий байгууллагууд Франц Улсад нэхэмжлэл гаргаж болно. ЕХ-ны Гүйцэтгэх хорооны 2020 оны зөвлөмжийн дагуу бусад орны байгууллага, холбоо нь Франц Улсын холбогдох төрийн байгууллагад бүртгүүлэн төлөөлөх байгууллагын эрх авснаар хил дамнасан бүлгийн ашиг сонирхлын нэхэмжлэл гаргах боломжтой болсон байна.²¹

2025 оны хуулиар бүлгийн ашиг сонирхлын нэхэмжлэл гаргах субъектийн хүрээ эрс тэлж, төрийн болон төрийн бус, дотоодын болон гадаадын байгууллагуудыг хамруулснаар Франц Улсад нийтийн ашиг сонирхлыг төлөөллийн тогтолцоог институтын түвшинд бүрэн бүрдүүлсэн гэж үзэж болохоор байна.

¹⁹ «Des contrôles de légalité et budgétaire annoncés prioritaires: comment passer de la parole aux actes (Rapport d'information n° 843 2024-2025). » Sénat – Rapports officiels (2024). [²⁰ A&O Shearman, *supra* note 15.](https://www.senat.fr/rap/r24-843/r24-8432.html#:~:text=2024%2C%20838%20d%C3%A9f%C3%A9r%C3%A9s%20ont%20%C3%A9t%C3%A9,observ%C3%A9e%20depuis%20une%20dizaine%20d%27ann%C3%A9es,_(Сүүлд үзсэн: 2025.10.23).</p></div><div data-bbox=)

²¹ A&O Shearman, *supra* note 15.



1.3. Шүүхийн практик

Франц Улсын нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн захиргааны шүүхэд нэхэмжлэл гаргах тогтолцооны хөгжилд чухал нөлөө үзүүлсэн олон шийдвэр байна. Эдгээрээс жишээ дурдвал:

Шигтгээ 1. Франц Улсын бүлгийн ашиг сонирхлыг хамгаалах асуудлаарх анхны шүүхийн шийдвэр

Эм үйлдвэрлэгч Санофи компанид холбогдуулан Франц Улсын Таталтын эсрэг эмийн хам шинжтэй хүүхдийн эцэг эхчүүдэд туслах холбоо (APESAC)-оос гаргасан бүлгийн ашиг сонирхлын нэхэмжлэлтэй хэрэг²²

Францын эмийн компани "Санофи" (Sanofi)-оос Депакин (Dépakine) гэх нэртэй эмийг олон жил үйлдвэрлэн худалдаалсан байна. Эпилепсийн²³ эсрэг "Dépakine" эмийг жирэмсний үед хэрэглэх нь ургийн гаж хөгжил үүсгэдэг болох нь тогтоогдсоны дараа, 2011 онд хохирогч гэр бүлүүд нэгдэн "APESAC" буюу Таталтын эсрэг эмийн хам шинжтэй хүүхдийн эцэг эхчүүдэд туслах холбоо (Association d'aide aux Parents d'Enfants souffrant du Syndrome de l'Anti-Convulsivant)-г байгуулжээ. 2016 онд эрүүл мэндийн салбарт бүлгийн ашиг сонирхлын нэхэмжлэл гаргах боломжтой болсноор тус холбоо 2017 оны 5-р сард Санофи компанийн эсрэг нэхэмжлэл гаргасан байна. Нэхэмжлэлд компанийн зүгээс эмийн гаж нөлөөг 1980-аад оноос мэдсээр байсан ч зохих анхааруулга өгөөгүй, зах зээлээс таталгүй борлуулсан гэж үзжээ.

Эмийн гаж нөлөөг мэдээгүйн улмаас уг эмийг уусан жирэмсэн эхчүүдийн урагт нөлөөлж бие махбодын гажиг, зүрх судасны эмгэг, мэдрэлийн хөгжлийн эмгэг (хэл ярианы саатал, аутизм гэх мэт)-тэй хүүхдүүд төрсөн байна.

2022 оны 1-р сарын 5-нд Парисын шүүх Санофи компанийг "сэрэмжлүүлэх, мэдээлэл өгөх үүргээ биелүүлээгүй" буруутай гэж үзэж, APESAC-ийн нэхэмжлэлийг "хүлээн авах үндэслэлтэй" гэж тогтоон, гурван гэр бүлийн жишээгээр нийт 450,000 еврогийн нөхөн төлбөр олгохыг үүрэг болгожээ.

Түүнчлэн Dépakine-ийн асуудлаар хохирогчид Санофигаас нөхөн төлбөр шаардахаас гадна улсын эмийн хяналтын агентлаг (ANSM)-ийн эсрэг захиргааны шүүхэд нэхэмжлэл гаргасан. Парисын захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс (La Cour administrative d'appel de Paris)-ээс 2025 оны 01 дүгээр сарын 14-нд жирэмсний үед Депакин эмийг хэрэглэсэн эхчүүдийн хүүхдүүдэд учирсан аймшигт хохирлыг нөхөн төлөхийг төрд үүрэг болгож шийдвэрлэжээ.²⁴

²² Le Monde. «Dépakine: Sanofi condamné à indemniser une famille dont la fille est née avec des malformations.» Le Monde, 14 mai 2022. https://www.lemonde.fr/sante/article/2022/05/14/depakine-sanofi-condamne-a-indemniser-une-famille-dont-la-fille-est-nee-avec-des-malformations_6126086_1651302.html#:~:text=D%C3%A9pakine%20%3A%20Sanofi%20condamn%C3%A9%20%3A0,de%20450%20000%20euros, (Сүүлд үзсэн: 2025.10.23).

²³ Эпилепс (англ. epilepsy) гэдэг нь тархины мэдрэлийн эсүүдийн хэвийн бус цахилгаан идэвхжилээс үүдэлтэй архаг өвчин юм. Энэ өвчний гол шинж нь таталт өгөх, унах, ухаан алдах, бие хэсэгчлэн эсхүл бүтэн хөших зэрэг байдлаар илэрдэг.

²⁴ Le Club des juristes. « Affaire de la Dépakine : quelle est la responsabilité de l'État ? » *Le Club des juristes* (2025). *Affaire de la Dépakine : quelle est la responsabilité de l'Etat ? – Le Club des Juristes*, (Сүүлд үзсэн: 2025.10.23).



Шигтгээ 2. Франц Улсын захиргааны хэргийн шүүхээс нийтийн эрх ашгийг төлөөлөн нэхэмжлэл гаргах боломжтой болохыг хүлээн зөвшөөрсөн шүүхийн шийдвэр

Касанова (Casanova)-ийн нэхэмжлэлтэй Бордо хотын захиргаа (le mairie de Bordeaux)-д холбогдох хэрэг

(Франц Улсын Захиргааны дээд шүүхийн 1901.03.29-ний өдрийн шийдвэр)²⁵

Энэ хэрэгт нэгэн жижиг суманд шинэ эмч ажиллуулах тухай сумын зөвлөлийн шийдвэрийг тухайн сумын татвар төлөгч иргэн Касановагийн гаргасан нэхэмжлэлийн дагуу Захиргааны дээд шүүх хэлэлцжээ. Тухайн үед иргэдэд ийм төрлийн нэхэмжлэл гаргах талаар тодорхой хууль зүйн үндэслэл байгаагүй боловч шүүх "сумын төсөвт нэмэлт зардал үүсгэх аливаа шийдвэр нь тухайн сумын татвар төлөгч бүрийн хууль ёсны ашиг сонирхолд нөлөөлнө" гэж үзэн Касановаг нэхэмжлэх эрхтэй хэмээн хүлээн зөвшөөрчээ.

Улмаар шүүхээс эмч ажиллуулах тухай шийдвэрийг төсвийн хувьд үндэслэлгүй, нийтийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан гэж дүгнэн хүчингүй болгосон байна. Энэхүү шийдвэр нь анх удаа орон нутгийн санхүүгийн ашиг сонирхлыг татвар төлөгч иргэн төлөөлөн хамгаалах эрх зүйн үндсийг тогтоосон бөгөөд үүнээс хойш "орон нутгийн татвар төлөгчийн нэхэмжлэл" гэх ойлголт Франц Улсын захиргааны эрх зүйд нийтлэг зарчим болон төлөвшжээ. Үүний үр дүнд, үндэсний хэмжээний татварын бодлого зэрэг бүх нийтийн шинжтэй асуудлаар иргэн бүр нэхэмжлэл гаргах боломжгүй хэвээр ч, нутаг дэвсгэрийн хэмжээнд татвар төлж буй иргэн тухайн орон нутгийн төсөв, шийдвэрийн хууль ёсны байдлыг шүүхийн хяналтад өгөх эрхтэй болсон байна.

2. Лиможийн үсчний ажил олгогчдын холбоо (Syndicat des patrons coiffeurs de Limoges)-ны нэхэмжлэлтэй Хаут-Вьенн мужийн захирагч (le Préfet du département de la Haute Vienne)-д холбогдох хэрэг

(Франц Улсын Захиргааны дээд шүүхийн 1906.12.28-ны өдрийн шийдвэр)²⁶

Энэ хэрэг нь мэргэжлийн холбоо, эвлэлүүд бүлгийн эрх ашгаа хамгаалан шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй болохыг анх удаа албан ёсоор баталгаажуулсан түүхэн шийдвэр юм. Лимож хотын үсчний ажил олгогчдын холбоо нь хотын захиргаанаас гаргасан амралтын өдөр ажиллахыг хориглосон шийдвэрийг эсэргүүцэн нэхэмжлэл гаргажээ. Шүүх тус холбооны дүрэмд гишүүдийнх нь ажил мэргэжлийн ашиг сонирхол, хөдөлмөр эрхлэх эрхийг хамгаалах зорилго тодорхой тусгагдсан байсан тул уг шийдвэр нь холбооны бүлгийн эрх ашигт нөлөөлж байна гэж үзэж, нэхэмжлэлийг хүлээн авч хэлэлцсэн байна. Энэхүү 1906 оны шийдвэрээр анх удаа хуулийн этгээд (мэргэжлийн холбоо) нь гишүүдийнхээ нийтлэг ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргаж болохыг Захиргааны дээд шүүх хүлээн зөвшөөрсөн юм. Үүнээс өмнө гарсан 1906 оны Товли дүүргийн оршиг суугчдын холбоо (Croix-de-Seguey-Tivoli)-нд ижил боломж олгосон бөгөөд Лимож хотын үсчний ажил олгогчдын холбооны хэрэг нь уг зарчмыг баталгаажуулсан чухал алхам болсон гэж үздэг.

Ийнхүү XX зууны эхээр Захиргааны дээд шүүхийн хэд хэдэн шийдвэрээр захиргааны хяналтын хүрээ өргөжиж, зөвхөн шууд хохирогч бус бүлгийн ашиг сонирхлыг төлөөлөгч этгээдүүдэд нэхэмжлэл гаргах эрх хүлээн зөвшөөрөгдөж эхэлсэн байна.

²⁵ Conseil d'État. «Syndicat des propriétaires et contribuables du quartier Croix-de-Seguey-Tivoli (21 décembre 1906, n° 19167).» Conseil d'État — Décisions de justice (Recueil Lebon). <https://www.conseil-etat.fr/decisions-de-justice/jurisprudence/les-grandes-decisions-depuis-1873/conseil-d-etat-21-decembre-1906-syndicat-des-proprietaires-et-contribuables-du-quartier-croix-de-seguey-tivoli>, (Сүүлд үзсэн: 2025.10.23).

²⁶ Ibid.



3. Хүний эрхийн холбоо (Ligue des droits de l'Homme, LDH)-ийн нэхэмжлэлтэй Мадалейн хотын захиргаа (mairie de La Madeleine)-д холбогдох хэрэг

(Франц Улсын Захиргааны дээд шүүхийн 2015.11.04-ний өдрийн шийдвэр)²⁷

Энэ хэрэг нь Франц улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг хүний эрхийн байгууллага орон нутгийн захиргааны шийдвэрийг нийтийн эрх ашигт хамаарах үндэсний асуудал гэж үзэн нэхэмжлэл гаргасан тохиолдол байв.

Франц Улсын хойд нутгийн нэгэн жижиг хотын дарга хогийн сав ухахыг хориглосон, мөн гудамжинд гуйлга гуйхыг хориглосон хоёр захирамж гаргасан нь нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг ялангуяа ядуус, орон гэргүйчүүдийг ялгаварлан гадуурхсан шинжтэй байжээ. Хүний эрхийн холбоо эдгээр захиргааны актуудыг хууль зүйн үндэслэлгүй, хүний эрх, эрх чөлөөнд халдсан гэж үзэн Захиргааны шүүхэд нэхэмжлэл гаргасан байна. Ялангуяа энэ маргааны хувьд "Хогийн сав ухахыг хориглох" захирамжийн хууль ёсны байдлын асуудлаар дээд шатны шүүхэд хүрчээ.

Анхан болон давж заалдах шатны шүүхүүд "орон нутгийн чанартай асуудалд улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг холбоо оролцох эрхгүй" гэсэн үндэслэлээр Хүний эрхийн холбооны нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгожээ. Харин Захиргааны дээд шүүх энэ асуудлыг авч хэлэлцээд дараах зарчмын шийдвэрийг гаргажээ:

- "Ерөнхийдөө улсын хэмжээний холбоо орон нутгийн хүрээнд хамаарах шийдвэрийг шүүхэд өдөөж маргах эрхгүй боловч, тухайн шийдвэрийн шинж, агуулга нь орон нутгийн хүрээг давж, нийтлэг ач холбогдол бүхий эрхийн асуудлыг хөндөж байгаа бол нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрч болно."

Ингэснээр Захиргааны дээд шүүх Хүний эрхийн холбооны нэхэмжлэх эрхийг хүлээн зөвшөөрч, доод шатны шүүхүүдийн шийдвэрийг хүчингүй болгосон байна. Энэхүү шийдвэр нь Франц Улсын захиргааны эрх зүйд нийтийн эрх ашгийн төлөө нэхэмжлэл гаргах эрхийн хүрээг уян хатан байдлаар тэлсэн, чухал жишиг шийдвэр болсон юм. Үүний үр дүнд зөвхөн хүний эрхийн байгууллагууд бус, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх бүх төрлийн холбоо, эвсэл тодорхой нөхцөлд орон нутгийн шийдвэрийг үндэсний түвшний нийтийн эрхийн асуудал болгон шүүхэд маргах боломжтой болсон гэж үздэг болжээ.

Дээр дурдсан шүүхийн шийдвэрүүд нь Франц Улсад иргэн, холбоод нийтийн ашиг сонирхлыг хамгаалахаар шүүхэд хандсан явдал нь төр, захиргааны бодлогод тодорхой өөрчлөлт авчирч, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үзэл санааг шинэ шатанд гарсан жишээнүүд юм. 1901 оны Касановагийн хэргээр анх удаа иргэн орон нутгийн төсвийн хууль ёсны байдлыг шүүхэд хянуулах эрхтэй болсон бол, 1906 оны Лиможийн үсчдийн холбооны шийдвэрээр мэргэжлийн холбоод бүлгийн эрх ашгаа төлөөлөн шүүхэд хандах эрх хүлээн зөвшөөрөгдсөн, улмаар 2015 оны Хүний эрхийн холбооны хэрэг нь энэ хүрээг өргөтгөж, орон нутгийн шийдвэр ч үндэсний хэмжээнд нийтийн эрх ашигт хамаарч болохыг тогтоожээ. Харин депакин эмд холбогдох хэрэг нь уламжлалт нийтийн ашиг сонирхлын нэхэмжлэлээс ялгаатай ч, адил төрлийн хохирол амссан олон иргэний эрхийг хамтад нь хамгаалсан орчин үеийн бүлгийн ашиг сонирхлын нэхэмжлэлийн бодит жишээ болжээ. Энэхүү хэрэг нь төрийн хяналт сул байсан асуудалд олон нийтийн оролцоог сэргээж, нийгмийн шударга ёсны илэрхийлэл болсон юм.

²⁷ Bourdon, Philippe. « Jurisprudence : L'intérêt pour agir d'une association "nationale" contre une décision "locale". » (2015). Lexbase - La lettre juridique, n° 636. <https://www.lexbase.fr/article-juridique/27716590-jurisprudence-linteret-pour-agir-dune-association-nationale-contre-une-decision-locale#:~:text=conteneurs%20et%20autres%20lieux%20de,significatif%20de%20personnes%20d%27origine%20%27rom,> (Сүүлд үзсэн: 2025.10.23).



2. ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС

2.1. Онолын үндэслэл, эрх зүйн тогтолцоо

ХБНГУ-ын Үндсэн хууль (1949)²⁸-ийн 19 дүгээр зүйлийн 4-т "Аливаа этгээд нийтийн засаглалын үйл ажиллагааны улмаас эрх нь зөрчигдсөн гэж үзвэл шүүхэд хандах эрх нээлттэй" хэмээн заасан байна. Хуулийн дээрх заалтад тусгасан "нийтийн засаглал гэдэгт" гагцхүү гүйцэтгэх эрх мэдлийг ойлгоно.²⁹ Үндсэн хуульд заасан дээрх шүүхэд хандах эрхийн баталгааг Захиргааны шүүхийн тухай хууль (1960)³⁰-ийн 42 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Хуульд өөрөөр заагаагүй бол нэхэмжлэгч нь захиргааны актын улмаас, эсвэл захиргааны актаас татгалзсан эсвэл эс үйлдэхүйн улмаас эрх нь зөрчигдсөн гэж үзвэл хүчингүй болгуулах эсвэл даалгах нэхэмжлэл гаргана" хэмээн нарийвчлан тусгасан бөгөөд уг зохицуулалт нь захиргааны хэргийн шүүх нэхэмжлэлийг хүлээн авах урьдчилсан нөхцөл болдог.

Үндсэн хууль болон Захиргааны шүүхийн тухай хуульд заасан эдгээр зохицуулалтад шүүхэд хандаж буй этгээдийн өөрийн эрх зөрчигдсөн байх гэсэн урьдчилсан нөхцөлийг тавьснаар тухайн улсын шүүх байгууллага субъектив эрхийн хамгаалалтыг хэрэгжүүлдэг хэмээн үздэг байна. Гэхдээ онцгой тохиолдолд субъектив эрх зөрчигдсөн байх шаардлагаас хазайхыг зөвшөөрдөг бөгөөд энэ нь нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах үед тохионо.³¹

Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийн талаар Захиргааны шүүхийн тухай хуульд заагаагүй, харин салбар хуулиудад тухайлбал, Байгаль орчныг хамгаалах тухай хууль (2003)³²-д уг эрхийг заасан байна.

Судалгааны өмнөх хэсэгт дурдсан Аархусын конвенц³³-д ХБНГУ нь мөн нэгдэн орсон байдаг. Уг конвенцын 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт байгаль орчныг хамгаалах чиглэлээр үйл ажиллагааг явуулдаг төрийн бус байгууллагад шүүхэд хандах эрх олгох талаар зохицуулжээ. ХБНГУ нь конвенцын дээрх заалтыг хэрэгжүүлэх үүднээс Байгаль орчныг хамгаалах тухай хууль (2006)³⁴-ийг баталсан бөгөөд уг хуульд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах холбоонд тавигдах шалгуур болон ямар асуудлаар шүүхэд хандах зэрэг харилцааг тус тус зохицуулсан байна.

²⁸ Grundgesetz für die Bundesrepublik Deutschland, 1949, https://www.gesetze-im-internet.de/gg/pr_ambel.html. (Сүүлд үзсэн:2025.10.22).

²⁹ Гочоогийн Банзрагч, "Герман-Монголын захиргааны процессын эрх зүйн харьцуулалт", legaldata.mn, 2017, S.1.

³⁰ Verwaltungsgerichtsordnung (VwGO), 1960, <https://www.gesetze-im-internet.de/vwgo/index.html>. (Сүүлд үзсэн:2025.10.22).

³¹ Deutscher Bundestag, Wissenschaftliche Dienste, Die umweltrechtliche Verbandsklage in der Europäischen Union, <https://www.bundestag.de/resource/blob/587750/WD-7-216-18-pdf.pdf>.

³² Umwelt-Rechtsbehelfsgesetz – UmwRG, https://www.gesetze-im-internet.de/umwrg/_1.html, 2003. (Сүүлд үзсэн: 2025.10.23).

³³ Die Aarhus-Konvention, 1998, <https://www.aarhus-konvention.de/aarhus-konvention/>. (Сүүлд үзсэн:2025.10.22).

³⁴ Umwelt-Rechtsbehelfsgesetz, 2006, <https://www.gesetze-im-internet.de/umwrg/index.html#BJNR281600006BJNE000111360>. (Сүүлд үзсэн:2025.10.22).



2.2. Хууль тогтоомжид тусгагдсан байдал

Түүхэн үүднээс авч үзвэл ХБНГУ-д нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд хандах эрхийг зөвшөөрөх эсэх асуудал олон жилийн турш маргаантай явж иржээ. Уг маргаан нь Үндсэн хууль болон шүүх байгууллагын чиг үүрэгтэй холбоотойгоор өрнөдөг. Тодруулбал, Үндсэн хуулийн 19.4-т хувь хүний субъектив эрхийн зөрчлийг хамгаалах талаар заасан бөгөөд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах нь Үндсэн хуультай зөрчилдөнө гэх байр суурийг илэрхийлдэг зарим эрдэмтэд байдаг. Үүнээс гадна шүүх байгууллага нь иргэн хооронд үүссэн маргаан эсвэл иргэн болон төрийн байгууллага хооронд үүссэн маргааныг хянан шийдвэрлэх үүрэгтэй, харин объектив эрхийн хяналтыг хэрэгжүүлдэггүй гэж зарим эрдэмтэд үздэг байна.³⁵ Энэхүү маргаантай асуудалд эрдэмтэд дараах тайлбарыг өгчээ. Үүнд:

Үндсэн хуулийн 19.4-т хувь хүний эрхийг хамгаалахад баримтлах наад захын хамгаалалтыг баталгаажуулсан байдаг. Иймээс хууль тогтоогч хувь хүний эрх зөрчигдсөн байх урьдчилсан нөхцөлөөс үл хамааран эрх зүйн хамгаалалтын хувилбарыг бий болгох боломжтой бөгөөд уг боломжийг ашиглахдаа гагцхүү үндсэн хуулиар баталгаажсан хувь хүний эрх зүйн хамгаалалтыг алдагдуулахгүй байх ёстой.³⁶ Мөн Захиргааны шүүхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 2-т "хуульд өөрөөр заагаагүй бол" гэх зохицуулалтыг тусгасан бөгөөд энэ нь онцгой тохиолдолд хувь хүний эрх зөрчигдсөн байх урьдчилсан нөхцөл шаардахгүй байх үр дагаварт хүргэдэг. Тиймээс Холбооны түвшинд болон Муж улсын түвшинд хувь хүний эрх зөрчигдөөгүй ч нийтийн ашиг сонирхлын үүднээс захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг хэрэгжүүлэх боломжтой байдаг гэж үздэг байна. Иймээс хуулиар нийтийн эрх ашгийг хамгаалан шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг хуульд заасан тодорхой шалгуур хангасан холбоонд олгожээ.

Тус улсад эрх бүхий холбоо (англ. association)³⁷ нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргахыг (*зепм. Verbandsklage, англ. legal action by association*) гэсэн ухагдахуунаар илэрхийлэх бөгөөд дараах асуудлын хүрээнд захиргааны хэргийн шүүх болон иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргадаг.

- Холбоо нь захиргааны хэргийн шүүхэд байгаль орчин болон амьтан хамгаалах асуудлаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхтэй.
- Холбоо нь иргэний хэргийн шүүхэд хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудлаар нэхэмжлэл гаргах эрхтэй.

³⁵ Eleftherios Dikaios, *Überindividueller Umweltschutz am Beispiel der altruistischen Verbandsklage in der deutschen, griechischen und europäischen Rechtsordnung*, Teilband I, 2018, S 241.

³⁶ Annette Guckelberger: *Allgemeines Verwaltungsrecht mit Verwaltungsprozessrecht und Staatshaftungsrecht*, 2023, 11. Auflage, S.122.

³⁷ Эрх бүхий холбоо гэдэг нь хэрэглэгч эсвэл олон нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх хууль ёсны эрх бүхий мэргэшсэн байгууллага юм. Энэхүү байгууллага нь хэрэглэгчийн эрх ашиг, байгаль орчны асуудлаар голчлон байгуулагддаг байна.



Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээд, нэхэмжлэл гаргах эрхийн хүрээ, хязгаар, үндэслэл, маргааны төрөл

ХБНГУ-д холбоо дараах 2 төрлөөр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

- egoistische Verbandsklage буюу хувийн эрх ашгийг хамгаалах зорилгоор гаргаж буй нэхэмжлэл;
- altruistische Verbandsklage буюу нийтийн эрх ашгийг хамгаалах зорилгоор гаргаж буй нэхэмжлэл.³⁸

Шүүхэд хувийн эрх ашгийг хамгаалах зорилгоор гаргаж байгаа нэхэмжлэл нь холбоо өөрийн нэрийн өмнөөс гишүүдийн субъектив эрх зөрчигдсөнд холбогдуулан гаргаж буй нэхэмжлэл байдаг.

Харин шүүхэд нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор нэхэмжлэл гаргах гэдэгт байгаль орчныг хамгаалах эрх бүхий холбоо шүүхэд нэхэмжлэл гаргахыг хэлэх бөгөөд уг нэхэмжлэл нь холбооны гишүүдийн эрх ашгийг зөрчсөнтэй хамааралгүй, харин нийтийн эрх зүйд хамаарах хууль тогтоомжийг зөрчсөнтэй холбогдуулан гаргагдгаараа ялгаатай болно.

Нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээдэд тавигдах шаардлага:

Байгаль орчныг хамгаалах зорилгоор захиргааны шүүхэд нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээд нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан дараах шаардлагыг хангасан байх ёстой байна.

Хүснэгт 4. ХБНГУ-ын байгаль орчныг хамгаалах тухай хуулийн зохицуулалт

Хуулийн нэр	Хуулийн зохицуулалт
Байгаль орчныг хамгаалах тухай хууль	<p style="text-align: center;">3 дугаар зүйл</p> <p>Дотоодын болон гадаадын холбоо нь хүсэлт гаргасан бол энэ хуульд зааснаар нэхэмжлэл гаргах эрхийг зөвшөөрч болно. Дараах нөхцөлд тухайн холбоог хүлээн зөвшөөрнө.</p> <ol style="list-style-type: none"> 1. Холбоо нь дүрэмдээ байгаль хамгаалах зорилгыг тусгасан мөн уг зорилго нь түр зуурын бус шинжтэй байх. 2. Холбоо нь хамгийн багадаа 3 жил үйл ажиллагаа явуулсан байх ёстой бөгөөд уг хугацаанд энэ зүйлийн №1-д заасан чиг үүргийг хэрэгжүүлсэн байх. 3. Үйл ажиллагаа явуулах тэр дундаа төрийн байгууллагын шийдвэр гаргах ажиллагаанд оролцох чадвартай байх. Үүний тулд үйл ажиллагааны төрөл, хүрээ, гишүүний тоо, холбоо үйл ажиллагаа явуулах чадвартай эсэхийг харгалзан үзэх. 4. Татварын хуулийн 52 дугаар зүйлд заасны дагуу үйл ажиллагаа явуулдаг байх. <p>Холбооны зорилгыг дэмжиж буй хэн бүхэн гишүүнээр элсэх боломжтой байх, холбооны гишүүд холбооны гишүүдийн хуралд саналын эрхтэй оролцдог байх.</p>

³⁸ Eleftherios Dikaios: *Überindividueller Umweltrechtsschutz am Beispiel der altruistischen Verbandsklage in der deutschen, griechischen und europäischen Rechtsordnung*, Teilband I, 2018, S 241.



Дээрх шаардлагыг хангасан холбоог Холбооны Улсын Байгаль орчны яам шүүхэд нэхэмжлэл гаргах эрх бүхий холбоогоор хүлээн зөвшөөрөх эсэх асуудлыг шийдвэрлэдэг. Мөн яамнаас нэхэмжлэл гаргах эрх бүхий холбооны жагсаалтыг гаргадаг байна.³⁹ Уг жагсаалтад багтсан холбоог нь "Байгаль орчныг хамгаалах өмгөөлөгч" хэмээн үздэг бөгөөд уг холбоо нь хувь хүний субъектив эрх зөрчигдсөн эсэхээс үл хамааран нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй болдог.

Захиргааны хэргийн шүүхэд гаргах нэхэмжлэлийн төрөл:

Шүүхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрх бүхий холбоо нь байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан шийдвэрийн эсрэг дараах нэхэмжлэлийг гаргана.⁴⁰

- Олгосон зөвшөөрлийг хүчингүй болгуулах тухай буюу хүчингүй болгуулах нэхэмжлэл (гер. *Anfechtungsklage*),
- Эрх бүхий байгууллагаас хэрэгжүүлэх шаардлагатай шийдвэр гаргуулах буюу даалгах нэхэмжлэл (гер. *Verpflichtungsklage*),
- Орон нутгийн барилга төлөвлөлтийн шийдвэрийг хүчингүйд тооцуулах нэхэмжлэл буюу хэм хэмжээний хяналтын нэхэмжлэл (гер. *Normenkontrollantrag*),
- Хэм хэмжээг хууль бус гэдгийг тогтоолгох нэхэмжлэл (гер. *Feststellungsklage*)

Амьтны эрхийг хамгаалахтай холбогдуулан нэхэмжлэл гаргах эрх

Амьтад өөрсдийн эрх ашгийг хамгаалж, тэдний эрхийг баталгаажуулсан хууль тогтоомжийг дагаж мөрдөхийг шаардаж чадахгүй учраас тэднийг сайн дурын үндсэн дээр төлөөлөн эрхийг нь хамгаалах төлөөлөгч хэрэгтэй байдаг. Иймээс уг эрхийг амьтны эрхийг хамгаалах зорилгоор үйл ажиллагаа явуулдаг холбоонд олгодог байна.

ХБНГУ-ын хуульч Йоханнес Каспар (Johannes Caspar) амьтны эрхийг хамгаалах зорилгоор гаргаж буй нэхэмжлэл нь байгаль орчныг хамгаалахаар гаргаж байгаа нэхэмжлэлээс ялгаатай байдаг гэжээ.⁴¹ Тэрээр байгаль орчныг хамгаалах нь бид өөрсдийн болон ирээдүй хойч үеийн төлөөх үйлдэл байдаг тул байгаль хамгаалах нэхэмжлэлийг нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс гаргадаг. Харин амьтны эрхийг хамгаалах зорилгоор гаргаж буй нэхэмжлэл нь нийтийн ашиг сонирхлын гэхээс илүүтэй ёс суртахуунтай холбоотой байдаг. Цаашлаад бид өөрсдийн ашиг сонирхлын төлөө амьтдыг хамгаалдаг гэжээ. Гэхдээ амьтны эрхийг хамгаалах зорилго бүхий холбоо нь захиргааны шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй бөгөөд үүнийг Үндсэн хуулийн заалттай холбон тайлбарладаг байна.

³⁹ Anerkennung von Umwelt- und Naturschutzvereinigungen, <https://www.umweltbundesamt.de/8>. (Сүүлд үзсэн:2025.10.22).

⁴⁰ Fachagentur Windenergie und Land, Klagemöglichkeiten nach dem Umwelt-Rechtsbehelfsgesetz (UmwRG) 2017, S.15. https://www.fachagentur-wind-solar.de/fileadmin/Veroeffentlichungen/Wind/Natur- und Artenschutz/FA_Wind_Hintergrundpapier_UmwRG_Klagemoeglichkeiten_12-2017.pdf. (Сүүлд үзсэн:2025.10.22).

⁴¹ Michael Klopfer und Hans-Georg Kluge: Die tierschutzrechtliche Verbandsklage, 2017, S.62.

ХБНГУ-ын Үндсэн хуулийн 20а дугаар зүйлд “Үндсэн хуулийн дэг журмын бүхий л хүрээнд төр нь хойч үеийн өмнө хүлээсэн хариуцлагаа ухамсарлан амьдралын баталгааг хууль тогтоох замаар хангах, хуульд нийцүүлэн гүйцэтгэх болон шүүхийн үйл ажиллагаагаар хамгаална” гэж заасан байх бөгөөд Үндсэн хуулийн уг заалтад үндэслэн амьтдыг хамгаалах ёстой гэж үздэг байна.⁴² Амьтны эрхийг хамгаалах тухай хууль (1972)⁴³-ийн 16а дугаар зүйлд эрх бүхий байгууллага нь илэрсэн зөрчлийг арилгах, ирээдүйд зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна хэмээн заасан бөгөөд арга хэмжээг аваагүй тохиолдолд эрх бүхий холбоо нэхэмжлэл гаргах боломжтой. Одоогоор тус улсын зарим мужид⁴⁴ амьтны эрх хамгаалах зорилгоор нэхэмжлэл гаргах эрх бүхий холбоод үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн байна.

3. БҮГД НАЙРАМДАХ ПОРТУГАЛ УЛС

3.1. Онолын үндэслэл, эрх зүйн тогтолцоо

Португал Улс нь эх газрын эрх зүйн бүлд харьяалагдах бөгөөд Үндсэн хуулийн шүүх (англ. *Constitutional Court*), Эрүү, Иргэний шүүх (англ. *Judicial court*), Захиргаа болон Татварын шүүх (англ. *Administrative and tax court*), Аудитын шүүх (англ. *Court of Audit*), Далайн шүүх (англ. *Maritime court*), Арбитрын шүүх (англ. *Arbitration tribunal*) зэрэг 3 шатлал бүхий шүүхийн тогтолцоотой.⁴⁵ Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхийг хууль болон онолын хүрээнд (лат. *actio popularis*) гэж нийтлэг байдлаар томъёолон хэрэглэдэг байна.

Байгаль орчныг хамгаалах асуудлыг нийтийн ашиг сонирхлын үүднээс судалж, судалгааны ажил бичсэн судлаач Александра Арагао болон Ана Селесте Карвало нар нийтийн ашиг сонирхол гэдгийг тархсан ашиг сонирхлын онолын (англ. *The doctrine of diffuse interest*)⁴⁶ хүрээнд авч үзсэн байдаг. Тархсан ашиг сонирхлын онолыг нийгмийн олон үнэт зүйлсэд ашиглаж болох ч, хамгийн өргөн ашиглагддаг салбар нь байгаль орчныг хамгаалахтай холбоотой асуудал юм гэжээ.⁴⁷

Дээрх судлаачдын үзэж байгаагаар Португал Улсын Үндсэн хуульд “*actio popularis*” буюу нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхийг хуульчилсан нь нийгэмд шударга ёсыг тогтооход чиглэсэн гэжээ. Энэхүү эрх нь шүүхэд 1980-аад оноос хойш байгаль орчныг хамгаалах зорилгоор идэвхтэй хэрэглэгдэж байна. Тухайн төрлийн хэрэг маргааны нэг талд байгаль орчныг

⁴² Verbandsklagerecht im Tierschutz, <https://albert-schweitzer-stiftung.de/themen/gesellschaft/verbandsklagerecht>. (Сүүлд үзсэн: 2025.10.22).

⁴³ Tierschutzgesetz, 1972, <https://www.gesetze-im-internet.de/tierschg/index.html>. (Сүүлд үзсэн: 2025.10.22)

⁴⁴ Үнд Берлин, Бремен, Намбург, Райнланд-Пфальц, Шлесвиг-Хольштайн, Баден-Вюрттемберг, Заарланд гэсэн муж хамаарна.

⁴⁵ “Pritzler Legal Research Center”, 2024, <https://library.law.northwestern.edu/c.php?g=1289164&p=946761Z>, (Сүүлд үзсэн: 2025.10.17).

⁴⁶ Тархсан ашиг сонирхлын онол гэдэг нь төвлөрсөн ашиг сонирхлын эсрэг чиглэдэг, санхүүгийн бус ашиг сонирхол бүхий иргэд, олон нийтийг хэлдэг байна.

⁴⁷ Alexandra Aragao and Ana Celeste Carvalho, “Taking access to justice seriously: diffuse interests and *actio popularis*. Why not?”, *ElNi Review*, no2 (2017), 43, https://www.elni.org/fileadmin/elni/dokumente/Archiv/2017/Heft_2/elni2017-2_Aragao_etal.pdf, (Сүүлд үзсэн: 2025.10.17).



хамгаалах зорилго бүхий олон нийтийн ашиг сонирхол байдаг бол нөгөө талд байгаль орчныг бохирдуулагч (ажил эрхлэлтийг бий болгож, эдийн засгийн үр өгөөж үзүүлэгч) этгээд байдаг. Иймд энгийн иргэд хууль зүйн туслалцаа авах санхүүгийн нөхцөл байдал тааруу байдгаас шалтгаалан хэрэг маргаан шударга, үнэн зөв шийдэгдэхэд хүндрэл үүсдэг талаар дурдсан байна.⁴⁸

Өөр нэгэн судалгааны бүтээлд Өрсөлдөөний хууль (англ. *Competition law*)-ийн⁴⁹ дагуу хэрэглэгчийн эрхийг хамгаалах зорилгоор нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргаж болох боловч энэ талаарх шүүхийн практик хангалттай тогтож амжаагүй, нэхэмжлэл гаргасан ч бодит үр дүн авчрахгүй байгаа талаар дурджээ. Учир нь хохирлыг тогтооход чиглэсэн нотлох баримт цуглуулах ажиллагааны зардал хэт өндөр, шүүхээс энэ төрлийн хэрэг маргаан ховор үүсдэгтэй холбоотой гэсэн байна. Судлаачид "actio popularis" буюу нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхийг процессын хувьд илүү нарийвчлан журамлах, нотлох баримт цуглуулах ажиллагааг сайжруулан хуульчлах шаардлагатай гэж үзжээ.⁵⁰

3.2. Хууль тогтоомжид тусгагдсан байдал

Португал Улсын хувьд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхийг Үндсэн хууль болон Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх хууль⁵¹ (порт. *Código de Processo nos Tribunais Administrativos*), Иргэний хэрэг хянан шийдвэрлэх хуульд⁵² (порт. *Código de Processo Civil*) тус тус хуульчилжээ. Мөн Үндсэн хуулийн 52 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн 1995 онд Шийдвэр гаргах ажиллагаа болон нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах хуулийг⁵³ (порт. *Direito de participação procedimental e de acção popular*) баталж, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах асуудлыг нарийвчлан зохицуулснаараа онцлог байна.

Тус улсад нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах үндсэн эрхийг Португал Улсын Үндсэн хуулийн 52 дугаар зүйлд баталгаажуулжээ. Уг зүйлд зааснаар иргэд дангаар болон хамтарч эсхүл нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор байгуулагдсан холбоогоор дамжуулан шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй талаар тусгасан байна. Үүний хажуугаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлж төрийн эрх бүхий байгууллагад өргөдөл, гомдол, мэдүүлэг гаргах эрхийг хамтад нь зохицуулсан байх ба нийтийн ашиг сонирхол гэдэгт нийтийн

⁴⁸ Alexandra Aragao and Ana Celeste Carvalho, "Taking access to justice seriously: diffuse interests and actio popularis. Why not?", *Elni Review*, no2 (2017), 43, https://www.elni.org/fileadmin/elni/dokumente/Archiv/2017/Heft_2/elni2017-2_Aragao_etal.pdf, (Сүүлд үзсэн: 2025.10.17).

⁴⁹ Lei n.º 19/2012, https://diariodarepublica.pt/dr/detalhe/lei/19-2012-553391?utm_source. (Сүүлд үзсэн: 2025.10.17).

⁵⁰ Leonor Rossi and Miguel Sousa Ferro, "Private enforcement of Competition law in Portugal (II): Actio Popularis - Facts, fictions and dreams", 36, https://www.concorrenca.pt/sites/default/files/imported-magazines/CR13 - Leonor_Rossi - Miguel_Sousa_Ferro.pdf, (Сүүлд үзсэн: 2025.10.17).

⁵¹ СРТА, Lei n.º 15/2002, <https://diariodarepublica.pt/dr/legislacao-consolidada/lei/2002-34464475>, (Сүүлд үзсэн: 2025.10.17).

⁵² СРС, Lei n.º 41/2013, <https://diariodarepublica.pt/dr/legislacao-consolidada/lei/2013-34580575>, (Сүүлд үзсэн: 2025.10.17).

⁵³ Lei n.º 83/95, https://dre.tretas.org/dre/68938/lei-83-95-de-31-de-agosto?utm_source, (Сүүлд үзсэн: 2025.10.17).

эрүүл мэнд, хэрэглэгчийн эрх, амьдралын чанар, байгаль орчин, соёлын өв, улсын болон орон нутгийн өмчийг хамгаалах асуудлыг хамруулжээ.

Хүснэгт 5. Португал Улсын Үндсэн хуулийн зохицуулалт

Хуулийн нэр	Хуулийн зохицуулалт
Португал Улсын Үндсэн хууль	<p>52 дугаар зүйл. Өргөдөл гаргах эрх ба олон нийтийн нэхэмжлэл гаргах эрх</p> <p>1. Иргэн бүр дангаар эсхүл бусадтай хамтран өөрийн эрх, Үндсэн хууль, хууль тогтоомж болон өөртөө засах орон нутгийн нийтийн ашиг сонирхлыг (англ. <i>The general interest</i>) хамгаалах зорилгоор төрийн эрх мэдлийн байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, аливаа эрх бүхий байгууллагад өргөдөл (англ. <i>petitions</i>), гомдол (англ. <i>complaints</i>), мэдүүлэг (англ. <i>representations</i>), нэхэмжлэл (англ. <i>claims</i>) гаргах эрхтэй бөгөөд эдгээрийг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллийг зохих хугацаанд авах эрхтэй.</p> <p>2. Бүгд Найрамдах Улсын Ассамблей (англ. <i>The Assembly of the Republic</i>) болон өөртөө засах орон нутгийн хууль тогтоох байгууллагын Ассамблей (англ. <i>The Legislative Assemblies of the autonomous</i>)-д хамтран гаргасан өргөдлийг (англ. <i>joint petition</i>) чуулганаар хэлэлцэх журам, нөхцөлийг хуулиар тогтооно.</p> <p>3. Хуульд заасан тохиолдол болон нөхцөл, журмын дагуу хүн бүр биечлэн эсхүл тухайн ашиг сонирхлыг хамгаалахаар байгуулагдсан холбоогоор дамжуулан нийтийн ашиг сонирхлын хүрээнд нэхэмжлэл гаргах эрхтэй (англ. <i>The right of actio popularis</i>) бөгөөд хохирсон этгээдийн зохих нөхөн төлбөр шаардах эрхийг үүнд багтаана. Энэхүү эрхийг дараах зорилгоор хэрэгжүүлнэ:</p> <p>a. Нийтийн эрүүл мэнд, хэрэглэгчийн эрх, амьдралын чанар, байгаль орчин, соёлын өвийн эсрэг үйлдлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шүүхийн журмаар хариуцлага хүлээлгэх;</p> <p>b. Улсын болон орон нутгийн өмчийг хамгаалах;</p>

Мөн Португал Улсын Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Хэрэглэгчдийн холбоо, хэрэглэгчдийн хоршоод нь хуульд заасны дагуу төрөөс дэмжлэг авах, хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудлаар санал бодлоо илэрхийлэх эрхтэй. Тэд гишүүдийнхээ эрх ашиг болон бүлгийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор шүүхэд нэхэмжлэл гаргах эрх эдэлнэ" гэж хэрэглэгчдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалж шүүхэд нэхэмжлэл гаргах асуудлыг тусад нь нарийвчлан зохицуулсан байгааг дурдах нь зүйтэй.

Түүнчлэн, 1995 онд Португал Улсын Парламентаас Үндсэн хуулийг хэрэгжүүлэх зорилгоор "Actio popularis" буюу нийтийн ашиг сонирхлын хүрээнд нэхэмжлэл гаргах эрх болон захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд оролцох иргэдийн эрхийг Шийдвэр гаргах ажиллагаа болон нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах хуулиар⁵⁴ тусгайлан зохицуулжээ. Хуульд зааснаар нийтийн ашиг сонирхолд холбогдох хэрэг маргаан нь иргэний болон захиргааны хэргийн журмаар шийдвэрлэгдэж болдог онцлогтой. Тухайлбал, нийтийн ашиг

⁵⁴ Lei n.º 83/95, https://dre.tretas.org/dre/68938/lei-83-95-de-31-de-agosto?utm_source. (Сүүлд үзсэн: 2025.10.17).



сонирхлыг төлөөлөн гаргасан нэхэмжлэл нь захиргааны хууль бус үйл ажиллагаа, захиргааны актыг хүчингүй болгохтой холбоотой бол захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарна. Харин урьдчилан сэргийлэх, нөхөн төлбөр авах, хохирол шаардах, хор уршгийг таслан зогсоохтой холбоотой бол иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаардаг байна.⁵⁵

Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхийн талаар зохицуулсан Шийдвэр гаргах ажиллагаа болон нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах хуулийн зарим зохицуулалтаас дурдвал:

⁵⁵ Alexandra Aragao and Ana Celeste Carvalho, "Taking access to justice seriously: diffuse interests and actio popularis. Why not?", Elni Review, no2 (2017), 47, https://www.elni.org/fileadmin/elni/dokumente/Archiv/2017/Heft_2/elni2017-2_Aragao_etal.pdf, (Сүүлд үзсэн: 2025.10.17).



Хүснэгт 6. Португал Улсын Шийдвэр гаргах ажиллагаа болон нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах хуулийн зохицуулалт

Хуулийн нэр	Хуулийн зохицуулалт
<p>Португал Улсын Шийдвэр гаргах ажиллагаа болон нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах хууль</p>	<p align="center">1 дүгээр зүйл. Энэ хуулийн хамрах хүрээ</p> <p>1. Энэ хуулиар Португал Улсын Үндсэн хуулийн 52 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох эсхүл шүүхийн журмаар шийдвэрлүүлэх зорилгоор захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд иргэд, олон нийтийн оролцох эрх, мөн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхийг ямар нөхцөл, журмын хүрээнд эдлэхийг тодорхойлсон болно.</p> <p>2. Энэ хуулиар хамгаалах ашиг сонирхолд нийтийн эрүүл мэнд, байгаль орчин, амьдралын чанар, хэрэглэгчийн эрх, соёлын өв, улсын болон нийтийн өмч хамаарна.</p>
	<p align="center">2 дугаар зүйл. Олон нийтийн оролцоо болон нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрх</p> <p>1. Иргэний болон улс төрийн эрхээ эдэлж буй иргэн бүр, өмнөх зүйлд заасан ашиг сонирхлыг хамгаалдаг холбоо, сан тухайн асуудалд шууд ашиг сонирхолтой эсэхээс үл хамааран олон нийтийн үйл ажиллагаанд оролцох, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхтэй.</p> <p>2. Мөн дээрх хэсэгт заасан эрхийг тухайн орон нутгийн харьяа нутаг дэвсгэрт оршин суугчдын эрх ашгийг төлөөлөх хүрээнд орон нутгийн захиргааны байгууллага эдэлж болно.</p>
	<p align="center">3 дугаар зүйл. Холбоо болон сан шүүхэд нэхэмжлэл гаргах эрх зүйн хүчин төгөлдөр байдал</p> <p>Холбоо болон сан нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрх, захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд оролцох эрхийг хэрэгжүүлэхдээ дараах шаардлагыг хангасан байна:</p> <ul style="list-style-type: none"> a. Хуулийн этгээд байх; b. Өөрийн дүрэм, зорилго, үйл ажиллагааны чиглэл нь нэхэмжлэлийн хүрээнд хамаарах нийтийн ашиг сонирхлыг хамгаалах талаар тодорхой тусгасан байх; c. Ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаггүй байх;
	<p align="center">12 дугаар зүйл. Захиргаа болон иргэний хэргийн журмаар хэрэг үүсгэх, нэхэмжлэл гаргах</p> <p>1. Захиргааны хэргийн журмаар хэрэг үүсгэх ажиллагаа нь 1 дүгээр зүйлд дурдсан ашиг сонирхлыг хамгаалах зорилготой нэхэмжлэл болон эдгээр ашиг сонирхлыг хохироосон аливаа захиргааны актад эсхүл шийдвэрт гаргасан нэхэмжлэл хамаарна.</p> <p>2. Иргэний хэргийн журмаар хэрэг үүсгэх ажиллагаа нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуульд заасан аль ч хэлбэрээр нэхэмжлэл гаргаж болох бөгөөд тус хуулийн процессын дагуу явагдана.</p>
	<p align="center">16 дугаар зүйл. Прокурорын байгууллага</p> <p>1. Прокурорын байгууллага нь хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бөгөөд хэрэв хэрэг маргаанд төр оролцогч тал байвал төрийг төлөөлнө. Мөн насанд хүрээгүй болон эрх зүйн чадамжгүй этгээдийг төлөөлөх үүрэгтэй.</p> <p>2. Прокурорын байгууллага нь хуулиар зөвшөөрсөн тохиолдолд төрийн бусад хуулийн этгээдийг төлөөлж болно.</p> <p>3. Хууль ёсны байдлыг хянан шалгах хүрээнд Прокурорын байгууллага нэхэмжлэгчийг орлож хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэх эрхтэй. Ялангуяа нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан, эвлэрлийн хэлэлцээр хийсэн эсхүл тухайн нийтийн ашиг сонирхлын эсрэг харш үйлдэл хийсэн тохиолдолд энэ эрхээ хэрэгжүүлнэ.</p>



Цаашилбал, Португал Улсын Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулийн⁵⁶ (порт. Código de Processo nos Tribunais Administrativos) 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг болон 55 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхийн талаар нарийвчлан зохицуулсан байна:

Хүснэгт 7. Португал Улсын Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулийн зохицуулалт

Хуулийн зүйл	Хуулийн зохицуулалт
Португал Улсын Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хууль	<p align="center">9 дүгээр зүйл. Эрх бүхий этгээд</p> <p>2. Хувийн ашиг сонирхол хөндөгдсөн эсэхээс үл шалтгаалан аливаа хүн, түүнчлэн тухайн ашиг сонирхлыг хамгаалах зорилго бүхий холбоо, сан, орон нутгийн захиргааны байгууллага болон прокурор нь хуульд заасны дагуу Үндсэн хуулиар хамгаалагдсан үнэт зүйлс болох нийтийн эрүүл мэнд, байгаль орчин, хот байгуулалт, газар ашиглалт, төлөвлөлт, амьдралын чанар, соёлын өв, улс, орон нутгийн өмчийг хамгаалах зорилгоор нэхэмжлэл гаргах, урьдчилан сэргийлэх зорилгоор нэхэмжлэл гаргах, оролцох эрхтэй. Мөн эдгээр асуудлаар гарсан шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.</p>
	<p align="center">55 дугаар зүйл. Эрх бүхий этгээд</p> <p>1. Захиргааны актыг хүчингүй болгох нэхэмжлэл гаргах эрхтэй этгээдүүд:</p> <p>a) Тухайн актаар өөрийн эрх эсхүл хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлоо шууд болон шууд бус байдлаар хохирсон гэж үзэж буй этгээд;</p> <p>b) Улсын Ерөнхий Прокурорын газар;</p> <p>c) Тухайн эрх, ашиг сонирхлыг хамгаалах үүрэг бүхий төрийн болон хувийн байгууллагууд;</p> <p>d) Төрийн байгууллагаас гаргасан захиргааны актад хяналт тавих эрх бүхий бусад төрийн байгууллагууд;</p> <p>e) Өөрийн байгууллагын гаргасан захиргааны актад, мөн хуульд заасан тохиолдолд захиргааны хууль ёсны байдлыг хамгаалах зорилго бүхий бусад эрх бүхий байгууллагууд;</p> <p>f) Энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан этгээдүүд;</p>

Харин Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулийн⁵⁷ (порт. Código de Processo Civil) 31 дүгээр зүйлд нийтийн эрх ашиг сонирхлыг хамгаалж нэхэмжлэл гаргах этгээдүүдийг тодорхойлсон байна. Үүнийг хүснэгтээр үзүүлбэл:

⁵⁶ CPTA, Lei n.º 15/2002, <https://diariodarepublica.pt/dr/legislacao-consolidada/lei/2002-34464475>. (Сүүлд үзсэн: 2025.10.17).

⁵⁷ CPC, Lei n.º 41/2013, <https://diariodarepublica.pt/dr/legislacao-consolidada/lei/2013-34580575>, (Сүүлд үзсэн: 2025.10.17).

Хүснэгт 8. Португал Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулийн зохицуулалт

Хуулийн зүйл	Хуулийн зохицуулалт
Португал Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хууль	31 дүгээр зүйл. Нийтийн ашиг сонирхлыг хамгаалан нэхэмжлэл гаргах Эрүүл мэнд, байгаль орчин, амьдралын чанар, соёлын өв, нийтийн өмч, түүнчлэн бараа, үйлчилгээний эрхийг хамгаалах зорилгоор аливаа иргэн, тухайн сонирхлыг хамгаалах зорилго бүхий холбоо, сан, орон нутгийн захиргааны байгууллага, Улсын Ерөнхий Прокурор нэхэмжлэл гаргах, урьдчилан сэргийлэх зорилгоор нэхэмжлэл гаргах, оролцох эрхтэй.

Португал Улсад нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхийг Үндсэн хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх хууль болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулиудад нарийвчлан тусгасан байна. Харин нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрх бүхий субъект, хүрээ хязгаар, үндэслэл, процессыг 1995 онд батлагдсан Шийдвэр гаргах ажиллагаа болон нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах хуулиар тусгайлан зохицуулжээ. Түүнчлэн, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхийг зарим салбар хуулиудад нэмэлтээр хуульчилсан байдаг. Үүнд Байгаль орчны хууль⁵⁸, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль⁵⁹, Соёлын өвийн хууль⁶⁰, Үнэт цаасны хууль⁶¹ болон Өрсөлдөөний хууль зэрэг орно.⁶²

Үндсэн хуульд зааснаар нийтийн ашиг сонирхол гэдэгт нийтийн эрүүл мэнд, хэрэглэгчийн эрх, амьдралын чанар, байгаль орчин, соёлын өв, улсын болон орон нутгийн өмчийг хамруулж байгаа бөгөөд уг хүрээнд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхийг (1) иргэн дангаар болон (2) хамтарч, эсхүл тухайн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор байгуулагдсан (3) холбоо, сан, (4) прокурорын байгууллага, (5) орон нутгийн хүрээнд бол тухайн орон нутгийн захиргааны байгууллагад хуулиар олгожээ. Тухайн төрлийн нэхэмжлэл нь хууль бус захиргааны үйл ажиллагаа, захиргааны актыг хүчингүй болгохтой холбоотой бол захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарч, харин хохирол шаардах, нөхөн төлбөр гаргуулах, урьдчилан сэргийлэх, хор уршгийг таслан зогсоохтой холбоотой бол иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарахаар заасан байна.

Нийтийн ашиг сонирхлыг төлөөлж иргэд нэхэмжлэл гаргаж байгаа тохиолдолд тухайн ашиг сонирхолд шууд бус байдлаар холбогдсон байх ёстой.

⁵⁸ Lei n.º 19/2014, https://files.dre.pt/1s/2014/04/07300/0240002404.pdf?utm_source, (Сүүлд үзсэн: 2025.10.17).

⁵⁹ Lei n.º 24/96, https://dre.tretas.org/dre/76234/lei-24-96-de-31-de-julho?utm_source, (Сүүлд үзсэн: 2025.10.17).

⁶⁰ Lei n.º 107/2001, https://diariodarepublica.pt/dr/detalhe/lei/107-2001-629790?utm_source, (Сүүлд үзсэн: 2025.10.17).

⁶¹ Decreto-Lei n.º 486/99, https://diariodarepublica.pt/dr/detalhe/decreto-lei/486-1999-682983?utm_source, (Сүүлд үзсэн: 2025.10.17).

⁶² Camila Sanger, "Class Actions Law Review", The Law Review, (2021), 164, https://www.uria.com/documentos/colaboraciones/2998/documento/Portugal.pdf?id=12326_en&utm_source, (Сүүлд үзсэн: 2025.10.17).



Харин нийтийн ашиг сонирхлыг төлөөлж холбоо, сан нэхэмжлэл гаргаж байгаа тохиолдолд Шийдвэр гаргах ажиллагаа болон нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах хуулийн 3 дугаар зүйлд заасан хуулийн шаардлагыг хангасан бол эрх бүхий этгээд гэж үзэхээр хуульчилжээ.

3.3. Статистик мэдээ, шүүхийн практик

Португал Улсын шүүхийн албан ёсны статистик мэдээлэлд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргасан, шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн талаарх мэдээлэл байхгүй байна. Харин Камила Сангерийн судалгааны ажилд "Португал Улсад нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргасан, шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг маргаан тун цөөхөн бөгөөд 2007–2019 оны хооронд иргэний хэргийн шүүх ердөө 220 хэрэг маргаан шийдвэрлэсэн, үүнээс 2019 онд 11 хэрэг маргааныг иргэний хэргийн шүүх шийдвэрлэсэн"⁶³ гэж дурджээ.

Судалгааны энэ хэсэгт нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргасан хэрэг маргааныг Португал Улсын шүүхээс хэрхэн шийдвэрлэж байгааг харуулав:

Шигтгээ 3. Португал Улсын Порто хотын Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн нийтийн ашиг сонирхлын асуудлаар гаргасан шийдвэр

Иргэдийн бүлгийн нэхэмжлэлтэй А телевизэд холбогдох нийтийн эрүүл мэндтэй холбоотой хэрэг⁶⁴

Хариуцагч А телевизийн сувгийн компани нь Сэтгэцийн эрүүл мэндийн төвийн нөхцөл байдлыг шүүмжилсэн агуулга бүхий нэвтрүүлгийг цацсан байна. Энэхүү нэвтрүүлгээр эмнэлгийн орчин, өвчтөний нэр, дүрс, эмч нарын талаарх сөрөг өнгө аяс бүхий мэдээллийг гаргажээ. Хэсэг бүлэг иргэд энэ нэвтрүүлгийг нийтийн эрүүл мэнд, нэр хүндэд хохирол учруулсан гэж үзэн шүүхэд "action popularis" буюу нийтийн ашиг сонирхлыг төлөөлж нэхэмжлэл гаргасан байна.

Анхан шатны шүүхээс нэхэмжлэгч иргэдийг нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрхгүй хэмээн үзэж нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон. Учир нь тухайн нэвтрүүлэг нь тодорхой хүмүүсийн нэр хүндтэй холбоотой асуудлын хүрээнд байсан тул нийтээр хамгаалагдах ашиг сонирхол биш гэж дүгнэжээ. Харин давж заалдах шүүхээс нэвтрүүлэг нь зөвхөн хувь хүний асуудлыг биш, нийтийн эрүүл мэндийн чанар, үйлчилгээ, эмнэлгийн нөхцөл, нийгмийн итгэлцлийн хүрээнд байгаа тул нийтийн ашиг сонирхлын хүрээний асуудал мөн гэж дүгнэн анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаан шийдвэрлэжээ.

Дээрх хэрэг маргаан нь Португал Улсад нийтийн ашиг сонирхол болон хувийн ашиг сонирхол хоорондын ялгаа, хүрээг тодотгосон, нөгөө талаасаа хувь хүний нэр хүнд, ашиг сонирхол бүхий агуулга нь нийтийн ашиг сонирхол биш гэдгийг баталсан ач холбогдол бүхий шүүхийн практик байна.

⁶³ Camila Sanger, "Class Actions Law Review", The Law Review, (2021), 165, https://www.uria.com/documentos/colaboraciones/2998/documento/Portugal.pdf?id=12326_en&utm_source, (Сүүлд үзсэн: 2025.10.17).

⁶⁴ Tribunal da Relação do Porto, Acórdão № 6030/21.1T8PRT.P1, (2023), https://diariodarepublica.pt/dr/detalhe/acordao/6030-2023-877998475?utm_source. (Сүүлд үзсэн: 2025.10.17).



Шигтгээ 4. Португал Улсын Дээд шүүхийн
нийтийн ашиг сонирхлын асуудлаар гаргасан шийдвэр

**"Ius Omnibus" төрийн бус байгууллагын нэхэмжлэлтэй
Х агаарын тээврийн онгоцны тасалбарын үнэтэй холбогдох хэрэг⁶⁵**

Хариуцагч Х агаарын тээврийн компани нь 2 талын онгоцны тасалбар авсан зорчигчтой "Хэрэв зорчигч аяллын эхний нислэгт суугаагүй бол буцах нислэгийн тасалбар автоматаар хүчингүй болно" гэх нөхцөл бүхий гэрээг байгуулдаг байжээ. Үүнийг нэхэмжлэгч "Ius Omnibus" гэх хэрэглэгчийн эрхийг хамгаалах зорилготой төрийн бус байгууллагын зүгээс компанийн ашиг сонирхлыг хамгаалж, давуу байдал олгосон шударга бус гэрээ гэж үзэн шүүхэд нэхэмжлэл маргажээ. Анхан шатны шүүхээс энэ бол хувь хүн, компани хоорондын байгуулсан гэрээтэй холбоотой асуудал бөгөөд хувь хүн бүр өөрийн эрхийг хамгаалах боломжтой тул нийтийн ашиг сонирхол биш гэж үзэн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон. Үүнийг давж заалдах шатны шүүхээс хэвээр үлдээн шийдвэрлэсэн бол харин Дээд шүүхээс "нэг хэрэглэгчийн бус, бүх зорчигчдын эрхийг нэгэн зэрэг зөрчиж буй үйлдэл, мөн нэхэмжлэгч Ius Omnibus төрийн бус байгууллага нь өөрийн дүрэмдээ хэрэглэгчийн эрхийг хамгаалах зорилготой гэдгийг тусгасан байсан тул нэхэмжлэл гаргах эрхтэй этгээд" гэж тус тус үзэн, анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаажээ.

Дээрх шүүхийн шийдвэр нь нэхэмжлэл гаргаж буй төрийн бус байгууллага, холбоо, сан нь нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрх бүхий субъект мөн эсэхийг тогтоож, шийдвэрлэсэн шүүхийн практик юм. Эндээс холбоо, сан болгон нийтийн ашиг сонирхлыг төлөөлж нэхэмжлэл гаргах боломжгүй бөгөөд хуулийн хязгаарын хүрээнд нэхэмжлэл гаргадаг гэдгийг харж болохоор байна.

4. ИСПАНИЙН ХААНТ УЛС

4.1. Онолын үндэслэл, эрх зүйн тогтолцоо

Испанийн Хаант Улсын (цаашид "Испани Улс" гэх) "Conceptos" нэр томъёоны тайлбар тольд "Нийтийн ашиг сонирхол" гэдэг ойлголт нь улс төр, хууль эрх зүй, эдийн засаг, ёс зүй зэрэг олон салбарт хэрэглэгддэг нэр томъёо юм. Энэ нь хувь хүний эсвэл хувийн ашиг сонирхлоос ялгаатайгаар, нийгмийн нийтлэг сайн сайхан байдалд тустай эсвэл зайлшгүй шаардлагатай гэж үздэг зүйлсийг илэрхийлдэг. Нийтийн ашиг сонирхлын тодорхой асуудлууд нь нийт иргэдийн сайн сайхан байдалд хамааралтай бөгөөд тэдгээрийг төр, эсвэл нийгэм бүхэлдээ хамгаалж, дэмжих ёстой гэсэн ойлголтод тулгуурладаг⁶⁶ гэж тодорхойлжээ. "Нийтийн ашиг сонирхол" гэх ойлголт нь төрийн байгууллага өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад бодитойгоор илэрдэг. Өөрөөр хэлбэл, захиргааны аливаа үйл ажиллагаа нь тодорхой зорилготой байх ёстой бөгөөд тухайн зорилго нь олон нийтийн

⁶⁵ Supremo Tribunal de Justiça, Acórdão № 33/23.9T8PDL.L1.S1, (2024), https://juris.stj.pt/33%2F23.9T8PDL.L1.S1/EodbaqzPjIQbhbSz1NT-pi1PzprA?search=zUrF1qrFO18Np9k-0Og&utm_source. (Сүүлд үзсэн: 2025.10.17).

⁶⁶ Conceptos Enciclopédicos, <https://conceptos.es/interes-publico>. (Сүүлд үзсэн: 2025.10.21).



4.2. Хууль тогтоомжид тусгагдсан байдал

Испани Улсад нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхтэй холбоотой асуудлыг Испанийн Үндсэн хууль⁷⁴ (исп. Constitución Española), Прокурорын байгууллагын дүрмийг зохицуулах тухай хууль⁷⁵ (исп. por la que se regula el Estatuto Orgánico del Ministerio Fiscal), Захиргааны хэргийн шүүхийн харьяаллын тухай хууль⁷⁶ (исп. reguladora de la Jurisdicción Contencioso-administrativa), Байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, олон нийтийн оролцоо болон шударга шүүхэд хандах эрхийн тухай хууль⁷⁷ (исп. por la que se regulan los derechos de acceso a la información, de participación pública y de acceso a la justicia en materia de medio ambiente) зэрэг хуулиудаар зохицуулсан байна. Хуулийн заалтыг хүснэгтээр харуулбал:

⁷⁴ Constitución Española, 1978, <https://www.boe.es/buscar/act.php?id=BOE-A-1978-31229>, (Сүүлд үзсэн: 2025.10.21).

⁷⁵ por la que se regula el Estatuto Orgánico del Ministerio Fiscal, 1982, <https://www.boe.es/eli/es/l/1981/12/30/50/cons>. (Сүүлд үзсэн: 2025.10.21).

⁷⁶ reguladora de la Jurisdicción Contencioso-administrativa, 1998, <https://www.boe.es/buscar/act.php?id=BOE-A-1998-16718>, (Сүүлд үзсэн: 2025.10.21).

⁷⁷ por la que se regulan los derechos de acceso a la información, de participación pública y de acceso a la justicia en materia de medio ambiente, 2006, <https://www.boe.es/buscar/act.php?id=BOE-A-2006-13010>, (Сүүлд үзсэн: 2025.10.22).



Хүснэгт 9. Испани Улсын нийтийн ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотой хуулийн зохицуулалт

№	Хуулийн нэр	Хуулийн зохицуулалт
1.	Испани Улсын Үндсэн хууль	<p style="text-align: center;">7 дугаар зүйл</p> <p>Ажилчдын үйлдвэрчний эвлэлүүд болон ажил олгогчдын холбоод нь өөрсдийн эдийн засаг, нийгмийн ашиг сонирхлыг хамгаалах, дэмжихэд хувь нэмэр оруулдаг. Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид нийцсэн тохиолдолд эдгээр байгууллагыг байгуулах, үйл ажиллагаа явуулах нь чөлөөтэй байна. Тэдгээрийн дотоод бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа нь ардчилсан зарчимд нийцсэн байх ёстой.</p> <p style="text-align: center;">24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг</p> <p>Хүн бүр хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хэрэгжүүлэхдээ шүүгч болон шүүхээс үр нөлөөтэй хамгаалалт авах эрхтэй бөгөөд ямар ч тохиолдолд эрхээ хамгаалуулах боломжгүй байдалд оруулж үл болно.</p> <p style="text-align: center;">49 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг</p> <p>Төрийн эрх бүхий байгууллагууд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бие даасан байдал, нийгмийн оролцоог бүх нийтэд хүртээмжтэй орчинд хангах бодлогыг хэрэгжүүлнэ. Мөн тэдгээр иргэдийн төлөөллийн байгууллагуудын оролцоог хуульд заасан нөхцөл, журмын дагуу дэмжинэ. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд болон хүүхдүүдийн тусгай хэрэгцээнд онцгойлон анхаарал хандуулна.</p> <p style="text-align: center;">124 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг</p> <p>Прокурорын байгууллага нь бусад эрх бүхий байгууллагад хуваарилагдсан чиг үүргийг хүндэтгэн, хууль ёс, иргэдийн эрх, хуулиар хамгаалагдсан нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс шүүхийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй. Энэхүү үүргээ прокурор өөрийн санаачилгаар эсхүл хохирогч, сонирхогч талын хүсэлтээр хэрэгжүүлнэ. Мөн шүүхийн хараат бус байдлыг хангах, нийгмийн ашиг сонирхлыг шүүхийн өмнө төлөөлөн хамгаалахыг зорино.</p> <p style="text-align: center;">162 дугаар зүйлийн 1 дэх хэсэг</p> <p><i>/Энэ хэсэгт Үндсэн хуулийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээдүүдийг тодорхойлсон байна./</i></p> <p>б) Үндсэн хуулийн нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээдүүд нь хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалан хандсан аливаа хувь хүн⁷⁸ болон хуулийн этгээд, мөн Олон нийтийн эрх ашгийг хамгаалагч болон Прокурорын байгууллага байна.</p>

⁷⁸ Испани хэлээр "persona natural", Англи хэлэнд "natural person" гэж бичсэн байсан бөгөөд Монгол хэлээр "хувь хүн" гэж орчуулсан болно.



2.	Прокурорын байгууллагын дүрмийг зохицуулах хууль	<p style="text-align: center;">3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг</p> <p>Үндсэн хуулийн байгууллагууд, хүний үндсэн эрх, эрх чөлөөг хүндэтгэж байгаа эсэхэд хяналт тавих, хамгаалахтай холбоотой бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх.</p> <p style="text-align: center;">3 дугаар зүйлийн 6 дахь хэсэг</p> <p>Хууль ёсны байдал, нийтийн болон нийгмийн ашиг сонирхлыг хамгаалах, иргэний эрх зүйн байдлын асуудалтай холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон хуулиар тогтоосон бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох.</p>
3.	Захиргааны хэргийн шүүхийн харьяаллын хууль	<p style="text-align: center;">19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг</p> <p>Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй этгээдүүд:</p> <p>б) Корпорац, холбоо, үйлдвэрчний эвлэл, бүлэг болон 18-р зүйлд заасан бусад этгээдүүд, хэрэв тэд эрх ашиг нь хөндөгдсөн эсвэл хууль ёсоор бүлгийн эрх ашгийг хамгаалах эрхтэй бол.</p> <p>е) Прокурорын байгууллага нь хуулиар тогтоосон хэрэг, маргаанд оролцох эрхтэй.</p> <p>ё) Хуулийн этгээдийн статустай олон нийтийн байгууллагууд, хэрэв тухайн шийдвэр нь тэдний зорилго, чиг үүрэгт нөлөөлж байвал, нэхэмжлэл гаргах эрхтэй.</p> <p>ж) Хуульд тодорхой заасан тохиолдолд, аливаа иргэн нь олон нийтийн эрх ашгийн төлөө нэхэмжлэл гаргах эрхтэй.</p> <p>з) Тэгш харьцах эрх, ялгаварлан гадуурхах болон хүлцэлгүй хандлагын эсрэг хамгаалалтыг хэрэгжүүлэхийн тулд, хохирсон этгээдүүдээс гадна, тэдгээрийн зөвшөөрлөөр, Тэгш харьцах болон ялгаварлан гадуурхахын эсрэг бие даасан байгууллага нэхэмжлэл гаргах эрхтэй байна. Мөн, тухайн байгууллагад харьяалагддаг эсвэл гишүүнчлэлтэй этгээдүүдтэй холбогдуулан, улс төрийн намууд, үйлдвэрчний эвлэлүүд, бие даасан ажилтнуудын мэргэжлийн холбоод, хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн байгууллагууд, хүний эрхийг хамгаалах, дэмжихийг зорилгоо болгосон хууль ёсоор байгуулагдсан холбоо, байгууллагууд ч мөн эрх бүхий этгээдэд тооцогдоно. Энэ нь Тэгш харьцах болон ялгаварлан гадуурхахын эсрэг цогц хуульд заасны дагуу хэрэгжинэ.</p> <p>Хохирсон этгээдүүд тодорхойгүй бөгөөд олон тооны хүнээс бүрдэх, эсвэл тодорхойлоход хүндрэлтэй тохиолдолд, нийтлэг эрх, ашиг сонирхлыг хамгаалан шүүхийн ажиллагаа эхлүүлэх эрх нь Тэгш харьцах болон ялгаварлан гадуурхахын эсрэг бие даасан байгууллага, улс төрийн намууд, үйлдвэрчний эвлэлүүд болон хамгийн олон төлөөлөл бүхий бие даасан мэргэжлийн холбоод, мөн улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн байгууллагууд, ялгаварлан гадуурхалт үүссэн нутаг дэвсгэрийн хэмжээнд эсвэл улсын хэмжээнд хүний эрхийг хамгаалах, дэмжихийг зорилгоо болгосон байгууллагуудад хамаарна. Энэ нь Тэгш харьцах болон ялгаварлан гадуурхахын эсрэг цогц хуульд заасны дагуу хэрэгжинэ. Ямар ч тохиолдолд, хохирсон этгээдүүдийн хувьд хувь хүний нэхэмжлэл гаргах эрх хэвээр хадгалагдана.</p>



3.	Байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, олон нийтийн оролцоо болон шударга шүүхэд хандах эрхийн хууль	<p style="text-align: center;">3 дугаар зүйл</p> <p>Хүн бүрийн хөгжлийн хэрэгцээнд нийцсэн байгаль орчинд амьдрах эрхийг бодитой хэрэгжүүлэх, мөн түүнийг хамгаалах үүргийг биелүүлэхийн тулд, энэ хууль болон Иргэний хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу, төрийн байгууллагуудтай харилцахдаа дараах эрхүүдийг хүн бүр эдэлж болно.</p> <p>3) Шударга шүүхэд хандах болон захиргааны хамгаалалттай холбоотойгоор:</p> <p>б) Байгаль орчны хууль тогтоомжийг зөрчсөн төрийн байгууллагын үйлдэл болон эс үйлдэхүйг энэ хуулиар тогтоосон нөхцөл, журмын дагуу нийтийн эрх ашгийг төлөөлөх нэхэмжлэл гаргах замаар эсэргүүцэх эрхийг хэрэгжүүлэх.</p> <p style="text-align: center;">23 дугаар зүйлийн 1 дэх хэсэг</p> <p>22 дугаар зүйлд зохицуулсан олон нийтийн нэхэмжлэлийг гаргах эрх нь дараах шаардлагыг хангаснаа нотолж чадах ашгийн бус хуулийн этгээдүүдэд хамаарна:</p> <p>а) Байгууллагын дүрэмд заасан зорилгуудын дунд байгаль орчныг ерөнхийд нь, эсвэл түүний тодорхой элементүүдийг хамгаалах тухай тусгагдсан байх.</p> <p>б) Нэхэмжлэл гаргах өдрөөс өмнө дор хаяж хоёр жилийн өмнө хууль ёсны дагуу байгуулагдсан байх бөгөөд дүрэмд тусгасан зорилгод хүрэхийн тулд шаардлагатай үйл ажиллагааг идэвхтэй явуулдаг байх.</p> <p>в) Холбооны дүрэмд заасны дагуу тухайн байгууллага нь үйл ажиллагаагаа тухайн захиргааны байгууллагын үйлдэл эсвэл эс үйлдэхүйд өртсөн газар нутагт явуулдаг байх.</p>
4.	Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль	<p style="text-align: center;">4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг</p> <p>Хэрэв хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүүхдийн талаарх мэдээлэл, зураг, нэрийг нийтлэх нь түүний хувийн нууц, нэр төр, нэр хүндэд хууль бус халдлага болох эсвэл түүний эрх ашигт харш байвал, Прокурорын байгууллага (Ministerio Fiscal) нэн даруй хуульд заасан урьдчилан сэргийлэх болон хамгаалалтын арга хэмжээг авч, учирсан хохирлын төлөө нөхөн төлбөр шаардах ажиллагааг эхлүүлнэ.</p>

Үүнээс үзэхэд Испани Улс нь нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхтэй холбоотой асуудлыг бие даасан хуулиар зохицуулдаггүй бөгөөд тухайлсан салбарын болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуулиар зохицуулж байна. Харин Үндсэн хуулиар хүн бүр шүүхэд хандах эрхийг баталгаажуулсан бөгөөд прокурорын байгууллагад өөрийн чиг үүргийн хүрээнд нийтийн ашиг сонирхлыг шүүхэд хамгаалах онцгой эрх олгосон байна. Мөн байгаль орчинтой холбоотой асуудлаар нийтийн эрх ашгийг төлөөлж нэхэмжлэл гаргах эрхийг хуульд заасан шаардлагыг хангасан ашгийн бус хуулийн этгээдэд олгожээ.

Хуулийн зохицуулалтаас үзэхэд **нийтийн болон нийгмийн ашиг сонирхол** гэх нэр томъёог ашигласан байх тул эдгээр ойлголтын ялгааг тайлбарлах шаардлагатай байна. Өмнөх хэсэгт нийтийн ашиг сонирхол (исп. interés



público)-ийн талаар ойлголтыг тайлбарласан бол нийгмийн ашиг сонирхол (исп. interés social) гэдэг нь бүх талуудын⁷⁹ нийтлэг ашиг сонирхол гэдэг агуулгаар тайлбарлагдаж байна. Нэр томъёоны тайлбар, судалгааны эх сурвалжаас үзэхэд эдгээр нь хоорондоо **төстэй ойлголт** хэдий ч тухайн ойлголтын гарал үүсэл, зорилгынх нь хүрээнд тайлбарлавал нийтийн ашиг сонирхол гэдэг нь нийгмийн тодорхой бүлгийн ашиг сонирхлоор төлөөлүүлж тайлбарлаж байсан бол нийгмийн ашиг сонирхол гэдэг нь бүх талуудын ашиг сонирхол гэж ойлгож болохоор байна. Өөрөөр хэлбэл, төлөөлүүлж буй ашиг сонирхлын хүрээгээр ялгаатай байна.

4.3. Шүүхийн практик

Испани Улсын шүүхийн практикт нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргахтай холбоотой асуудал нь захиргааны хэргийн шүүхээс гадна эрүү, иргэний хэргийн болон Үндсэн хуулийн шүүхээр шийдвэрлэгддэг болохыг дурдах нь зүйтэй. Энэхүү судалгааны хүрээнд захиргааны байгууллагын шийдвэртэй холбогдуулан захиргааны хэргийн шүүхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхтэй холбоотой асуудлыг дэлгэрүүлэн судалсан болно.

Мөн судалгаа хийх явцад захиргааны хэргийн шүүхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргасан тохиолдол цөөн байх бөгөөд дийлэнх тохиолдолд иргэн, хуулийн этгээдийн субъектив эрхтэй холбоотой маргааныг шийдвэрлэсэн шүүхийн практик байна.

⁷⁹ Испани улсын хууль зүйн толь бичиг, <https://dpej.rae.es/lema/inter%C3%A9s-social>, (Сүүлд үзсэн: 2025.10.22).

*Шигтгээ 5. Испани Улсын Дээд шүүхийн нийтийн ашиг сонирхолтой холбоотой гаргасан шийдвэр***Don Secundino-ийн нэхэмжлэлтэй, Галисия (исп. Galicia) мужийн захиргаанд холбогдох, хуульд заасан журмын дагуу олон нийтийн оролцоог хангахтай холбоотой хэрэг⁸⁰**

Иргэн Don Secundino нь Галисия (исп. Galicia) мужийн захиргаанаас EDP Renovables España, S.L.U. компанид олгосон салхин цахилгаан станц барих зөвшөөрөл олгосон шийдвэр нь хуульд заасан байгаль орчны нөлөөллийн үнэлгээний дарааллыг зөрчсөн гэх агуулгаар нэхэмжлэл гаргасан байна. Тодруулбал, хууль ёсны процедур алдагдсан буюу олон нийтэд мэдээлэл өгөхөөс өмнө салбарын тайланг авсан байх ёстой гэжээ.

Анхан шатны шүүхээс нэхэмжлэлийг хангаж Галисия мужийн захиргаанаас EDP Renovables España, S.L.U. компанид олгосон зөвшөөрлийг хүчингүй болгож шийдвэрлэсэн байна.

Хариуцагч талын зүгээс кассаши (исп. casación⁸¹)-ийн гомдол гаргасан бөгөөд уг гомдолдоо шүүхээс салхин цахилгаан станцын зөвшөөрлийг хүчингүй болгосон нь төслийн хууль ёсны байдлыг алдагдуулсан бөгөөд байгаль орчны нөлөөллийн үнэлгээний үе шатны дараалал зөрчигдөөгүй. Учир нь салбарын тайлангуудыг олон нийтэд мэдээлэл өгөх үе шатнаас өмнө авах шаардлагагүй бөгөөд энэ нь хуульд заасан заавал мөрдөх дараалал биш гэж маргажээ.

Дээд шүүхээс хариуцагчийн гаргасан кассацийн гомдлыг хүлээн авч, байгаль орчны үнэлгээний үе шатны дараалал нь шүүхийн жишиг тогтооход ач холбогдолтой асуудал гэж үзээд анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, Corme G-3 салхин цахилгаан станцын зөвшөөрлийг хүчинтэй хэвээр үлдээсэн байна.

/Жич:Шүүхийн шийдвэрийг сонгохдоо хэргийн агуулга, шийдвэрлэсэн байдал бус нэхэмжлэл гаргах хүрээ, түүнд холбогдох асуудалд ач холбогдол өгсөн болно./

Нэхэмжлэгч нь захиргааны байгууллагын үйл ажиллагаа, тэр дундаа байгаль орчинтой холбоотой төсөл нь хуульд заасан журмын дагуу явагдах ёстой бөгөөд ингэснээр олон нийтийн оролцооны эрх хангагдана гэж үзэж нийтийн эрх ашгийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргасан байна. Тодруулбал, Байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, олон нийтийн оролцоо болон шударга шүүхэд хандах эрхийн хуулийн 3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу нийтийн эрх ашгийг төлөөлж нэхэмжлэл гаргасан гэж үзэж болохоор байна.

5. ЯПОН УЛС

5.1. Онолын үндэслэл, эрх зүйн тогтолцоо

Япон Улсад нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрх иргэн, төрийн бус байгууллагад нээлттэй бус байдаг. Тухайлбал, байгаль орчны асуудлаар төрийн бус байгууллагад нэхэмжлэл гаргах эрхийг нээлттэй болгох нь зүйтэй эсэх дээр онолын маргаан одоог хүртэл өрнөж байна.

Байгаль орчны асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах замаар байгаль орчныг хамгаалахын тулд үндсэн хоёр сонголт байдаг гэж дүгнэж болно. Нэгдүгээрт,

⁸⁰ STS 5708/2023- ECLI:ES:TS:2023:5708, https://www.poderjudicial.es/search_openDocument/26557785124a0a8ba0a8778d75e36f0d, (Сүүлд үзсэн: 2025.10.22).

⁸¹ Кассашийн гомдол гэдэг нь Дээд шүүхийн аль ч танхимд, тухайн танхимын мэргэшсэн чиглэлд үндэслэн гаргадаг бөгөөд доод шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох, цуцлах зорилготой байдаг, <https://dpej.rae.es/lema/casaci%C3%B3n>, (Сүүлд үзсэн: 2025.10.23).

тухайн байгаль орчны асуудлаар хөндөгдөж буй ашиг сонирхол нь нэхэмжлэгчийн өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хамааралтай гэдгийг хуулийн заалтыг тайлбарлах замаар шийдвэрлэх юм. Хоёрдугаарт, байгаль орчны асуудлаар хөндөгдөж буй ашиг сонирхол нь хувь иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхолд хамааруулж болохгүй тул нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхийг хуульчилж өгөх арга зам юм.

Судлаач Ватари Тадасү өөрийн бүтээлдээ байгаль орчны ашиг сонирхол нь хувийн ашиг сонирхол эсхүл нийтийн ашиг сонирхол гэж хоёр хэсэгт хатуу хуваагдаж ирсэн байдлыг өөрчилж гурав дахь ашиг сонирхол, хосолмол ашиг сонирхол байж болох санааг дэвшүүлсэн байна. Мөн судлаач Оцүка Тадаши хувь хүнд хамааралтай байгаль орчны ашиг сонирхол байж болох нь зүйн хэрэг тул (эрүүл мэнд, эд хөрөнгийн хохирол хүртсэн гэх мэт) түүнд хамаарахгүй байгаль орчны ашиг сонирхол гэж хувааж болох санааг дэвшүүлжээ.⁸²

Харин Обүко Норико Япон Улсад байгаль орчны асуудлаар захиргааны хэргийн нэхэмжлэл гаргахад нэхэмжлэгчийн өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн байхыг шаардах бөгөөд өнөөгийн шүүхийн шийдвэрийн жишиг дээрх "эрх, хууль ёсны ашиг сонирхол" гэдгийг хэт явцуу тайлбарлан, нэхэмжлэгчийн нэхэмжлэл гаргах эрхийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа шүүхийн хандлага өөрчлөгдөхгүй байгаа тул хууль батлах замаар асуудлыг шийдвэрлэх нь оновчтой гэсэн саналыг дэвшүүлдэг. Дээрх судлаач нар бүтээлдээ дурдсанчлан байгаль орчны ашиг сонирхол нь хэдийгээр дэлгэрүүлэн тайлбарлаж болох ч хувь хүнд хамааралтай гэж тайлбарлах боломжгүй цэвэр байгаль орчны ашиг сонирхол (нийтийн ашиг сонирхол) тул уг асуудлыг хуульчлах замаар шийдвэрлэх нь зүйтэй гэдэг дээр ихэнх судлаач санал нэгддэг байна.⁸³

5.2. Хууль тогтоомжид тусгагдсан байдал

Япон Улсад нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхтэй субъектийн талаар нарийвчлан зохицуулаагүй ч захиргааны акт, шийдвэрийг хүчингүй болгох нэхэмжлэл гаргах эрхийн тухайд дараах байдлаар зохицуулжээ.

Хүснэгт 10. Япон Улсын нийтийн ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотой хуулийн зохицуулалт

Хуулийн нэр	Хуулийн зохицуулалт
Япон Улсын Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль	9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг Захиргааны акт, шийдвэрийг хүчингүй болгох нэхэмжлэлийг зөвхөн тухайн захиргааны акт, шийдвэрийг хүчингүй болгохтой холбоотойгоор эрх, хууль, ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд гаргаж болно.
	9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг⁸⁴ Өмнөх хэсэгт заасны дагуу шүүх тухайн этгээдийн өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн эсэхийг тогтоохдоо хууль тогтоомжийн тайлбарыг харгалзан үзэхээс гадна хууль тогтоомжийн зорилгыг харгалзан үзэх, түүнчлэн захиргааны актын агуулга, мөн чанарыг харгалзан үзэх шаардлагатай.

⁸² Дам эшлэв: С.Сүхчулуун, *Байгаль орчин болон соёлын өвийг хамгаалах асуудлаар төрийн бус байгууллагад нэхэмжлэл гаргах эрхийг олгохтой холбоотой Япон Улсын өнөөгийн чиг хандлага, судалгаа 2022*, 2 дахь тал.

⁸³ Мөн тэнд, 1, 3 дахь тал.

⁸⁴ Administrative Procedure Act §9 (2)



Дээрхээс үзвэл, Япон Улсад захиргааны акт, шийдвэрийг хүчингүй болгох нэхэмжлэл гаргах эрх нь зөвхөн өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдолд нэхэмжлэл гаргах зарчимтай байна. Иймд байгаль орчны асуудлаар захиргааны хэргийн нэхэмжлэл гаргах үед тухайн зөрчигдсөн гэж үзэж буй ашиг сонирхол нь нэхэмжлэгчийн өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хамаарна гэж үзэхэд хүндрэл тулгардаг.⁸⁵

5.3. Шүүхийн практик

Шигтгээ 6. Япон Улсын нийтийн ашиг сонирхолтой холбоотой гаргасан шүүхийн шийдвэр

Кунитачи хотын оршин суугчдын бүлгийн Хотын захиргаанд холбогдох гүүр бариулахгүй байхыг шаардсан хэрэг⁸⁶

1974 онд Кунитачи хотын оршин суугчдын нэгэн бүлэг University Avenue гудамжинд гүүр барих гэрээг цуцлуулах хүсэлт гаргасан. Нэхэмжлэгчид "хүүхдийн сургууль, өдөр өнжүүлэх төвүүд энэ гүүрний ойролцоо байрладаг тул өндөр настай хүмүүс болон сургуулийн насны хүүхдүүдийн аюулгүй байдал, хүртээмжтэй байдалд аюул учруулах эрсдэлтэй" гэх үндэслэлээр шүүхэд ханджээ.

Шүүх дараах үндэслэлээр нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Тодруулбал, оршин суугчдын өөрсдийн эрх, хууль ёсны эрх ашиг хөндөгдөөгүй буюу нийтийн эрх ашиг, тав тухтай орчинд хамааралтай асуудлыг хөндөж шүүхэд нэхэмжлэл гаргах боломж нь зөвхөн хууль ёсны эрх, ашиг сонирхолтой этгээдээр хязгаарлагддаг гэж тайлбарлажээ. Оршин суугчид гүүр баригдахаас өмнө University Avenue гудамжинд явган хүний гарц ашигладаг байсан гэж дурдсан үндэслэлийг гудамжийг зөвхөн нийтийн эд хөрөнгө байдлаар ашиглахтай холбоотой давхар ашиг сонирхол гэж тодорхойлсон. Тиймээс оршин суугчид гудамжийг гүүрээр гатлах шаардлагатай болсон ч, нэхэмжлэгчдийн эрх, хууль ёсоор хамгаалагдсан ашиг сонирхол хохирсон гэж үзэхгүй. Төрийн аливаа бодлогыг хэрэгжүүлэх үед бүх нийтийн дэмжлэг, зөвшөөрлийг авахад хүндрэлтэй, зарим хүмүүс үүнтэй санал зөрөх, тааламжгүй байдал үүсгэх, төвөг учруулах тохиолдол зайлшгүй гардаг. Гэвч тэдгээр бүлэг хүмүүс байгаль орчныг хамгаалах эрхийн нэр дор шүүхийн хэрэгслийг ашиглан төрийн бодлогын хэрэгжилтийг нөлөөлбөл энэ нь захиргааны байгууллагын үйл ажиллагааг саатуулж, төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломжгүй болгож, байгууллагуудыг шахаж, улмаар "нийтийн ашиг сонирхолд сөрөг нөлөө үзүүлэх болно" гэж дүгнэжээ.

Дээрхээс үзвэл, Япон Улсад нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах эрх хязгаарлагдмал бөгөөд хуульд нарийвчлан зохицуулагдаагүй. Шүүхийн практикт нэхэмжлэгчийн өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзсэн тохиолдолд зарчмын дагуу тухайн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн гаргасан нэхэмжлэлийг хүлээж авах үндэслэлтэй гэж үздэг. Харин нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргасан нэхэмжлэгчийн өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөөгүй бол шүүх нэхэмжлэлийг хүлээж авахгүй, эсхүл хүлээж авсан тохиолдолд хэрэгсэхгүй болгож шийдвэрлэдэг жишигтэй байна.

⁸⁵ С.Сүхчулуун, *Байгаль орчин болон соёлын өвийг хамгаалах асуудлаар төрийн бус байгууллагад нэхэмжлэл гаргах эрхийг олгохтой холбоотой Япон Улсын өнөөгийн чиг хандлага*, 2022, 1–2 дахь тал.

⁸⁶ Kuniko Shibata, *The public interest in planning in Japanese jurisprudence: the limits to participatory democracy*, 2008, [https://eprints.lse.ac.uk/21676/1/The_public_interest_in_planning_in_Japanese_jurisprudence_\(LSERO\).pdf](https://eprints.lse.ac.uk/21676/1/The_public_interest_in_planning_in_Japanese_jurisprudence_(LSERO).pdf).

БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Эх газрын эрх зүйн тогтолцоотой улс орнуудын хувьд нэхэмжлэл гаргах эрх нь анх хувь хүний субъектив эрхийн хамгаалалтад төвлөрч байсан нь Франц, Португал, Герман, Испани, Япон улсуудаас харагддаг. Гэвч нийгмийн харилцаа төвөгтэй болж, хүрээлэн буй орчин, хэрэглэгчийн эрх, төрийн өмч, соёлын өв зэрэг нийтлэг үнэт зүйлсэд хохирол учрах эрсдэл нэмэгдэхийн хэрээр зөвхөн хувь хүний эрхийн хязгаарт тулгуурласан шүүхийн хамгаалалт хангалтгүй болж, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах шинэ механизмууд шаардлагатай болсон. Үүний үр дүнд тухайн судалж буй улс орнуудад "нийтийн ашиг сонирхлыг төлөөлж нэхэмжлэл гаргах" гэх ойлголт нь хууль зүйн шинэ төрөл хэлбэрээр хөгжиж, тэдгээрийн хууль тогтоомж, шүүхийн практикт тодорхой хэмжээгээр тусгагджээ.

Эдгээр улсуудын нийтлэг нэг онцлог нь эх газрын эрх зүйн уламжлалдаа нийцүүлэн "нийтийн ашиг сонирхол"-ыг төрийн хяналт ба иргэний оролцооны тэнцвэрийн хүрээнд авч үздэг байна. Нийтийн ашиг сонирхлыг хамгаалах нь нэг талаас төрийн байгууллагын хяналтын хэрэгсэл, нөгөө талаас иргэний нийгмийн оролцоог дэмжих хэлбэр гэж үздэг. Энэ нь нийтлэг эрх ашгийн төлөө шүүхэд хандах эрхийг хязгааргүй нээлттэй болгохын оронд тодорхой шалгуур, нөхцөлөөр зохицуулж, хууль ёсны ашиг сонирхол, зорилго нэгдсэн этгээдүүдэд олгодог систем юм.

Франц, Португал зэрэг улсуудын тогтолцоонд нийтийн ашиг сонирхлыг төлөөлж нэхэмжлэл гаргах тухай ойлголт илүү өргөн хүрээнд хөгжсөн. Эдгээр улсад хууль тогтоогчид иргэн, төрийн бус байгууллага, холбоо, зарим тохиолдолд прокурорт ч нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхийг олгосон байдаг. Франц Улс ЕХ-ны удирдамжид нийцүүлэн 2025 онд бүлгийн ашиг сонирхлын нэхэмжлэлийн нэгдсэн тогтолцоог бий болгосон бол Португал Улс Үндсэн хуулиараа "*actio popularis*" буюу иргэн бүрд нийтлэг ашиг сонирхлыг хамгаалах үүрэг, эрх олгосон цөөн улсын нэг юм.

Нөгөө талаар ХБНГУ, Испани, Япон зэрэг улсуудад нийтийн ашиг сонирхлыг төлөөлж нэхэмжлэл гаргах эрх илүү хязгаарлагдмал байдалтай байна. ХБНГУ-д нэхэмжлэл гаргах эрх нь ерөнхийдөө "субъектив эрх" зөрчигдсөн байх шаардлагад тулгуурладаг ч байгаль орчны болон амьтны эрхийн асуудалд хамаарах тусгай хуульд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх холбоодод онцгой эрх олгодог байна. Испани Улсын хувьд иргэдийн оролцоотой эрүүгийн болон захиргааны хяналтын хэлбэрийг хязгаарлагдмал байдлаар зөвшөөрдөг бол Япон Улсад зөвхөн тодорхой хуулиудаар заасан тохиолдолд иргэн, холбоо нийтийн эрх ашгийн төлөө нэхэмжлэл гаргаж болдог ажээ.

Нийтийн ашиг сонирхлын нэхэмжлэл нь практикт хамгийн өргөн хэрэглэгддэг салбарууд болох байгаль орчныг хамгаалах, хэрэглэгчийн эрхийг хамгаалах, ялгаварлан гадуурхалтаас хамгаалах, төрийн өмчийн ашиглалт, нийтийн эрүүл мэнд зэрэг асуудлуудад төвлөрдөг. Эдгээрээс байгаль орчны маргаан нь бүх улсын хувьд нийтлэг бөгөөд Европын орнуудад (Франц, Португал, Испани, Герман) байгаль орчныг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн бус байгууллагуудад шүүхэд хандах эрхийг олгосон байна.



Ерөнхийдөө эх газрын эрх зүйн тогтолцоонд хамаарах 6 улсад нийтийн ашиг сонирхлыг хамгаалах нэхэмжлэл нь төрийн хяналт, иргэний нийгмийн оролцоо, шүүхийн хяналтын тэнцвэр гэсэн гурван тулгуур зарчимд үндэслэн хөгжиж буй нь харагдаж байна. Хууль тогтоогчид нэхэмжлэл гаргах хүрээг аажмаар өргөтгөж, хууль ёсны ашиг сонирхлын ойлголтыг уян хатан болгож байгаа нь нийтийн эрх ашиг, шударга ёсны хэрэгжилтийг хангах чухал алхам гэж хүлээн зөвшөөрч буйтай шууд холбоотой юм. Ингэснээр эх газрын эрх зүйн бүлд багтах улс орнууд нийтийн ашиг сонирхлыг хуулиар хамгаалж, ард иргэдийн оролцоог өргөжүүлэх чиглэлд хөгжиж байна гэх дүгнэлтэд хүрлээ.

III. АНГЛО-САКСОНЫ ЭРХ ЗҮЙН БҮЛИЙН УЛСУУД

1. АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

1.1. Онолын үндэслэл, эрх зүйн тогтолцоо

АНУ нь нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах (англ. *Public interest litigation*) тогтолцоог бий болгосон анхдагч улсуудын нэг юм. Олон нийтэд зориулсан эрх зүйн хамгааллын дээрх чиглэлийг "англ. *Public Interest Law*"⁸⁷ нэршлээр ч мөн нэрлэж иржээ.⁸⁸ Энэхүү ойлголт нь 1960-аад оноос илүү дэлгэрч эхэлсэн бөгөөд тухайн оны сүүлчээр хүүхдийн асаргаа, хорих байрны шинэчлэл, агаарын бохирдол зэрэг олон асуудлаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүх байгууллагад гаргах нэхэмжлэлийн тоо ихэссэн байна.⁸⁹

Онолын хувьд нийтийн ашиг сонирхол гэх ойлголтыг хувийн ашиг сонирхлоос ялган зааглах шаардлага бий, үүний тулд "ашиг сонирхол" гэх ойлголтыг тайлбарлах нь зүйтэй юм. Судлаачдын тайлбарлаж буйгаар "ашиг сонирхол" гэдэг нь тодорхой этгээд ямарваа нэг зүйлд хандсан дотоод хандлага бөгөөд энэ нь түүний идэвх болон үйл ажиллагаа байх ба тухайн үйл ажиллагаа нь тодорхой хэрэгцээг хангах боломжтой арга хэрэгсэл, боломж, хэм хэмжээг хайх эерэг эсхүл сөрөг чиглэлээр илэрхийлэгддэг гэж тодорхойлжээ.⁹⁰ Харин "Нийтийн ашиг сонирхол" гэх ойлголт нь судлаач С.Т.Хончарук (S.T. Noncharuk)-ийн үзсэнээр "Нийгмийн тодорхой хамт олны ашиг сонирхол бөгөөд түүнийг төр хүлээн зөвшөөрч, хангах ёстой. Төрөөс нийтийн ашиг сонирхлыг хүлээн зөвшөөрөх үйл явц нь эрх зүйн харилцаагаар хэрэгждэг буюу өөрөөр хэлбэл тухайн ашиг сонирхлыг хуулиар баталгаажуулж, хэрэгжүүлэх механизмыг тогтоох хэлбэрээр илэрнэ" гэжээ.⁹¹ Нийтийн ашиг сонирхлыг заавал олон хүн, бүлэг илэрхийлэх шаардлагагүй заримдаа нэг эсвэл цөөн тооны хүн өөрийн

⁸⁷ Нийтийн ашиг сонирхолд нийцээгүй нийгэм, соёлын шударга бус практикийг өөрчлөх, засах зорилготой байна.

⁸⁸ Shubha Sinha "International P.I.L in the USA: Socio-Legal contextualization", *Journal of Education and Science Research Review*, Volume 4, Issue, 87, <https://jesrr.org/publication/44/2017%20june%20arts%20journal%20naina.pdf>, (Сүүлд үзсэн: 2025.10.15).

⁸⁹ *Ibid.*

⁹⁰ Tetiana Evgeniivna Kaganovska, "Public interest as a category of administrative and legal science, (2022), pp-7, [file:///C:/Users/serviceadmin/Downloads/Dialnet-PublicInterestAsACategoryOfAdministrativeAndLegals-8391122%20\(1\).pdf](file:///C:/Users/serviceadmin/Downloads/Dialnet-PublicInterestAsACategoryOfAdministrativeAndLegals-8391122%20(1).pdf), (Сүүлд үзсэн: 2025.10.16).

⁹¹ *Ibid*, p-8.



санаачилгаар илэрхийлэх боломжтой гэсэн байдаг.⁹² Өөрөөр хэлбэл, нийтийн ашиг сонирхлыг нэг эсхүл түүнээс дээш хэдэн ч хүн илэрхийлэн төлөөлөх боломжтой бөгөөд тухайн боломжийн нэг хэлбэр нь шүүхэд нэхэмжлэл гаргах явдал юм.

АНУ-ын эрх зүйд өргөн хэрэглэгддэг Блекийн эрх зүйн тайлбар тольд⁹³ "Нийтийн эрх ашиг" гэдэг нь 1) хүлээн зөвшөөрч, хамгаалахад хүргэдэг олон нийтийн ерөнхий сайн сайхан байдал; 2) олон нийт энэхүү эрх ашигт нэгдэж, нэн ялангуяа, төрөөс зохицуулалтыг шаарддаг гэж тайлбарлажээ. Харин Барроны (Barron) эрх зүйн тайлбар тольд⁹⁴ "Нийгэмд бүхэлд нь хамгийн их хэрэгцээтэй бөгөөд нийт хүн амын сайн сайхан гэж юу болохыг шүүгч, засаг дарга зэрэг хувь хүмүүс эсхүл хууль тогтоогчид субъектив байдлаар тодорхойлохыг ойлгоно" гэжээ.

Эрдэмтэн Теодр Лоуи (Theodore Lowi), Бенжамин Гинзберг (Benjamin Ginsberg) нарын тэмдэглэсэнээр "Нийтийн ашиг сонирхлын бүлэг нь хувийн бүлгүүдийн эсрэг утгатай, өөрийн эрх бус нийтлэг сайн сайхны төлөө ажилладаг" гэж тодорхойлдог ч бодит байдал дээр нийтийн болон хувийн ашиг сонирхлын бүлгүүдийн ялгаа тодорхой бус, хоорондоо давхцах шинжтэй байдаг гэжээ.⁹⁵

1.2. Хууль тогтоомжид тусгагдсан байдал болон шүүхийн жишиг

АНУ-д нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн ямар төрлийн, ямар салбарын асуудлаар нэхэмжлэл гаргах эрхтэйг тусгайлан хуульчлаагүй байдаг. Харин нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийн талаар Үндсэн хууль болон бусад ердийн хууль, холбогдох бусад дүрэм, журмаар зохицуулсан байна. Үүнийг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 11. АНУ-ын нийтийн ашиг сонирхлыг хамгаалах тухай холбогдох хуулийн зохицуулалт

№	Хууль	Хуулийн зохицуулалт
1.	Үндсэн хууль (англ. <i>Constitution law</i>)	Энэ хуулиар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээд ямар тохиолдолд шүүх байгууллагад хандах, ямар төрлийн маргааныг шүүхээр хянан шийдвэрлэх зэрэг анхдагч хууль эрх зүйн үндсийг бий болгодог байна. <i>Тодруулбал:</i> АНУ-ын Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг: ⁹⁶ "Шүүх эрх мэдэл нь зөвхөн талууд хоорондын шийдвэрлэх боломжтой, үнэн бодит маргаанд үндэслэн хэрэгжинэ, түүнээс бусад маргаанд үл хамаарна" гэжээ. Мөн АНУ-ын Шүүх байгууллага хянан шийдвэрлэх маргааны төрлүүдийг тус хуулиар нарийвчлан зааж өгсөн. Энэ нь иргэний шүүхэд хандах эрхийн шалгуур болдог байна.

⁹² Ibid.

⁹³ Bryan A. Garner (ed), Black's Law Dictionary, (1979), 7th ed, Minnesota: West Publishing.

⁹⁴ Steven H. Gifis, Law Dictionary, 4th ed, (1996), New York: Barron's Educational Services.

⁹⁵ Jayanth Kumar Krishnan, "Public Interest Litigation in a Comparative Context" (2011), William Mitchell Colleg of Law, pp.33-34, <https://digitalcommons.law.buffalo.edu/cgi/viewcontent.cgi?article=1104&context=bpilj>, (Сүүлд үзсэн: 2025.10.15).

⁹⁶ U.S. Constitution (1787), Article III, Section 2.



2.	Иргэний хэрэг хянан шийдвэрлэх холбооны журам (англ. <i>Federal Rules of Civil Procedure</i>)	Иргэний хэрэг хянан шийдвэрлэх холбооны журам (англ. <i>Federal Rules of Civil Procedure</i>)-ын 23 дугаар зүйлд ⁹⁷ зааснаар доорх нөхцөл хангагдсан тохиолдолд аливаа хүн болон аж ахуйн нэгж нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах боломжтой байна: <ol style="list-style-type: none"> 1. Нэхэмжлэгчдийн тоо олон байх; 2. Нэхэмжлэлийн зүйл нэг байх; 3. Нэхэмжилж байгаа хүмүүс (бүлгийн төлөөлөл эсхүл бүлгийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэгчид) бүлгийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах; 4. Нэхэмжлэл гаргаж буй этгээдүүд нь нийтийн ашиг сонирхлыг хамгаалах хангалттай чадвартай байх зэргээр нэхэмжлэл гаргаж буй этгээдэд тавигдах шалгуурыг хуульчлан зохицуулсан байна.
3.	Цэвэр усны тухай хууль (англ. <i>Clean Water Act</i>)	Цэвэр усны тухай хууль (англ. <i>Clean Water Act</i>)-ийн 33 дугаар зүйлд ⁹⁸ зааснаар "Энэ хуулийн дагуу тогтоосон усны бохирдлын стандарт, хязгаарыг зөрчсөн этгээдийн эсрэг, эсвэл уг хуульд заасан үүргээ биелүүлээгүй байгууллагын эсрэг хуульд заасан ашиг сонирхол нь сөргөөр нөлөөлөгдсөн аливаа иргэн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй" гэж заасан байдаг. Уг зохицуулалтын хүрээнд нийтийн эрх ашиг зөрчигдөж байгаа тохиолдолд иргэн, төрийн бус байгууллага ч мөн нэхэмжлэл гаргах эрхтэй байна.

Цэвэр усны тухай хуульд заасан дээрх заалттай холбоотой АНУ-ын Дээд шүүхээр шийдвэрлэгдсэн хэргээс эш татвал:

Шигтгээ 7. АНУ-ын Дээд шүүхээр шийдвэрлэгдсэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөхтэй холбоотой шүүхийн шийдвэр

<p>Earth төрийн бус байгууллага нь "Цэвэр усны тухай хууль" (англ. <i>Clean Water Act</i>)-ийн дагуу олгогдсон химийн бодис нийлүүлэх зөвшөөрөл (англ. <i>NPDES permit</i>)-ийг зөрчсөнтэй холбогдон нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхтэй эсэх тухай хэрэг⁹⁹</p> <p>Нэхэмжлэгч төрийн бус байгууллага Earth, хариуцагч "Laidlaw Environmental Services" компанид холбогдох хэрэгт хариуцагч байгууллага нь Цэвэр усны тухай хууль (англ. <i>Clean water act</i>)-ийн дагуу олгогдсон голд химийн бодис нийлүүлэх зохих стандартын хязгаарыг зөрчиж, Өмнөд Каролина мужийн "North Tyger" голд химийн хорт бодис хэтрүүлэн нийлүүлсэн нь нийтийн ашиг сонирхолд бодит хохирол (англ. <i>actual and particularized injury</i>) учруулсан хэмээн маргалджээ. Энэ нь нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргасан төрийн бус байгууллагын гишүүд "North Tyger" голд усанд сэлэх, загасчлах, амрах зэрэг үйл ажиллагаанд оролцдог байсан бөгөөд тухайн үйл ажиллагааг явуулах боломжгүй болсон гэх баримтаар нотлогдсон байна.</p> <p>Шүүхээс Цэвэр усны тухай хуулийн 1365-р зүйлд (англ. <i>Citizen Suit Provision</i>) "Өөрийн ашиг сонирхол нь сөргөөр нөлөөлөгдсөн эсхүл нөлөөлөгдөж болзошгүй аливаа иргэн" гэж заасныг үндэслэн нийтийн эрх ашиг тодорхой хохирол учирч байгаа тохиолдолд иргэн, байгууллага тэднийг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхтэй гэж үзэн нэхэмжлэлийг үндэслэлтэй гэж шийдвэрлэжээ.</p>

⁹⁷ Federal Rules of Civil Procedure (1938), <https://www.law.cornell.edu/rules/frcp>, (Сүүлд үзсэн: 2025.10.15).

⁹⁸ Clean Water Act (CWA), 33 U.S.C. § 1365.

⁹⁹ Friends of the Earth v. Laidlaw Environmental Services (2000), <https://supreme.justia.com/cases/federal/us/528/167/>, <https://www.casebriefs.com/blog/law/constitutional-law/constitutional-law-keyed-to-chemerinsky/the-federal-judicial-power/friends-of-the-earth-incorporated-v-laidlaw-environmental-services/>, (Сүүлд үзсэн: 2025.10.16).



Энэ шийдвэр нь АНУ-д нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл (англ. citizen suit) гаргах эрхийн үндсэн жишиг болсон байна. Мөн Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар иргэн, төрийн бус байгууллага шүүхээр хэрэг маргаан хянан шийдвэрлүүлэх эрхийг хуульчилж өгсөн бөгөөд бусад холбогдох хуульд дээрх эрхийг ямар байдлаар хэрэгжүүлэх боломжтойг хуульчилсан байна.

Нэхэмжлэл гаргах эрхийн хүрээ, хязгаар, үндэслэл, эрх бүхий этгээд, маргааны төрөл

АНУ-ын эрх зүйн тогтолцоонд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхийн хүрээ хязгаарыг хуулиар тусгайлан заагаагүй байдаг. Гэсэн хэдий ч ердийн хуулиуд болон бусад хууль тогтоомжид зааснаас үзэхэд нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээдийг хоёр үндсэн хэсэгт хуваан үзэж болохоор байна. Үүнд:

Төрийн байгууллага (англ. *Public enforcement*): Хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд нийтийн ашиг сонирхлыг төлөөлж төрийн байгууллагын нэрийн өмнөөс нэхэмжлэл гаргах талаарх зохицуулалт байдаг. Холбооны хуулиудад зааснаар холбооны байгууллагууд нэхэмжлэл гаргах саналыг (англ. Recommendation) Ерөнхий прокурорт (англ. U.S. Attorney general) хүргүүлж шүүхэд нэхэмжлэлийг гаргадаг байна¹⁰⁰.

АНУ-ын Конгрессоос зарим агентлагт **бие даан шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг олгосон** байдаг. Үүнд холбооны худалдааны комисс, Үндэсний хөдөлмөрийн харилцааны зөвлөл зэрэг байх бөгөөд хуульд заасан эрхийн хүрээнд нэхэмжлэл гаргах бүрэн эрхтэй. Үүнийг тус агентлагуудад холбогдох хуулиар зохицуулсан байна.

Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд гаргаж буй нэхэмжлэлийн тодорхой хувийг байгаль орчинтой холбогдох маргаанууд эзэлдэг. Тус улсад Байгаль орчны агентлаг (англ. Environmental protection agency, EPA) үйл ажиллагаа явуулдаг, энэ нь холбооны агентлагуудын нэгд багтдаг ч дээр дурдсанчлан бие даан шүүхэд нэхэмжлэл гаргах эрхгүй байна. **Шүүхэд нэхэмжлэл гаргахдаа заавал Ерөнхий прокуророор дамжуулан нэхэмжлэл гаргах эрхтэй** байхаар зохицуулжээ.

Тухайлбал: АНУ-ын Холбооны хууль (United States Code, U.S.C.)-ийн 28-§516¹⁰¹:

"Хуульд өөрөөр заагаагүй бол АНУ-ын агентлаг, эсхүл түүний албан тушаалтан оролцож буй, оролцох шаардлагатай хэрэг, маргаан нь Ерөнхий прокурорын удирдлага дор явагдаж, Хууль зүйн яамны харьяалалд хамаарна." гэж зааснаар дээрх агуулгыг хуульчилсан байна.

¹⁰⁰ United States Code, (2018), 28 U.S.C, §516 "Except as otherwise authorized by law, the conduct of litigation in which the United States, an agency, or officer thereof is a party, or is interested, and securing evidence therefor, is reserved to officers of the Department of Justice, under the direction of the Attorney General".

¹⁰¹ United States Code, U.S.C, (2018).



Хүснэгт 12. АНУ-ын хуульд заасан эрхийн хүрээнд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрх бүхий байгууллагуудын жишээ

№	Нэхэмжлэл гаргах байгууллага	Хууль	Хуулийн заалт
1.	Холбооны агентлаг (англ. <i>Federal Agencies</i>)	Federal Trade Commission Act-ийн 45(a)	"Худалдаанд нөлөөлөх шударга бус өрсөлдөөн болон хуурмаг эсвэл залилан мэхлэх үйлдэл, практикийг энэ хуулиар хууль бус үйлдэл гэж үзнэ. Холбооны Худалдааны Комисс (агентлаг) нь эдгээрийг нийтийн ашиг сонирхлын үүднээс худалдаанд нийлүүлэхийг хориглох эрх, үүрэгтэй" гэж заасны дагуу шударга бус өрсөлдөөнийг үзүүлж буй тохиолдолд нийтийн ашиг сонирхлын үүднээс нэхэмжлэл гаргах эрхтэй байна.
2.	Холбооны агентлаг (англ. <i>Federal Agencies</i>)	Federal Trade Commission Act-ийн 53(b) ¹⁰²	"Хэрэв Холбооны худалдааны комиссоос тухайн этгээд Худалдааны комиссын хяналт тавих (хэрэгжүүлэх) хуулийг зөрчиж байгаа эсвэл зөрчих боломжтой гэж үзэж, уг зөрчлийг зогсоох нь "нийтийн ашиг сонирхолд нийцнэ" гэж үзвэл АНУ-ын дүүргийн шүүхэд нэхэмжлэл гаргаж, уг үйлдлийг хориглох боломжтой" буюу өөрсдийн саналаар нэхэмжлэл гаргах боломжтой байна.
3	Байгаль орчны агентлаг (англ. <i>Environmental protection agency</i>):	Цэвэр агаарын тухай хууль (англ. <i>Clean Air Act</i>), Цэвэр усны тухай хууль, Нөхөн сэргээлтийн тухай хуульд	АНУ-д энэ агентлаг нь нийтийн ашиг сонирхлын үүднээс ихэвчлэн тус хуулиудад зааснаар нэхэмжлэл гаргах эрхтэй байна.
4.	Байгаль орчны агентлаг (EPA)	Цэвэр агаарын тухай хууль (Clean Air Act)	42-§ 7413(b) "Ерөнхий прокурор нь EPA-ийн хүсэлтээр аливаа этгээд агаарын чанарын журам, стандарт, зохих зөвшөөрлийг зөрчсөн бол шийтгэл ногдуулах, хориг тавих, шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй байна.
5.	Байгаль орчны агентлаг (EPA)	Аюултай, хорт бодисын хяналтын тухай хууль (TSCA)	5-§ 2619(a) Байгаль орчны агентлаг нь аюултай, хорт химийн бодисын хэрэглээ, үйлдвэрлэл, экспорт, импорт зөрчигдсөн тохиолдолд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхтэй.

Цэвэр агаарын тухай хуульд заасны дагуу тус улсын Давж заалдах шатны шүүх нийтийн ашиг сонирхолтой холбоотой хэргийг хянан шийдвэрлэдэг байна. Давж заалдах шатны шүүхийн шийдвэрлэсэн хэргээс эш татвал:

¹⁰² *Ibid.*



Шигтгээ 8. АНУ-ын Давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэгдсэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөхтэй холбоотой шүүхийн шийдвэр

Цэвэр агаарын тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн нь нийтийн ашиг сонирхолд сөргөөр нөлөөлж буй тухай хэрэг¹⁰³

АНУ-ын Ерөнхий прокурор, Байгаль орчны агентлагийн (англ. EPA) саналаар "EME Homer City Generation" компанид холбогдуулан гаргасан нэхэмжлэлд дурдсанаар хариуцагч нь тус улсын Пеннсилвани мужид цахилгаан станц ажиллуулдаг хувийн хэвшлийн байгууллага юм. Тус компани нь цахилгаан үйлдвэрлэх хэрэгцээ бүхий тоног төхөөрөмжийг өргөтгөж шинэчилсэн бөгөөд үүнийгээ Байгаль орчны агентлаг буюу EPA-д урьдчилан мэдэгдээгүй буюу Цэвэр агаарын тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн байна гэжээ. Мөн тус компанийн цахилгаан үйлдвэрлэх үйл ажиллагааны явцад агаарт ялгаруулж буй хүхрийн диоксид, азотын исэл зэрэг агаар бохирдуулах химийн бодисын хэмжээ хуульд заасан тодорхой стандартаас хэтэрсэн нь тогтоогдсон байна.

Нэхэмжлэгч үүнийг нийтийн ашиг сонирхолд сөргөөр нөлөөлсөн буюу нийтийн эрүүл мэнд, амьдрах орчны чанар буюу агаарын орчин, тус компанийн ойролцоо оршин суух оршин суугчдын бодит ашиг сонирхолд хохирол учруулж байна гэж үзжээ.

Шүүхээс дээрх маргааныг шийдвэрлэхдээ хариуцагч нь хууль заасан тодорхой зүйлүүдийг зөрчсөн буюу компанийн цахилгаан үйлдвэрлэх төхөөрөмжийг өргөтгөсөн талаарх мэдээллийг урьдчилан зохих ёсны байгууллагад мэдэгдээгүй нь хууль зөрчсөн үйлдэл мөн хэдий ч тус маргааныг шийдвэрлэх хугацаа хэдийн өнгөрсөн байна.

Харин хуулиар хориглосон химийн бодисыг зохих хэмжээнээс хэтрүүлэн агаарт нийлүүлж байгаа нь одоо болон ирээдүйд нийтийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх боломжтой байх тул тус асуудлаар хуульд заасны дагуу стандартад нийцүүлэн үйл ажиллагаа явуулахыг сануулж, EPA-ийг урьдчилан хориглох арга хэмжээ авах эрхтэй гэж үзсэн байна.

Хувь хүн, төрийн бус байгууллага: Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн иргэн, төрийн бус байгууллага нэхэмжлэл гаргах ойлголтыг тус улсад "citizen suit" гэж нэрлэжээ. Тус агуулгыг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар (англ. Administrative procedure act) болон бусад ердийн хуулиудаар өргөжүүлэн зохицуулсан байна. Тухайлбал Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (англ. Administrative procedure act)-ийн 5-§702:¹⁰⁴-т *"Захиргааны байгууллага, Агентлагийн үйл ажиллагааны улмаас хохирол учирсан, эсхүл тухайн үйл ажиллагааны улмаас өөрт сөргөөр нөлөөлсөн гомдолтой байгаа этгээд дээрх маргааныг шүүхээр хянан шийдвэрлүүлэх эрхтэй"* гэж заасныг үндэслэн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй байна.

АНУ-д нийтийн эрх ашгийн төлөөх нэхэмжлэлийг нийтийн үйлчилгээний томоохон байгууллага болох бүх шатны сургууль, хорих байгууллага, сэтгэцийн эмнэлэг, цагдаагийн байгууллага, улсын орон сууц хангамжийн газар зэрэг байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой гарсан хэрэг маргаан, нэн ялангуяа, эдгээр байгууллагуудад урт хугацааны бүтцийн өөрчлөлт хийх,

¹⁰³ Шийдвэрийг дэлгэрэнгүй үзэх холбоос: United States v. EME Homer City Generation, L.P., 727 F.3d 274 (3d Cir. 2013), <https://app.midpage.ai/document/united-states-v-eme-homer-1038028?utm>. (Сүүлд үзсэн: 2025.10.22)

¹⁰⁴ U.S. Administrative procedure act (1946). <https://www.law.cornell.edu/uscode/text/5/702>. (Сүүлд үзсэн: 2025.10.22)



хяналтыг сайжруулахтай холбоотойгоор өргөн хүрээнд гаргах боломжтой гэх судалгаа бий.¹⁰⁵

2. ИХ БРИТАНИ УМАРД ИРЛАНДЫН НЭГДСЭН ХААНТ УЛС

1.1. Онолын үндэслэл, эрх зүйн тогтолцоо

Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс (цаашид "ИБУИНХУ" гэх)-д 1977 болон 1980 оны эхэн үеийн Дээд шүүхийн журам (англ. *Rules of the Supreme Court*)-ийн нэмэлт өөрчлөлт, мөн 1981 оны Дээд шүүхийн тухай хууль (англ. *Supreme Court Act*) батлагдсантай холбоотойгоор "шүүхийн хяналт" (англ. *judicial review*) хэмээх ойлголт анх танилцуулагджээ.¹⁰⁶ Үүний гол агуулга нь аливаа хүн шүүхэд нэхэмжлэл гаргахын тулд хангалттай хэмжээнд ашиг сонирхол нь хөндөгдсөн байх (англ. *sufficient interest*) шаардлагатай, өөрөөр хэлбэл нэхэмжлэл гаргаж буй этгээд өөрт хамааралтай асуудлаар нэхэмжлэл гаргах нь зүйтэй гэх үзэл баримтлал хууль, тогтоомжид туссан гэж үзэж болно.¹⁰⁷ Харин энэхүү шаардлагыг уян хатан байдлаар тайлбарлан авч үзэх нь зүйтэй хэмээн үздэг асуудал бол нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах явдал юм. Тодруулбал, шүүхээс тухайн тохиолдол буюу хэрэг бүрийн онцлог, нэхэмжлэгч этгээдийн тухайн нэхэмжлэлийг гаргаж буй үндэслэл, тайлбар, болон хэргийн оролцогч нарыг харгалзан үзсэний үр дүнд нэхэмжлэлийг хүлээн авах эсэхийг шийдвэрлэдэг гэж үзэж болохоор байна.¹⁰⁸

1990-ээд оноос эхлэн төрийн бус байгууллага (англ. *non governmental organization*)-ууд олноор байгуулагдан, үйл ажиллагаагаа явуулж эхлэх болсон ба үүнтэй холбоотойгоор нийтийн эрх ашгийг төлөөлөн нэхэмжлэл гаргаж эхэлсэн гэж үздэг. Энэ нь төрийн бус байгууллага нь олон нийтийн дуу хоолой болж, тэдний эрх ашгийг хамгаалах хэрэгсэл болдог гэх тайлбартай уялдах боломжтой талаар судлаачид мөн дурджээ.¹⁰⁹ Ийнхүү эдгээрт үндэслэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргаж байгаагийн цаад шалтгааныг хүрээлэн буй орчныг хамгаалах, мөн хэн нэг этгээдийн эрх ашиг хамгаалагдаггүй үлдэхээс сэргийлэх хэмээн тайлбарлах нь ч бий.¹¹⁰ Практикт нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах дийлэнх тохиолдолд нэхэмжлэгч нь төрийн бус

¹⁰⁵ Charles F Sabel and William H Simon, "Destabilization Rights: How Public Law Litigation Succeeds" *Harvard Law Review* 117 (2004), pp. 1016-1017.

¹⁰⁶ Jason Varuhas, University of Cambridge Faculty of Law, The Public Interest Conception of Public Law: Its Procedural Origins and Substantive Implications, 61/2014, 2014, p.2, https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract_id=2508981, (Сүүлд үзсэн: 2025.10.21).

¹⁰⁷ The Administrative Court Judicial Review Guide 2024, page 29, 6.3.2.1 https://www.judiciary.uk/wp-content/uploads/2024/09/24.85_HMCTS_Administrative_Court_Guide_2024_WEB1.pdf, (Сүүлд үзсэн: 2025.10.21).

¹⁰⁸ Standing in judicial review proceedings: no 'carte blanche' for public interest groups, 2022, https://www.linklaters.com/en-us/knowledge/publications/alerts-newsletters-and-guides/2022/march/22/standing-in-judicial-review-proceedings-no-carte-blanche-for-public-interest-groups?utm_, (Сүүлд үзсэн: 2025.10.21).

¹⁰⁹ The Public Law Project, Third Party Interventions-a practical guide, 2008, 3, https://publiclawproject.org.uk/content/uploads/data/resources/120/PLP_2008_Guide_3rd_Party_Interventions.pdf?utm_, (Сүүлд үзсэн: 2025.10.21).

¹¹⁰ The Resurgence of Standing in Judicial Review, Standing and Its Resurgence, 2024, https://academic.oup.com/ojls/article/44/2/313/7629062?utm_, (Сүүлд үзсэн: 2025.10.21).

байгууллага байдаг ба сайн дурын байгууллага, орон нутгийн байгууллага зэрэг нь нэхэмжлэл гаргадаг байна.¹¹¹ Мөн нийтийн ашиг сонирхол хөндөгдөж буй хэрэг гэдэгт олон нийт эсхүл түүний томоохон хэсэгт нөлөөлөх хэргийг ойлгодог ба дийлэнх тохиолдолд хүрээлэн буй орчин болон хүний эрхийг хамгаалах асуудлаар нэхэмжлэл гардаг байна.

2.2. Хууль тогтоомжид тусгагдсан байдал болон шүүхийн жишиг

ИБУИНХУ-ын хувьд хууль болон жишиг шийдвэрийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 13. ИБУИНХУ-ын нийтийн ашиг сонирхлыг хамгаалах тухай холбогдох хуулийн зохицуулалт

№	Хуулийн нэр	Хуулийн зохицуулалт
1.	Дээд шатны шүүхийн тухай хууль (англ. <i>Senior Courts Act 1981</i>) ¹¹²	31. Шүүхэд нэхэмжлэл/хүсэлт гаргах (англ. <i>Application for judicial review</i>) Дээд шатны шүүх (англ. <i>The High Court</i>) (2B) Шүүхээс нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн гаргаж буй нэхэмжлэлийг хүлээн авна. (3D) Хэрэв шүүхээс захиргааны байгууллага өөр шийдвэр гаргасан, өөрөөр хэлбэл гаргасан алдаагаа зассан ч адил үр дүнд хүрэх буюу ямар нэг өөрчлөлт гарахгүй гэж үзвэл нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн авахаас татгалзах эрхтэй. (3E) Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн гаргасан нэхэмжлэлд (3D)-д заасан шаардлага хамаарахгүй. (3F) Хэрэв шүүх 3E-д заасны дагуу зөвшөөрөл олгох тохиолдолд ийнхүү зөвшөөрөх үндэслэл байгааг бататгах ёстой.
2.	Шүүх болон хуулийн хяналтын журам (англ. <i>Judicial review and Statutory review</i>) ¹¹³	54.11 (a) Шүүхээс Дээд шатны тухай хуулийн 31(3F) хэсэгт заасан нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн гаргаж буй нэхэмжлэлийг хүлээн авсан тухай захирамжийг гаргана. 54.11A (1) (b) нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргаж байгаа тохиолдолд шүүхээс тухайн нэхэмжлэлийг заавал хүлээж авна.

Хүснэгт 13-т ИБУИНХУ-д нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргахтай холбоотой 2 хууль (журам)-ын холбогдох заалтын жишээг харуулав. Тухайн хуулиудаар дээд шатны шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйл нь Дээд шатны шүүхэд төрийн байгууллагуудын шийдвэр, үйл ажиллагааны хууль ёсны байдлыг хянуулах эрхийг хуульчилсан байна.

¹¹¹ Justice, To Assist the Court: Third Party Interventions in the Public Interest, 2016, p.6, https://files.justice.org.uk/wp-content/uploads/2016/06/06170721/To-Assist-the-Court-Web.pdf?utm_ Сүүлд үзсэн: 2025.10.21).

¹¹² Senior Courts Act, 1981, <https://www.legislation.gov.uk/ukpga/1981/54/section/31>. Сүүлд үзсэн: 2025.10.21).

¹¹³ Part 54-Judicial review and statutory review, https://www.justice.gov.uk/courts/procedure-rules/civil/rules/part54?utm_. (Сүүлд үзсэн: 2025.10.21).



Хүснэгт 14. ИБУИНХУ-ын нийтийн ашиг сонирхлыг хамгаалах тухай холбогдох шүүхийн жишиг шийдвэр

№	Шүүхийн шийдвэрийн нэр	Шүүхийн шийдвэрийн агуулга
1.	R v Inland Revenue Commissioners, ex p. National Federation of Self-Employed (NFSE) 1982 ¹¹⁴	Үндэсний хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон жижиг дунд бизнес эрхлэгчдийн холбооноос зарим төрлийн ажилчдад ногдуулж буй татвар нь тэгш бус байна хэмээн Дотоодын төсвийн орлого болон татвар хариуцсан байгууллагын шийдвэрийг эсэргүүцэн нэхэмжлэл гаргасан байна. Үүссэн гол хууль зүйн асуудал нь өөрт шууд хамааралгүй асуудлаар захиргааны байгууллагын шийдвэрийг хүчингүй болгуулахаар хандах боломжтой эсэх байв. Шүүхээс энэхүү нэхэмжлэлийг хүлээн авснаар нийтийн ашиг сонирхлыг хэрхэн хянах, шууд эрх ашиг нь үл хөндөгдөж буй байгууллага төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхийн талаар анхлан гарсан шийдвэр гэж тооцогддог байна.
2.	R v Secretary of State for Foreign and Commonwealth Affairs, ex parte World Development Movement Ltd [1995] ¹¹⁵	Их Британийн Засгийн газар нь гадаад харилцааны газраараа дамжуулан 234 сая паундыг Малайз улсын цахилгаан станцыг байгуулах ажилд зориулсан ба үүнийг "Дэлхийн хөгжлийн хөдөлгөөн" төрийн бус байгууллага тухайн шийдвэрийг эдийн засгийн хувьд алдагдалтай, хууль бус хэмээн маргасан ба энэхүү маргааны гол хууль зүйн асуудал нь нэхэмжлэгч төрийн бус байгууллага хангалттай сонирхол илэрхийлэх эрхтэй этгээд мөн эсэх дээр үүссэн байна. Дээд шүүхээс тухайн төрийн бус байгууллага нь уг асуудлаар нэхэмжлэл гаргах эрхтэй, учир нь олон нийтэд хамаарах, чухал асуудал мөн, уг асуудлаар өөр нэхэмжлэл гаргах боломжтой субъект байхгүй, улс төрийн бус, ач холбогдол бүхий чухал зорилгоор хандаж байгаа тул нэхэмжлэл гаргах эрхтэй хэмээн шийдвэрлэжээ. Энэ нь аливаа төрийн бус байгууллага өөрийн зорилгодоо нийцсэн, өөрт ач холбогдолтой асуудлаар нэхэмжлэл гаргаж байгааг шүүхээс харгалзан үзсэнээр хүлээн авч шийдвэрлэх, мөн тухайн асуудлаар өөр субъект нэхэмжлэл гаргах боломжийг харгалзан үзэх жишиг тогтоосон шийдвэр хэмээн үздэг байна.

Хүснэгт 14-т ИБУИНХУ-д нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрх бүхий субьекттэй холбоотой шүүхийн жишиг шийдвэрийг жишээгээр дурдсан бөгөөд тухайн шийдвэрүүдээр төрийн бус байгууллага өөрт шууд хамааралгүй асуудлаар захиргааны байгууллагын шийдвэрийг хүчингүй болгуулах эрхийн зарчмыг хүлээн зөвшөөрч тус шийдвэрүүд нь жишиг болсон байдаг.

¹¹⁴ Case Summary: R (ex parte National Federation of Self-Employed and Small Businesses Limited) –v- Commissioners of Inland Revenue [1981] UKHL 2, <https://www.pila.ie/resources/case-summary-r-ex-parte-national-federation-of-self/>. (Сүүлд үзсэн: 2025.10.21).

¹¹⁵ Lord Justice Rose and Mr Justice Scott Baker v The Secretary of State for Foreign Affairs ex parte the World Development Movement limited, 10th November 1994, <https://www.bailii.org/ew/cases/EWHC/Admin/1994/1.html>. (Сүүлд үзсэн: 2025.10.21).

Эдгээрээс үзвэл ИБУИНХУ-ын тогтолцооны үндсэн зарчим нь нэхэмжлэгч нь тухайн асуудалд хангалттай ашиг сонирхолтой байх ёстой бөгөөд энэ шаардлагыг уян хатан тайлбарлан, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах боломжийг шүүх харгалзан үздэг байна. 1990-ээд оноос төрийн бус байгууллагууд олон нийт, хүрээлэн буй орчин, хүний эрхийг хамгаалах зорилгоор шүүхэд нэхэмжлэл гаргах болсон бөгөөд энэхүү эрхийг тус улсын шүүх өөрийн жишиг шийдвэрүүдээрээ баталгаажуулжээ.

3. БҮГД НАЙРАМДАХ ЭНЭТХЭГ УЛС

3.1. Онолын үндэслэл, эрх зүйн тогтолцоо

БНЭУ-д нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах боломжтой болсон нь 1970-аад оны сүүлийн жилүүдэд тус улсад тогтоод байсан онц байдал цуцлагдаж¹¹⁶ хэвийн үе ирсэн, нийгмийн эмзэг бүлгүүдийн эрх ашгийг авч үзэх шаардлагатай болсон үйл явдлуудтай холбоотой байв. Ингэснээр хууль зүйн уламжлалт "locus standi" буюу эрх ашиг нь зөрчигдсэн этгээд нэхэмжлэл гаргах эрхийн ойлголт бага багаар өөрчлөгдөж эхэлсэн байна¹¹⁷. Тодруулбал БНЭУ-ын шүүх 1980-аад оноос эхлээд шийдвэртээ Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлд заасан "Амьд явах эрх"-д эрүүл мэнд, боловсрол, цэвэр орчин, нэр төртэй байх эрхийг багтана гэж тайлбарласан бөгөөд хорих анги дахь хүчирхийлэл, байгаль орчны доройтол зэрэг тогтолцооны асуудлуудыг нийтийн ашиг сонирхлын хүрээнд авч үзэх болжээ¹¹⁸. Үүнийг дагаад төр, нийтийн ашиг сонирхлын хүрээ өргөсөж, түүнийг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхтэй субъектүүд нэмэгджээ.

БНЭУ-ын хувьд жишгийн эрх зүйн бүлд багтах улс гэдэг утгаараа нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхтэй субъект, түүний хүрээг шүүх шийдвэрээрээ өргөсгөж, ерөнхий зарчмыг гаргаж ирсэн байдаг. Тухайн ерөнхий шинжтэй зарчим тус улсад бий болсноор материаллаг хуулиар нэхэмжлэл гаргах эрхийн хүрээ улам бүр өргөссөн ажээ.

3.2. Хууль тогтоомжид тусгагдсан байдал болон шүүхийн жишиг

Дээр дурдсанчлан БНЭУ-ын хувьд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхтэй субъектүүд нь бичигдмэл хууль болон шүүхийн жишиг шийдвэрээр тодорхойлогддог. Үүнд БНЭУ-ын Үндсэн хууль түүнд үндэслэн гарсан салбарын хуулиуд, Дээд шүүхийн жишиг болсон шийдвэрүүд багтдаг байна. Эдгээрийг хүснэгтээр үзүүлбэл:

¹¹⁶ БНЭУ-д улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалан 1975–1977 онд онц байдал тогтоож байв.

¹¹⁷ Anuj Bhuwania, *Courting the People: Public Interest Litigation in Post-Emergency India* (Oxford: Oxford University Press, 2017), <https://academic.oup.com/icon/article/16/2/710/5036475>, (Сүүлд үзсэн: 2025.10.22).

¹¹⁸ "The Role of the Indian Judiciary in Enforcing Human Rights: Constitutional Safeguards, Judicial Interpretation, and Mechanisms for Accountability in a Complex Legal Landscape," *International Journal of Creative Research Thoughts* 11, no. 4 (2025), <https://ijcrt.org/papers/IJCRT2504484.pdf>, (Сүүлд үзсэн: 2025.10.22).


Хүснэгт 15. БНЭУ-ын нийтийн ашиг сонирхлыг хамгаалах тухай холбогдох хуулийн зохицуулалт

№	Хуулийн нэр	Хуулийн зохицуулалт
1.	БНЭУ-ын Үндсэн хууль ¹¹⁹	<p>32 дугаар зүйл. Энэ хэсэгт олгогдсон эрхийг хамгаалах</p> <p>(1) Энэ хэсэгт олгогдсон эрхийг хэрэгжүүлэхийн тулд зохистой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны (англ. appropriate proceedings) журмаар Дээд шүүхэд хандах эрхтэй байна.</p> <p>(2) Дээд шүүх нь энэ хэсгээс олгосон аливаа эрхийг хэрэгжүүлэхэд тохиромжтой байж болох шүүхийн өмнө авчрах (habeas corpus), төрийн эрх бүхий байгууллагыг албадах (mandamus), хэрэг хянан шийдвэрлэх ажиллааг зогсоох (prohibition), төрийн албан тушаалд өргөдөл гаргаж байгаа нь хууль ёсны эсэх (quo warranto) болон дээд шатны шүүх доод шатны шүүхийн хянах чиг үүрэг (certiorari) шинж чанартай заавар, тушаал, захирамж гаргах эрхтэй.</p>
2.	Байгаль орчныг хамгаалах тухай хууль ¹²⁰	<p>19 дүгээр зүйл. Зөрчлийн тухай гомдол хүлээн авах</p> <p>(b) тогтоосон журмын дагуу жараас доошгүй хоногийн дотор гомдол гаргах хүсэлтэй байгаа тухайгаа Төв засгийн газар, эсхүл дээр дурдсан эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдсэн аливаа этгээд.</p>
3.	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль ¹²¹	<p>2 дугаар зүйл. Тодорхойлолт</p> <p>(5) "гомдол гаргагч" гэдэгт: (i) хэрэглэгч; (ii) аль нэг хуулийн дагуу бүртгэлтэй хэрэглэгчдийн сайн дурын холбоо; (iii) Төв Засгийн газар эсвэл аль нэг муж улсын засгийн газар; (iv) төрийн байгууллага; (v) ижил сонирхолтой олон хэрэглэгчид байгаа нэг буюу хэд хэдэн хэрэглэгч; (vi) хэрэглэгч нас барсан тохиолдолд түүний хууль ёсны өв залгамжлагч буюу хууль ёсны төлөөлөгч; (vii) хэрэглэгч насанд хүрээгүй бол түүний эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч.</p>

Дээрхээс үзвэл БНЭУ-ын Үндсэн хуульд нийтийн ашиг сонирхлыг хамгаалах эрхийн ерөнхий зарчим болох шүүхээр эрхээ хамгаалуулах зарчмыг тусгажээ. Уг заалтад үндэслэн материаллаг хуулиар ямар субъект нэхэмжлэл гаргах эрхтэй талаар нарийвчлан заасан байна. Тухайлбал салбарын хуулиудад иргэн, төрийн байгууллага, төрийн бус байгууллага, холбоод зэрэг нэлээдгүй олон субъект нэхэмжлэл гаргах эрхтэй байгаа нь ажиглагдаж буй юм.

¹¹⁹ Government of India, Constitution of India – Legislative Department, <https://legislative.gov.in/constitution-of-india/>, (Сүүлд үзсэн: 2025.10.21).

¹²⁰ Government of India. The Environment (Protection) Act, 1986, https://www.indiacode.nic.in/bitstream/123456789/6196/1/the_environment_protection_act%2C1986.pdf, (Сүүлд үзсэн: 2025.10.21).

¹²¹ Government of India. The Consumer Protection Act, 2019. Ministry of Law and Justice, <https://www.indiacode.nic.in/bitstream/123456789/16939/1/a2019-35.pdf>, (Сүүлд үзсэн: 2025.10.21).



Хүснэгт 16. БНЭУ-ын нийтийн ашиг сонирхлыг хамгаалах тухай холбогдох шүүхийн жишиг шийдвэр

№	Шүүхийн шийдвэрийн нэр	Шүүхийн шийдвэрийн агуулга
1.	S.P. Gupta v. Union of India (1981)- <i>"Judges' Transfer Case"</i> ¹²²	<p>Шүүгчийг шилжүүлэх (англ. 'Judges' Transfer Case) гэх хэрэг нь Энэтхэг Улсад нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн иргэн нэхэмжлэл гаргах эрхтэй гэдгийг Дээд шүүхээс тогтоосон анхны хэрэг байв. Үйл баримтын хувьд Энэтхэг Улсын Дээд шүүхийн шүүгчдийг зөвшөөрөлгүйгээр шилжүүлдэг Энэтхэгийн төв Засгийн газрын практикийг S.P.Gupta болон бусад өмгөөлөгчид эсэргүүцэж нэхэмжлэл гаргасан.</p> <p>Тухайн үед шүүгчдийн олонхыг төлөөлж байсан P.N.Bhagwati шүүгч шийдвэртээ Үндсэн хуулийн 32 дугаар зүйлд заасан "зохистой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа" гэдэг нь шүүхэд хандах боломжтой хүмүүст төдийгүй бүх иргэдэд утга учиртай байх ёстой гэж зарчмын үүднээс тайлбарласан байна.</p> <p>Энэхүү хэргийн гол үр дүн нь Шүүх нийтийн ашиг сонирхлын маргааныг төрийн үйл ажиллагаа иргэнд шууд нөлөөлөөгүй байсан ч түүнийг иргэд эсэргүүцэх хууль ёсны хэрэгсэл болгон баталсан явдал байв. Энэ нь шударга ёсны хүртээмжийг өргөжүүлж, олон нийтийн өмнөөс Үндсэн хуулийн үнэт зүйлсийг хамгаалах боломжийг олгожээ.</p>
2.	People's Union for Democratic Rights (PUDR) v. Union of India (1982) ¹²³	<p>PUDR v. Union of India гэх хэрэг нь төрийн бус байгууллагууд нийгмийн ашиг сонирхлын үүднээс нийгмийн эмзэг бүлгийн нэрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг баталгаажуулсан чухал шийдвэр юм. Энэ нь Энэтхэгийн Дээд шүүх үндсэн эрх нь зөрчигдсөн бусдыг төлөөлөх төрийн бус байгууллагын байр суурийг (locus standi) шууд хүлээн зөвшөөрсөн анхны хэргүүдийн нэг байсан.</p> <p>Хэргийн үйл баримтаас үзвэл 1982 онд Дели хотод болсон Азийн спортын наадмын барилга байгууламж барих үеэр ажилчдыг хэт удаан ажиллуулах, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бага мөнгө төлж байсан. PUDR төрийн бус байгууллагаас хөдөлмөрийн хууль тогтоомжийг зөрчиж байгааг илрүүлж, Үндсэн хуулийн 32 дугаар зүйлд заасны дагуу бичгээр өргөдөл гаргасан. Ажилчид өөрсдөө ядуу, бичиг үсэг тайлагдаагүй тул шүүхэд хандах боломжгүй байв.</p> <p>Шүүхээс хэргийг шийдвэрлэхдээ ажилчдын цалинг цалингийн доод хэмжээгээр төлөөгүй нь Үндсэн хуулийн 23 дугаар зүйл буюу хүн худалдаалах, албадан хөдөлмөр эрхлэхийг хориглосон заалтыг зөрчсөн гэж үзсэн. Энэхүү шийдвэр нь Энэтхэг Улсад нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрх бүхий субъектийн ангиллыг өргөжүүлж төрийн бус байгууллага нэхэмжлэл гаргах жишгийг бий болгосон байдаг.</p>

¹²² LegalFly. "Case Summary: S.P. Gupta v. Union of India.", <https://legalfly.in/case-summary-sp-gupta-v-union-of-india/#the-role-of-public-interest-litigation-pil-post-s-p-gupta>, (Сүүлд үзсэн: 2025.10.21).

¹²³ Supreme Court of India. People's Union for Democratic Rights (PUDR) v. Union of India, (1982), <https://indiankanon.org/doc/496663/>, (Сүүлд үзсэн: 2025.10.21).



БНЭУ-ын Үндсэн хуулийн 32 дугаар зүйлд заасан шүүхэд хандах эрхийг урьд өмнө дан ганц субъектив эрх нь зөрчигдсөн этгээдэд хамааруулж байсан бол шүүх шийдвэрээрээ энэхүү хүрээг улам бүр өргөсгөж ирсэн байна. Иймд иргэн болон төрийн бус байгууллагууд шүүхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах жишиг тогтжээ.

3.3. Статистик мэдээ, шүүхийн практик

Өмнөх хэсгүүдэд дурдсанчлан БНЭУ-д нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхтэй олон субъект байх бөгөөд түүнийг дагаад тухайн төрлийн олон тооны хэрэг, маргааныг шүүх шийдвэрлэсэн байна. Тоо баримтаас үзвэл 1985–2019 оны хооронд Энэтхэгийн Дээд шүүх ойролцоогоор 923,277 нийтийн ашиг сонирхолд холбогдох маргаан хүлээн авсан бөгөөд энэ нь жилд дунджаар 26,379 маргааныг Дээд шүүх хүлээн авсан гэсэн үг юм. Түүнчлэн 1985 онд нийтийн ашиг сонирхолд холбогдох 24,823 нэхэмжлэлийг хүлээн авч байсан бол энэ тоо тогтмол өсөж 2019 онд энэ тоо 70,836 болжээ.¹²⁴

Шүүхэд ирүүлж буй нийтийн ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотой нэхэмжлэлийн хамгийн түгээмэл төрлүүдийг жагсаавал:

1. Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөц;
2. Хүний эрх, үндсэн эрхийн зөрчил;
3. Газар, орон сууц, хот байгуулалтын маргаан;
4. Захиргааны болон засаглалын маргаан;
5. Эрүүл мэнд, боловсрол;
6. Хэрэглэгчийн эрх ашиг;
7. Шашин шүтэх эрх чөлөө ба цөөнхийн эрх.¹²⁵

Дээрх тоо, баримтуудаас үзвэл нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах БНЭУ-ын шүүхийн системд томоохон хувийг эзлэх болсон нь жил тусам өсөх нэмэгдсээр байгааг харуулж буй юм.

БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Англо-Саксоны эрх зүйн бүлд багтах АНУ, ИБУИНХУ болон БНЭУ-ын хувьд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхийн тогтолцоо нь тухайн эрх зүйн бүлийн зарчимд тулгуурласан боловч эрх зүйн хэрэгжилтийн хэлбэр, шүүхийн оролцоо, хууль тогтоомжийн нарийвчлалын хувьд тодорхой ялгаатай хөгжсөн байна.

Нийтлэг талаас нь авч үзвэл эдгээр улсуудын хувьд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах нь шүүхийн хяналт, шударга ёсны хэрэгжилт, хүний эрх, хүрээлэн буй орчны хамгааллыг хангах үндсэн арга хэрэгсэл гэж үздэг.

¹²⁴ Gauri Kashyap and Ayushi Saraogi, "On an Average, the Court Receives over 25,000 PILs a Year," *Supreme Court Observer*, July 22, 2021, <https://www.scobserver.in/journal/on-an-average-the-court-receives-over-25000-pils-a-year/>. (Сүүлд үзсэн: 2025.10.22).

¹²⁵ Vidhi Centre for Legal Policy. *The Evolution of Public Interest Litigation in India: A Retrospective Analysis (2000–2023)*. New Delhi: Vidhi Centre for Legal Policy, 2023.



Судалж буй улсуудад нийтийн ашиг сонирхол гэдэг нь "нийгмийн тодорхой хамт олны ашиг сонирхол бөгөөд төрөөс хүлээн зөвшөөрч, хуулиар баталгаажуулах ёстой" хэмээх онолын үндэслэлээр илэрхийлэгддэг байна. Тухайн ашиг сонирхлыг хамгаалахын тулд иргэн, төрийн бус байгууллага, холбоо зэрэг субъект шүүхэд нэхэмжлэл гаргах боломжтой гэж үздэг нь нийтлэг онцлог юм.

Харин тухайн улсуудын ялгаатай тал нь эрх зүйн тогтолцоо, шүүхийн оролцооны цар хүрээгээр илэрдэг байна. АНУ-д нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх нэхэмжлэлийн асуудлыг Үндсэн хууль, холбооны хууль, журам зэргээр нарийвчлан хуульчилсан байдаг бол, ИБУИНХУ-д хууль тогтоомжоос илүүтэйгээр шүүхийн практик, онолын тайлбарт тулгуурладаг байна. БНЭУ-ын хувьд эдгээр хоёр улсын дунд байр суурь эзэлж, Үндсэн хуулийн заалтыг тулгуурлан шүүхийн идэвхтэй тайлбар, практикийг хослуулсан тогтолцоог бүрдүүлжээ.

Ийнхүү эдгээр гурван улс нь Англо-Саксоны эрх зүйн бүлийн нийтийн ашиг сонирхлын төлөө нэхэмжлэл гаргах тогтолцоо нь шүүхийн оролцоонд тулгуурласан, шударга ёсны хүртээмжийг өргөжүүлэх зорилготой нийтлэг шинжтэй боловч хуулийн хэрэгжилтийн хэлбэр, хуулийн нарийвчлал, шүүхийн гүйцэтгэж буй үүрэг, түүний цар хүрээгээрээ ялгаатай байна. АНУ-ын хувьд системтэйгээр хуульчилсан тогтолцоо, ИБУИНХУ-ын хувьд шүүхийн жишиг шийдвэр, онолын тайлбар, БНЭУ-ын хувьд Үндсэн хуулийн зарчим, шүүхийн идэвхтэй тайлбарыг түлхүү баримталж буй нь тус тусын онцлогийг илтгэж байна. Эцэст нь эдгээр улс орнуудын туршлагаас үзэхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах нь төрийн хяналт, нийгмийн шударга ёсыг хангах чухал хэрэгсэл болон төлөвшсөн гэж дүгнэж болох юм.

IV. СОЦИАЛИСТ ЭРХ ЗҮЙН БҮЛИЙН УЛС

1. БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС

1.1. Онолын үндэслэл, эрх зүйн тогтолцоо

БНХАУ-ын нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхийн ойлголт нь барууны улс, орнуудын хэлбэртэй ойролцоо боловч, агуулгын хувьд ялгаатай байдлаар авч үзэх нь зүйтэй. Тодруулбал, БНХАУ-д тухайн асуудлын гол цөм нь нийтийн (ард түмэн, пролетарийн) ашиг сонирхол нь хувь хүний эрх ашгаас илүү байдаг гэсэн марксист-ленинист зарчмууд, Хятадын уламжлалт улс төрийн гүн ухаан, Хятад Улсын онцлог улс төрийн дэглэм буюу социализм¹²⁶ гэх идеологид үндэслэдэг байна.

БНХАУ-ын социалист эрх зүйн тогтолцоо нь нам-төрийн засаглалын ерөнхий зорилгод үйлчлэх зарчимд суурилдаг бөгөөд энэ хүрээнд нийтийн ашиг сонирхол нь шүүхээр тодорхойлогддог төвийг сахисан зүйл биш, харин намын бодлогоор илэрхийлсэн улс төрийн тодорхой зорилгод үндэслэдэг байна. Өөрөөр хэлбэл тус улсад "төр төвтэй тэнцвэрийн зарчим" (англ. state-centric proportionality)-д нийгмийн тогтвортой байдал, бүлгийн ашиг тус, намын удирдлагыг эрхэмлэдэг

¹²⁶ Xi Jinping. "必须坚持人民至上." 中国政府网. https://www.gov.cn/yaowen/liebiao/202403/content_6942668.htm, (Сүүлд үзсэн: 2025.10.22).



Хүснэгт 17. БНХАУ-ын нийтийн ашиг сонирхлыг хамгаалах тухай холбогдох хуулийн зохицуулалт

№	Хуулийн нэр	Хуулийн зохицуулалт
1.	БНХАУ-ын Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль	<p style="text-align: center;">55 дугаар зүйл</p> <p>Хуульд албан ёсоор заасан байгууллага (англ. legally designated institution), төрийн бус байгууллагууд (англ. relevant organizations) байгаль орчныг бохирдуулах, нийт хэрэглэгчдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хохироох зэрэг нийтийн эрх ашгийг хохироосон үйлдлийн эсрэг Ардын шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.</p> <p>Ардын прокурорын байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэх явцдаа экологийн орчин, баялгийг хамгаалахад хохирол учруулсан, хүнсний болон эмийн аюулгүй байдлын чиглэлээр хэрэглэгчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг зөрчсөн үйлдэл, олон нийтийн ашиг сонирхлыг хохироосон бусад үйлдлийг илрүүлсэн тохиолдолд, өмнөх хэсэгт заасан байгууллага байхгүй, шүүхэд нэхэмжлэл гаргаагүй тохиолдолд Ардын шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.</p>
2.	БНХАУ-ын Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль	<p style="text-align: center;">25 дугаар зүйлийн 3 дахь хэсэг</p> <p>Ардын прокурорын газар нь өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэх явцад экологийн орчин, нөөц баялгийг хамгаалах, хүнс, эмийн аюулгүй байдал, төрийн өмчийг хамгаалах, төрийн өмчийн газар ашиглах эрх шилжүүлэх, бусад салбарт хяналт тавих үүрэг бүхий захиргааны байгууллага нь хууль тогтоомж зөрчсөн, эсхүл үл хэрэгссэн, үндэсний болон нийтийн ашиг сонирхолд хохирол учруулсан, эсхүл эрх мэдлээ хэрэгжүүлсэн нь тогтоогдсон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд прокурор зөвлөмж гаргаж, хуульд заасан үүргээ биелүүлэхийг шаардаж болно.</p> <p>Хэрэв захиргааны байгууллага прокурорын сануулсны дагуу хуульд заасан үүргээ биелүүлэхгүй бол Ардын прокурорын газар тухайн асуудлаар Ардын шүүхэд хуулийн дагуу нэхэмжлэл гаргаж болно.</p>

Хуулийн дээрх зохицуулалтаас үзвэл БНХАУ-д нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрх бүхий субъектүүд нь (1) Прокурорын байгууллага, (2) Төрийн бус байгууллага, (3) Хуулиар эрх олгосон байгууллага гэж ойлгож болно. Түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг экологийн орчин, нөөц баялгийг хамгаалах, хүнс, эмийн аюулгүй байдал, төрийн өмчийг хамгаалах, төрийн өмчийн газар ашиглах эрх шилжүүлэх, хэрэглэгчийн эрх гэх хүрээнд тодорхойлжээ.

1.3. Статистик мэдээ, шүүхийн практик

БНХАУ-ын хувьд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхтэй голлох субъект нь Ардын прокурор юм. Тус улсын Ардын прокурорын газар (англ. The Supreme People's Procuratorate of the People's Republic of China, хятад. 中华人民共和国最高人民检察院)-ын 2025 оны Бүх Хятадын Ардын төлөөлөгчдийн



их хуралд танилцуулсан тайланд¹³¹ дурдсанаар 2024 онд нийтийн ашиг сонирхлын асуудлаар 151,000 хэргийг прокурорын байгууллагаас шийдвэрлэсэн бөгөөд сүүлийн 10 жилийн хугацаанд тухайн асуудлаар 1,117,000 хэрэг үүсгэсэн гэдэг. Эдгээр шийдсэн хэргийн хамгийн түгээмэл нь 530,000 гаруй нь экологийн орчин, нөөцийг хамгаалах чиглэлээр, 200,000 гаруй нь хүнс, эмийн аюулгүй байдалтай холбоотой юм¹³². Түүнчлэн тус тайланд дурдсанаар төрийн өмчийн хамгаалалт, газар ашиглах эрх шилжүүлэхтэй холбоотой асуудлаар прокурорын байгууллага шүүхэд нэхэмжлэл гаргадаг байна. Харин хуульд заасан бусад субъектүүд болох төрийн бус байгууллага, хуулиар эрх олгогдсон байгууллагуудын нийтийн ашиг сонирхлыг хамгаалах асуудлаар нэхэмжлэл гаргаж буй талаар нарийн тоо, баримт хараахан олдоогүй болно.

Шигтгээ 9. БНХАУ-ын прокурор нэхэмжлэл гаргасан шүүхийн шийдвэр

БНХАУ-ын Ардын прокурорын нэхэмжлэлтэй Жинлин мужийн Байшан хотын Жянюань дүүргийн эрүүл мэндийн товчоонд холбогдох хэрэг (The Baishan Case)¹³³

Жинлин мужийн Байшан хотын Жянюань дүүргийн эмнэлэг нь цэвэршүүлээгүй бохир усыг гадагшлуулах зөвшөөрөл авалгүйгээр эмнэлэг барьж, 2012 онд үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байна. Мөн тус эмнэлэг байгаль орчны хуулийн зохицуулалтын дагуу бохир ус цэвэрлэх байгууламжийг суурилуулаагүйгээс гүний ус болон ойр орчмын хөрсийг бохирдуулсан байна. 2014 онд төслийг хүчингүй болгох үеэр тус эмнэлгийн байгаль орчныг хамгаалах газраас зөрчлийг илрүүлж, эмнэлгийг хууль тогтоомжид нийцүүлэн торгууль төлөхийг үүрэг болгосон. Төрийн өмчит эмнэлгийг засан сайжруулах арга хэмжээ авахад төрөөс санхүүжилт байхгүй гэсэн шалтгаанаар хууль бусаар эмнэлгээс бохир ус гадагшилсаар байв. Мөн орон нутгийн эрүүл мэндийн байгууллага нь хүрээлэн буй орчны шаардлагад нийцсэн гэрчилгээгүйгээр эмнэлгийн үйл ажиллагааны зөвшөөрлийг сунгасан байна.

2015 оны 11 дүгээр сард Байшан хотын прокурорын газраас орон нутгийн эрүүл мэндийн товчоонд хууль бусаар бохир ус гадагшлуулах үйлдлийг таслан зогсоох арга хэмжээ авахыг зөвлөсөн зөвлөмж хүргүүлсэн. Эрүүл мэндийн товчоо эмнэлгийг засан сайжруулах арга хэмжээ авахыг тушаасан боловч хууль бусаар эмнэлгээс бохир ус гарсаар нийтийн эрүүл мэндэд ноцтой эрсдэл учруулсан хэвээр байв. Прокурорын газраас Байшаны Ардын шүүхэд эрүүл мэндийн товчооны эсрэг нийтийн ашиг сонирхлын үүднээс захиргааны нэхэмжлэлийг эмнэлгийн эсрэг гаргасан. 2016 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн шүүх хуралдаанаар Эрүүл мэндийн товчоо хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй гэж үзэж, 3 сарын дотор бохир ус цэвэрлэх байгууламж суурилуулах ажилд хяналт тавьж ажиллахыг даалгасан. Шүүх тус эмнэлгийг хууль бусаар бохир ус гаргахыг зогсоохыг даалгасан.

Шүүхийн шийдвэрийн дагуу орон нутгийн засаг захиргаанаас 900 мянган юань гаргаж, тус эмнэлэгт бохир ус цэвэршүүлэх төхөөрөмж худалдан авч суурилуулжээ.

¹³¹ Ying, Y. (2025, March 15). 最高人民法院工作报告 [Supreme People's Procuratorate work report]. Supreme People's Procuratorate of the People's Republic of China, https://www.spp.gov.cn/spp/gzbg/202503/t20250315_690544.shtml, (Сүүлд үзсэн: 2025.10.20).

¹³² Chinese procuratorates handle 190,000 public interest litigation cases in 2023, (2024, February 29). Supreme People's Procuratorate of the People's Republic of China. Retrieved from https://en.spp.gov.cn/2024-02/29/c_966137.htm, (Сүүлд үзсэн: 2025.10.20).

¹³³ Han, Su Lin. Background Memorandum: Public Interest Litigation in China. Paul Tsai China Center, Yale Law School, June 2017, https://law.yale.edu/sites/default/files/area/center/china/document/public_interest_litigation_china_background_memo.pdf, (Сүүлд үзсэн: 2025.10.20).



Шигтгээ 9-д БНХАУ-д нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгийн их нэхэмжлэл гаргадаг субъект болох Ардын прокурорын байгууллагын шүүхээр шийдвэрлүүлсэн хэргийн жишээг харуулжээ. Тухайн жишээнээс үзвэл БНХАУ-д прокурорын байгууллага нь нийтийн ашиг сонирхлыг аливаа нэг байгууллага зөрчсөн бол тухайн асуудлаар зөвлөмж гаргаж, түүнийг биелүүлээгүй бол шүүхээр шийдвэрлүүлэх өргөн эрх мэдэлтэй байгаа юм.

Шигтгээ 10. БНХАУ-ын төрийн бус байгууллагын нэхэмжлэл гаргасан шүүхийн шийдвэр

"Байгаль хамгаалах нөхөрлөл" болон "Ногоон хөгжил сан" төрийн бус байгууллагын нэхэмжлэлтэй нэр бүхий химийн үйлдвэрт холбогдох хэрэг (The Changzhou Poisoned Land Case)¹³⁴

2015–2016 оны хооронд шинээр баригдсан Хятадын нэг сургуульд 500 гаруй сурагч өвчилсөн бөгөөд уг сургууль өмнө нь гурван томоохон химийн үйлдвэрийн эзэмшилд байсан, одоо хотын захиргааны мэдэлд шилжсэн талбайн хажууд байрладаг байв. Сурагчдад агаарт химийн бодисын үнэр үнэртэж, арьсны тууралт, толгой өвдөх зэрэг шинж тэмдгүүд илэрч байгаа талаар урьд нь гомдол мэдүүлж байсан. Уг талбайг орон нутгийн засаг захиргаа цэвэрлэж, нөхөн сэргээх ажил хийж байв. Эцэг эхчүүдийн гомдлын дагуу орон нутгийн засаг захиргаа болон төв засгийн газрын хэд хэдэн байгууллага, түүний дотор Байгаль орчны яам, хамтран шалгалт хийж, орчны байдал сурагчдад аюулгүй гэх дүгнэлтэд хүрсэн.

2016 оны 12 дугаар сард "Байгаль хамгаалах нөхөрлөл" болон "Ногоон хөгжил сан" нэртэй хоёр төрийн бус байгууллага нь Чанжөү хотын дунд шатны Ардын шүүхэд байгаль орчны олон нийтийн ашиг сонирхлын нэхэмжлэл гаргаж, химийн үйлдвэрүүдийг бохирдсон газрыг нөхөн сэргээх эсвэл нөхөн сэргээлтийн зардлыг төлөхийг шаардав. Мөн шүүхээс нийт нэхэмжлэлийн дүнгийн 0.5%-тай тэнцэх хэмжээний шүүхийн зардал болох 1.89 сая юанийг хариуцагчаар төлүүлэхийг хүссэн. Нийт нэхэмжлэлийн дүн нь 370 сая юань байв.

2017 оны 01 дүгээр сард шүүх нэхэмжлэгчдийн нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, орон нутгийн засаг захиргаанд бохирдсон газрыг цэвэрлэх, нөхөн сэргээх ажлыг үргэлжлүүлэхийг ёстой гэж хэргийг шийдвэрлэсэн. Шүүх шийдвэр гаргахдаа тухайн газрыг орон нутгийн засаг захиргаа "буцаан авсан" бөгөөд нөхөн сэргээлтийн ажлыг эхлүүлж, газрыг дахин хөгжүүлэхээр төлөвлөсөн тул нөхөн сэргээлтийн хариуцлага нь захиргааны байгууллагад ногдох ёстой гэж үзжээ. Мөн шүүх хариуцагч нараас нэхэмжлэгчийн гаргасан шүүхийн хураамжийг төлүүлэхээс татгалзсан байна.

Шигтгээ 10-т БНХАУ-д нийтийн ашиг сонирхлыг хамгаалан нэхэмжлэл гаргах эрх бүхий төрийн бус байгууллага шүүхэд нэхэмжлэл гаргаж, шийдвэрлүүлсэн хэргийн жишээг харуулжээ. Тухайн улсад төрийн бус байгууллага нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах тохиолдол байгаа гэдэг нь дээрх жишээнээс харагдаж байна. Гэхдээ Хятад Улсад төрийн бус байгууллага нь хуульд зааснаар төр, нийтийн эрх ашгийг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхтэй боловч практикт тун хязгаарлагдмал түвшинтэй байдаг ажээ.

¹³⁴ *Ibid.*



БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Социалист эрх зүйн тогтолцоонд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах тогтолцоо нь төрийн удирдлага, намын бодлого, нийгмийн тогтвортой байдлыг хангах зорилго бүхий институтийн нэг хэлбэрээр хөгждөг байна. Энэхүү тогтолцоонд нийтийн ашиг сонирхол нь хувь хүний эрх ашиг, хувийн эрх зүйн харилцаанаас дээгүүр тавигддаг бөгөөд энэ нь марксист-ленинист үзэл санаанд тулгуурласан нийгмийн нийтлэг зорилго, хамтын ашиг сонирхлыг дээдлэх зарчмаар илэрхийлэгддэг ажээ.

Энэхүү үзэл баримтлалын дагуу нийтийн ашиг сонирхлыг хамгаалах ажиллагаа нь шүүхийн бие даасан байдлаар бус, харин төрийн бодлого, намын хяналтад суурилсан бүтэц дотор хэрэгждэг. Прокурорын байгууллага, төрийн бус байгууллага, эсвэл хуулиар эрх олгосон этгээд зэрэг субъектүүд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхтэй байж болох ч тэдний үйл ажиллагаа нь нийгмийн нийтлэг зорилготой нийцэх, төрийн бодлогод харшлахгүй байх хүрээгээр хязгаарлагддаг байна. Судалгааны хүрээнд сонгон авсан социалист эрх зүйн төлөөлөл болох БНХАУ-ын эрх зүйн орчин нь дээрх онол, үзэл баримтлалтай бүрэн нийцэж байгаа юм.

Үүнээс дүгнэхэд, социалист эрх зүйн тогтолцоонд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах институт нь барууны ардчилсан орнуудын иргэний нийгэмд тулгуурласан хэлбэрээс ялгаатай, төр төвтэй, улс төрийн зорилго бүхий шинжийг агуулдаг. Энэ тогтолцоо нь нийгмийн нийтлэг ашиг сонирхлыг дээдлэн хамгаалахыг эрхэмлэж, төрийн хяналт, удирдлагын нөлөөг эрх зүйн тогтолцооны салшгүй хэсэг болгон хадгалдаг онцлогтой юм.

V. ДҮГНЭЛТ

Судалгааны багийн зүгээс АНУ, Франц Улс, БНХАУ, ИБУИНХУ, ХБНГУ, Япон Улс, БНЭУ, Португал Улс, Испанийн Хаант Улс гэсэн 9 улсын нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхийн онол, нэхэмжлэл гаргах эрх бүхий субъект, шүүхийн практикийг судаллаа. Тухайн улсуудыг авч үзвэл, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрх нь улс орнуудын эрх зүйн уламжлал, улс төрийн тогтолцоо, нийгмийн үнэт зүйлээс хамааран харилцан адилгүй хөгжсөн байна. Зарим улс оронд энэхүү эрх нь Үндсэн хууль болон салбарын хуулиар нарийвчлан зохицуулагдаж, иргэд, холбоо, төрийн байгууллага, прокурор зэрэг олон төрлийн субъектэд олгогдсон байдаг бол зарим улсад зөвхөн өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдолд нэхэмжлэл гаргахыг зөвшөөрдөг уламжлалт хандлага давамгайлдаг ажээ.

Харин төр төвтэй тогтолцоотой улсуудын хувьд нийтийн ашиг сонирхлыг хамгаалах ажиллагаа ихэвчлэн төрийн байгууллагаар дамжин хэрэгждэг бол, иргэний нийгэм төлөвшсөн орнуудад төрийн бус байгууллага болон иргэдийн оролцоо илүү өргөн хүрээтэй байгаа юм.



1. Эх газрын эрх зүйн бүлд хамаарах улсуудын хувьд:

1.1. *Франц Улсын тухайд* "нийтийн ашиг сонирхол" нь төрийн үйл ажиллагааны зорилго, хязгаар, хууль ёсны шалгуурын үндсэн хэмжүүр болон төлөвшсөн бөгөөд энэ ойлголт нь Францын эрх зүйн тогтолцооны бүхэл бүтэн философийг илэрхийлдэг байна. Тухайн улсын захиргааны хууль, тогтоомжуудад нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах тухай зохицуулалтыг тусгайлан тодорхой заагаагүй хэдий ч, захиргааны шүүхийн практик, онолын тайлбараар өргөжиж байна. Түүнчлэн Байгаль орчны хуулиар тодорхой шаардлага хангасан, байгаль орчныг хамгаалах зорилготой холбоо, төрийн бус байгууллагад нэхэмжлэл гаргах эрхийг олгосон нь нийтийн ашиг сонирхлыг хамгаалах хүрээг салбарын түвшинд баталгаажуулсан жишээ гэж үзэж болно.

Франц Улсад нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг бүлгийн ашиг сонирхлын нэхэмжлэлийн хэлбэрээр институтын түвшинд хэрэгжүүлэх зохицуулалт болгон хөгжүүлжээ. Бүлгийн ашиг сонирхлын нэхэмжлэл гаргах холбоод нь зөвхөн гишүүдийнхээ шууд эрх ашгийг хамгаалахаас гадна, өөрийн дүрэмд хамгаалах гэж буй ашиг сонирхлын хүрээг тодорхой заасан байх шаардлагыг хангасан байх ёстой. Энэ зохицуулалт нь нэхэмжлэл гаргах ашиг сонирхлыг илүү өргөн хүрээнд хэсэг бүлгийн хязгаарлагдмал ашиг бус, нийтийн шинжтэй эрх ашиг хамгаалах зорилгоор хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлж байна гэж үзэж болох юм.

1.2. *ХБНГУ-ын тухайд* субъектив эрхийн хамгаалалтын зарчим үйлчилдэг тухайн улсад хувь хүний субъектив эрх зөрчигдсэн гэж үзвэл шүүхэд хандах нь нээлттэй гэж үздэг байна. Гэхдээ субъектив эрх нь хөндөгдөөгүй ч гэсэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн захиргааны шүүхэд нэхэмжлэл гаргах тохиолдолд дээрх зарчмаас хазайхыг зөвшөөрдөг байна. Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхийг хуульд заасан шалгуур хангасан холбоо эдлэх бөгөөд уг эрхийг салбарын хуулиудад тусгайлан заадаг. Тус холбоо нь нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн байгаль орчны асуудлаар мөн амьтны эрхийг хамгаалах асуудлаар захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах боломжтой байна.

1.3. *Португал Улсын тухайд* нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхийг Үндсэн хууль, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх хууль болон бусад салбар хуулиудад зохицуулжээ. Мөн түүнчлэн, Үндсэн хуульд заасан нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхийг хэрэгжүүлэх хүрээнд 1995 онд Шийдвэр гаргах ажиллагаа болон нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах хуулийг баталж, нарийвчлан зохицуулснаараа онцлог байна.

Тус улсад нийгэм болон улс төрийн эрхээ эдэлж буй иргэд, тухайн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор байгуулагдсан холбоо, сан, орон нутгийн захиргааны байгууллага, прокурорын байгууллагад нийтийн ашиг сонирхлыг төлөөлж нэхэмжлэл гаргах эрхийг хуулиар олгожээ. Нийгмийн ашиг сонирхол гэдэгт нийтийн эрүүл мэнд, байгаль орчин, хэрэглэгчийн эрх, соёлын өв, улсын болон орон нутгийн өмчийг хамруулсан байна. Түүнчлэн, шүүхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлж нэхэмжлэл гаргасан бол нэхэмжлэлийн төрлийн хувьд



иргэний эсхүл захиргааны журмаар шийдвэрлэгддэг бөгөөд ямар нийтийн ашиг сонирхлыг хамгаалж байгаагаасаа хамаараад хуулийн хэрэгжилт харилцан адилгүй байгааг судлаачид дурджээ.

1.4. Испани Улсын тухайд нийтийн эрх ашгийг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг тус улсад хүлээн зөвшөөрдөг ба дотоодын хууль тогтоомжоор энэ эрхийг баталгаажуулсан байна. Харин нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхийг хуульчлахдаа салбарын тухайлсан хуулиар харилцан адилгүй байдлаар зохицуулжээ.

Тус улсын шүүхийн практикийг судалж үзэхэд, нийтийн эрх ашгийг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрх нь зөвхөн захиргааны шүүхийн хяналтын хүрээнд бус иргэн, эрүүгийн хэргийн болон Үндсэн хуулийн шүүхийн хяналтад мөн хамаарахаар байна. Тодруулбал, шүүхийн практикт дийлэнх тохиолдолд нийтийн эрх ашгийг төлөөлөн эрүүгийн хэргийн шүүхэд хандсан байх бөгөөд захиргааны хэргийн шүүхийн хувьд ихэвчлэн субъектив эрх /эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн хувь хүн, байгууллага/-ийн асуудлаар маргасан ба нийтийн эрх ашгийг төлөөлж нэхэмжлэл гаргасан тохиолдол бусад нийт хэрэгтэй харьцуулахад цөөн байгаа юм.

1.5. Япон Улсын тухайд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах эрх нээлттэй биш бөгөөд зөвхөн өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдолд нэхэмжлэл гаргах зарчимтай тул нэхэмжлэл гаргах үед тухайн зөрчигдсөн гэж үзэж буй ашиг сонирхол нь нэхэмжлэгчийн өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хамаарна гэж үзэхэд хүндрэлтэй байсаар байна. Түүнчлэн шүүхийн практикт ч мөн адил дээрх зарчмыг баримтлан маргааныг шийдвэрлэдэг жишиг тогтжээ. Тиймээс уг асуудлыг хуульчлах замаар шийдвэрлэх нь зүйтэй гэдэг дээр ихэнх судлаач санал нэгддэг байна.

2. Англо-Саксоны эрх зүйн бүлд хамаарах улсуудын хувьд:

2.1. АНУ-ын тухайд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх, шүүхэд нэхэмжлэл гаргах зохицуулалтыг бий болгосон анхдагч улсуудын нэг юм. Тус улсын хувьд нийтийн ашиг сонирхлыг төр өөрийн зохицуулалтаар буюу эрх зүйн харилцаагаар дамжуулан хамгаалах шаардлагатай гэж үзэх бөгөөд үүний нэг хэлбэр нь нийтийн эрх ашгийг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргаж түүнийг шүүхээр хянан шийдвэрлэж буй байдал гэж онолын хувьд үздэг. Тиймдээ ч шүүхэд нэхэмжлэл гаргах тодорхой хүрээ хязгаар, төрөл, салбарыг тухайлан хуульчлаагүй ч Үндсэн хууль болон бусад хуульд заасан эрхийн хүрээнд иргэн, төрийн бус байгууллага мөн төрийн байгууллага, Ерөнхий прокурор шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй байна.

2.2. ИБУИНХУ-ын тухайд нийтийн эрх ашгийг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах асуудлаар нарийвчилсан хуулийн зохицуулалтаас илүүтэйгээр шүүхийн жишиг болоод онолын үзэл баримтлалыг голчлон үндэслэдэг гэж дүгнэж болохоор байна. Ингэхдээ нэхэмжлэл гаргаж буй этгээд тухайн маргаж буй асуудлаараа шүүхэд хандах эрхтэй эсэх, цаашлаад тийнхүү хандаж буй үндэслэлийн талаар шүүхээс тохиолдол бүрд нарийн тодорхойлдог ажээ.



2.3. *БНЭУ-ын тухайд* Үндсэн хуулийнхаа 32 дугаар зүйл дээр тулгуурлан 1970-аад оны онц байдлын дараах нийгмийн сэргэлтийн үед нийтийн ашиг сонирхлыг хамгаалах тухай зарчмыг тус улсын шүүх институтээс уламжлалт ойлголтыг өөрчилж, нийтийн ашиг сонирхлыг хамгаалахын тулд төрийн бус байгууллага, иргэд, холбоо зэрэг олон субъектийн оролцоог зөвшөөрчээ. Цаашлаад уг зарчмыг салбар эрх зүйн нарийвчилсан хуулиар зохицуулжээ. Үүний үр дүнд тус улсын шүүхийн системд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргаж буй маргаан нь жил ирэх тусам өссөн үзүүлэлттэй байна.

3. Социалист эрх зүйн бүлд хамаарах улсын хувьд:

3.1. *БНХАУ-ын тухайд* нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах тогтолцоо нь социалист эрх зүйн тогтолцооны онцлог, нам-төрийн бодлоготой нягт уялдсан институтийн хэлбэрээр төлөвшсөн байна. Тус улсад нийтийн ашиг сонирхол нь хувь хүний эрх ашгаас дээгүүр тавигддаг бөгөөд энэ нь марксист-ленинист үзэл санаа, Хятадын онцлогтой социализмын идеологид үндэслэсэн төр төвтэй эрх зүйн үзэл баримтлал юм.

БНХАУ-ын эрх зүйн орчинд Ардын прокурорын байгууллага нийтийн ашиг сонирхлын төлөө нэхэмжлэл гаргах голлох субъект бөгөөд байгаль орчныг хамгаалах, хүнсний болон эмийн аюулгүй байдал, төрийн өмчийн хамгаалалт зэрэг салбарт төвлөрдөг. Энэ нь төрийн хяналт, нийгмийн тогтвортой байдлыг хангах зорилго бүхий эрх зүйн хэрэгсэл болж, төрийн бодлогын хэрэгжилтийг шүүхийн шатанд баталгаажуулах үүрэгтэй гэж үзэж болно. Харин төрийн бус байгууллага болон хуульд заасан бусад субъектүүдийн оролцоо хязгаарлагдмал бөгөөд тэдгээрийн нэхэмжлэл нь төрийн бодлоготой нийцэх хүрээнд л хүлээн зөвшөөрөгддөг байна. Өөрөөр хэлбэл, Хятад Улсад нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах тогтолцоо нь барууны орнуудын иргэний нийгэмд тулгуурласан загвараас ялгаатайгаар төрийн хяналттай, улс төрийн зорилго бүхий шинжийг агуулдаг байна.

НОМ ЗҮЙ

1. Монгол хэл дээрх эх сурвалж:

1. Хууль зүйн үндэсний хүрээлэн, *"Нийтийн эрх ашгийг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах эрх"* Судалгааны тайлан, 2013 он.
2. Г.Банзрагч, *"Герман-Монголын захиргааны процессын эрх зүйн харьцуулалт"*, 2017 он.
3. С.Сүхчулуун, *"Байгаль орчин болон соёлын өвийг хамгаалах асуудлаар төрийн бус байгууллагад нэхэмжлэл гаргах эрхийг олгохтой холбоотой Япон Улсын өнөөгийн чиг хандлага"*, судалгаа, 2022 он.

2. Гадаад хэл дээрх эх сурвалж:

А. Англи хэл дээрх эх сурвалж

1. U.S. Constitution 1787.
2. United States Code, U.S.C. 2018.



3. Federal Rules of Civil Procedure 1938.
4. U.S. Administrative procedure act 1946.
5. Clean Water Act 1972.
6. Friends of the Earth v. Laidlaw Environmental Services (2000).
7. Constitution of the Portuguese Republic (1976).
8. Administrative Procedure Law of the People's Republic of China (Amended in 2017), 1989.
9. Civil Procedure Law of the People's Republic of China, (Revised in 2017), 1991.
10. Government of India, *Constitution of India* 1949.
11. Government of India. *The Environment (Protection) Act*, 1986.
12. Government of India. *The Consumer Protection Act*, 2019.
13. United Kingdom, Senior Courts Act, 1981.
14. Japanese Administrative Procedure Act, 1962.
15. United Nations Economic Commission for Europe (UNECE). *Text of the Convention: Convention on Access to Information, Public Participation in Decision-making and Access to Justice in Environmental Matters (Aarhus Convention)*, 1988.
16. Tetiana Evgeniivna Kaganovska, "Public interest as a category of administrative and legal science, 2022.
17. Bryan A. Garner (ed), *Black's Law Dictionary* 7th ed, Minnesota: West Publishing, 1979.
18. Steven H. Gifis, *Law Dictionary*, 4th ed, New York: Barron's Educational Services, 1996.
19. Charles F Sabel and William H Simon, "Destabilization Rights: How Public Law Litigation Succeeds" *Harvard Law Review*, 2004.
20. *The Administrative Court Judicial Review Guide* 2024.
21. The Public Law Project, *Third Party Interventions-a practical guide*, 2008.
22. Shubha Sinha "International P.I.L in the USA: Socio-Legal contextualization", *Journal of Education and Science Research Review*, Volume 4, Issue.
23. *United States v. EME Homer City Generation, L.P.*, 727 F.3d 274 (3d Cir. 2013).
24. Alexandra Aragao and Ana Celeste Carvalho, "Taking access to justice seriously: diffuse interests and actio popularis. Why not?", *Elni Review*, no2 (2017).
25. Leonor Rossi and Miguel Sousa Ferro, "Private enforcement of Competition law in Portugal (II): Actio Popularis – Facts, fictions and dreams".
26. "The Role of the Indian Judiciary in Enforcing Human Rights: Constitutional Safeguards, Judicial Interpretation, and Mechanisms for Accountability in a Complex Legal Landscape," *International Journal of Creative Research Thoughts* 11, no. 4 (2025).
27. Anuj Bhuwania, *Courting the People: Public Interest Litigation in Post-Emergency India* (Oxford: Oxford University Press, 2017).
28. Chinese procuratorates handle 190,000 public interest litigation cases in 2023, (2024, February 29). *Supreme People's Procuratorate of the People's Republic of China*.



29. Gauri Kashyap and Ayushi Saraogi, "On an Average, the Court Receives over 25,000 PILs a Year," *Supreme Court Observer*, July 22, 2021.
30. Han, Su Lin. *Background Memorandum: Public Interest Litigation in China*. Paul Tsai China Center, Yale Law School, June 2017.
31. LegalFly. "Case Summary: S.P. Gupta v. Union of India".
32. Supreme Court of India. *People's Union for Democratic Rights (PUDR) v. Union of India*, (1982).
33. Xiao, Shiling. "State-Centric Proportionality Analysis in Chinese Administrative Litigation." *International Journal of Constitutional Law* 21, no. 2 (April 2023).
34. Jason Varuhas, University of Cambridge Faculty of Law, *The Public Interest Conception of Public Law: Its Procedural Origins and Substantive Implications*, 61/2014, 2014.
35. Kuniko Shibata, *The public interest in planning in Japanese jurisprudence: the limits to participatory democracy*, 2008.
36. Jayanth Kumar Krishnan, "Public Interest Litigation in a Comparative Context" (2011), William Mitchell College of Law.
37. Vidhi Centre for Legal Policy. *The Evolution of Public Interest Litigation in India: A Retrospective Analysis (2000–2023)*. New Delhi: Vidhi Centre for Legal Policy, 2023.

Б. Франц хэл дээрх эх сурвалж

1. A&O Shearman. "Réforme des actions de groupe : ce que change la loi du 30 avril 2025" (2025).
2. Bourdon, Philippe. "Jurisprudence : L'intérêt pour agir d'une association 'nationale' contre une décision 'locale'" (2015).
3. Chevalier, Émilie. "Standing before French Administrative Courts and Environmental Protection: Not Specific Enough for an Effective Access to Justice?" (2020).
4. Couvreur, Sébastien. "Réflexions sur la notion d'intérêt à agir devant les juridictions administratives" (2017).
5. *Décisions de justice (Recueil Lebon)*. "Syndicat des propriétaires et contribuables du quartier Croix de Seguey Tivoli (21 décembre 1906, n° 19167)". "Dépakine :
6. Sanofi condamné à indemniser une famille dont la fille est née avec des malformations" (2022).
7. Hauriou, Maurice. "Droits des habitants d'un quartier vis-à-vis un service public concédé et recevabilité d'un recours pour excès de pouvoir formé par un syndicat de quartier" (2013).
8. Le Club des juristes. "Affaire de la Dépakine : quelle est la responsabilité de l'État?" (2025).
9. Merland, Guillaume. "L'intérêt général, instrument efficace de protection des droits fondamentaux ?" *Cahiers du Conseil constitutionnel*, 16 (2004).
10. Sénat – Rapports officiels, "Des contrôles de légalité et budgétaire annoncés prioritaires : comment passer de la parole aux actes (Rapport d'information n° 843 2024–2025). (2024).



В. Португал хэл дээрх эх сурвалж

1. Lei n.º 19/2012, Өрсөлдөөний хууль, 2012 он.
2. Lei n.º 15/2002, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх хууль, 2002 он.
3. Lei n.º 41/2013, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх хууль, 2013 он.
4. Lei n.º 83/95, Шийдвэр гаргах ажиллагаа болон нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах хууль, 1995 он.
5. Lei n.º 19/2014, Байгаль орчны хууль, 2014 он.
6. Lei n.º 24/96, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль, 1996 он.
7. Lei n.º 107/2001, Соёлын өвийн хууль, 2001 он.
8. Lei n.º 486/99, Үнэт цаасны хууль, 1999 он.
9. Tribunal da Relação do Porto, Acórdão № 6030/21.1T8PRT.P1, (2023).
10. Supremo Tribunal de Justiça, Acórdão № 33/23.9T8PDL.L1.S1, (2024).

Г. Хятад хэл дээрх эх сурвалж

1. Ying, Y. (2025, March 15). 最高人民法院工作报告 [Supreme People's Procuratorate work report]. Supreme People's Procuratorate of the People's Republic of China.
2. Xi Jinping. "必须坚持人民至上." 中国政府网.

Д. Герман хэл дээрх эх сурвалж

1. Grundgesetz für die Bundesrepublik Deutschland, 1949.
2. Verwaltungsgerichtsordnung (VwGO), 1960.
3. Umwelt-Rechtsbehelfsgesetz, 2006.
4. Die Aarhus - Konvention, 1998.
5. Tierschutzgesetz, 1972.
6. Annette Guckelberger: *Allgemeines Verwaltungsrecht mit Verwaltungsprozessrecht und Staatshaftungsrecht*, 2023,
7. Eleftherios Dikaios, Überindividueller Umweltrechtsschutz am Beispiel der altruistischen Verbandsklage in der deutschen, griechischen und europäischen Rechtsordnung, Teilband I, 2018.
8. Hendrik Stephan Ley, Das Instrument der Tierschutz-Verbandsklage Hintergründe, theoretische Grundlagen und praktische Umsetzung, 2018.
9. Fachagentur Windenergie und Land, Klagemöglichkeiten nach dem Umwelt-Rechtsbehelfsgesetz (UmwRG), 2017.
10. Michael Kloepfer und Hans-Georg Kluge, Die tierschutzrechtliche Verbandsklage, 2017.
11. Black's Law Dictionary.

Е. Испани хэл дээрх эх сурвалж

1. Constitución Española, 1978.
2. por la que se regula el Estatuto Orgánico del Ministerio Fiscal, 1982.
3. reguladora de la Jurisdicción Contencioso-administrativa, 1998.
4. por la que se regulan los derechos de acceso a la información, de participación pública y de acceso a la justicia en materia de medio ambiente, 2006.



5. STS 5708/2023 – ECLI:ES:TS:2023:5708.
6. Ucín, María Carlota, "Litigio de interés público", September 2017.
7. Conceptos Enciclopédicos.
8. Enciclopedia jurídica.
9. Javier Graña Gianoni, Las demandas estratégicas contra la participación pública (SLAPP): El desafío del abuso de los sistemas judiciales y avances de la normativa anti SLAPP, November 2024.
10. Испани улсын хууль зүйн толь бичиг.

Ё. Солонгос хэл дээрх эх сурвалж

1. 박균성, "프랑스 행정법상 공익개념", 서울대학교 법학 (2006).

3. Цахим эх сурвалж:

1. Хууль зүйн судалгааны бүтээлийн цахим сан: <https://legaldata.mn/>.
2. АНУ-ын Шүүхийн цахим хуудас: <https://www.uscourts.gov/>.
3. Франц Улсын Үндсэн хуулийн зөвлөлийн цахим хуудас: <https://www.conseil-constitutionnel.fr>.
4. БНСУ-ын судалгаа цахим хуудас: <https://www.kci.go.kr>.
5. Франц Улсын "Intérêt à Agir" байгууллагын цахим хуудас: <https://www.interetaagir.org/linteret-a-agir-des-associations-par-le-contentieux/>.
6. Франц Улсын "Revue Générale du Droit" цахим сэтгүүлийн хуудас: <https://www.revuegeneraledudroit.eu>.
7. "Krieger & Associés" хууль зүйн фирмийн цахим хуудас: <https://www.krieger-avocats.lu>.
8. Франц Улсын хууль тогтоомжийн нэгдсэн цахим систем "Legifrance": <https://www.legifrance.gouv.fr>.
9. Франц Улсын Сенатын албан ёсны цахим хуудас: <https://www.senat.fr>.
10. Франц Улсын өдөр тутмын сонин "Le Monde"-ийн цахим хуудас: <https://www.lemonde.fr>.
11. Франц Улсын хууль, бодлогын судалгааны сэтгүүл "Le Club des juristes"-ийн цахим хуудас: <https://www.leclubdesjuristes.com>.
12. Франц Улсын Захиргааны дээд шүүхийн (Conseil d'État) цахим хуудас: <https://www.conseil-etat.fr>.
13. Франц Улсын хуулийн сэтгүүл "Lexbase"-ийн цахим хуудас: <https://www.lexbase.fr>.
14. Франц Улсын хууль, эдийн засаг, бизнесийн зөвлөх фирм "A&O Shearman"-ийн цахим хуудас: <https://www.aoshearman.com>.
15. Португал Улсын шүүхийн эрх зүйн мэдээллийн цахим сан: <https://diariodarepublica.pt/dr/home>.
16. Оксфорд академик цахим хуудас: <https://academic.oup.com/>.
17. Йэлийн их сургуулийн цахим хуудас: <https://law.yale.edu/>.
18. Австрали Улсын аж үйлдвэр, шинжлэх ухаан, нөөцийн яамны цахим хуудас: <https://www.industry.gov.au/>.



19. Энэтхэг Улсын эрдэм шинжилгээний бүтээлийн цахим хуудас: <https://ijcrt.org/>.
20. Энэтхэг Улсын парламентын цахим хуудас: <https://legislative.gov.in/>.
21. Энэтхэг Улсын Indian Code цахим хуудас: <https://www.indiacode.nic.in/>.
22. Энэтхэг Улсын Legal Fly цахим хуудас: <https://legalfly.in/>.
23. Энэтхэг Улсын Indiankanoon блог: <https://indiankanoon.org/>.
24. Энэтхэг Улсын Дээд шүүхийн мэдээллийн цахим хуудас-<https://www.scobserver.in/>.
25. Оксфордын их сургуулийн номын сангийн цахим хуудас: <https://libguides.bodleian.ox.ac.uk>.
26. ИБУИНХУ-ын хууль, тогтоомжийн нэгдсэн цахим хуудас: <https://www.legislation.gov.uk>.
27. ИБУИНХУ-ын Шүүхийн нэгдсэн цахим хуудас: <https://www.justice.gov.uk>.
28. Цахим номын сан: <https://papers.ssrn.com>.
29. ИБУИНХУ-ын Нийтийн эрх зүйн эрх ашгийг хамгаалах байгууллагын цахим хуудас: <https://publiclawproject.org.uk>.
30. ХБНГУ-ын эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан: <https://www.gesetze-im-internet.de/aktuell.html>.
31. Испани улсын төрийн албан ёсны мэдээллийн эмхэтгэл: <https://boe.es/>.
32. Испани улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн цахим хуудас: <https://www.poderjudicial.es/cgpj/>.
33. Испани улсын хууль зүйн толь бичиг: <https://dpej.rae.es/>.
34. Блэйкийн хууль зүйн нэвтэрхий толь: <https://thelawdictionary.org/>.
35. Испани улсын "Conceptos" нэвтэрхий толь: <https://conceptos.es/>.
36. "Enciclopedia" хууль зүйн нэвтэрхий толь: <http://www.encyclopedia-juridica.com/>.
37. "ResearchGate" судалгааны цахим сан: <https://www.researchgate.net/>.
38. La Plata их сургуулийн цахим хуудас: <https://sedici.unlp.edu.ar/>.
39. БНХАУ-ын Олон Улсын худалдааны шүүхийн цахим хуудас: <https://cicc.court.gov.cn/html/1/219/index.html>.
40. БНХАУ-ын Ардын Дээд Прокурорын газрын цахим хуудас: <https://en.spp.gov.cn/>.
41. БНХАУ-ын Засгийн газрын цахим хуудас: <https://www.gov.cn/>.